

**МОНГОЛ УЛС**  
**Шинжлэх Ухааны Академи**  
**Ботаникийн хүрээлэн**



**“СҮХБААТАР АЙМГИЙН АШИГТ**  
**УРГАМЛЫН ТАРХАЦ-НӨӨЦ” ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨСӨЛТ**  
**АЖЛЫН ТАЙЛАН**

**Улаанбаатар хот**  
**2014 он**

**МОНГОЛ УЛС**  
**Шинжлэх Ухааны Академи**  
**Ботаникийн хүрээлэн**

**“СҮХБААТАР АЙМГИЙН АШИГТ УРГАМЛЫН ТАРХАЦ-НӨӨЦ”**  
**(Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газрын Байгаль орчны хэлтсийн**  
**захиалгаар гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын тайлан)**

**Захиалагч:** Байгаль Орчин, Ногоон Хөгжлийн Яам,  
Сүхбаатар аймгийн БОГазар

**Удирдагч:** Чүлтэмийн ДУГАРЖАВ. Ботаникийн  
хүрээлэнгийн захирал, академич, доктор (Sc.D),  
профессор

**Гүйцэтгэгч:** Магсарын УРГАМАЛ. Ургамлын ангилалзүйн  
салбарын эрдэм шинжилгээний ажилтан, Биологийн  
ухааны доктор(Ph.D).

Батцэрэнгийн МӨНХЖАРГАЛ. Ботаникийн  
хүрээлэнгийн Ургамлын нөөц судлалын салбарын  
эрдэм шинжилгээний ажилтан

Цамбаагийн БАТЦЭРЭН. Ботаникийн хүрээлэнгийн  
Ургамлын нөөц судлалын салбарын эрдэм  
шинжилгээний ажилтан, Биологийн ухааны  
доктор(Ph.D).

Лувсандоржийн ЖАРГАЛСАЙХАН. Ургамалжилтын  
экологийн салбарын эрдэм шинжилгээний ахлах  
ажилтан, Биологийн ухааны доктор(Ph.D).

Отгоны ХОНГОР. Ургамалжилтын экологийн салбарын  
эрдэм шинжилгээний ажилтан, магистр

**Улаанбаатар хот**  
**2014 он**

## АГУУЛГА

### ОРШИЛ

#### I. СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ

I.1. Судалгаа явуулсан газар, нутаг, хугацаа.

I.2. Судалгааны аргазүй

#### II. СУДАЛГАА ЯВУУЛСАН НУТГИЙН БАЙГАЛИЙН ОНЦЛОГ

II.1. Газрын гадарга, геоморфологи

II.2. Цаг уур

II.3. Ургамалжилт, ургамлын бүрхэвч

#### III. СУДАЛГАА ЯВУУЛСАН НУТГИЙН УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ

#### IV. СҮХБААТАР АЙМГИЙН АШИГТ ЗАРИМ УРГАМАЛ

1. Ацан Ажигана
2. Эмийн Багваахай
3. Эмийн Бамбай
4. Алаг цэцэгт Башир
5. Хоёр-ишт Бирэш
6. Сөөгөн Боролзгоно
7. Асганы Бөөрөлзгөнө
8. Бариулт Бүйлэс
9. Толгодын Бударгана
10. Дэлбэрхүү Буржгар
11. Үмхий Буржгар
12. Энгийн Буржгар
13. Цэх Галуунтаваг
14. Говийн Ганга
15. Буурал Гандбадраа
16. Маралнавчит Гичгэнэ
17. Долгиотсон Гишүүнэ
18. Одой Далантүрүү
19. Монгол Догор
20. Хэвтээ Дэгд
21. Сибирь Ерөндгөнө
22. Дэрэвгэр Жиргэрүү
23. Зэлэн Зангуу
24. Нангиад Зээргэнэ
25. Шивлээхэй Зээргэнэ
26. Үлдэн Могойн идээ
27. Ачлагийн Монос
28. Жинхэнэ Өрөмтүүл
29. Нангиад Садагнагва
30. Одой Сараана
31. Өргөст Сарнай
32. Анхил Сонгино
33. Монгол Сонгино
34. Таана
35. Эмийн Сөд
36. Үсхий Суль
37. Их Тавансалаа
38. Юлдэн Тарваган шийр
39. Дэрвээн Тарна
40. Шувуун Тарна
41. Азийн Төлөгчөвс

42. Булцуут Туйпланцар
43. Хос шивүүрт Улаагана
44. Бунгийн Хавраг
45. Одой Хайлаас
46. Нарийн навчит Халгай
47. Жижигнавчит Харгана
48. Сибирь Хармаг
49. Буриад Хонинзажлуур
50. Кузнецовын Хорс
51. Сибирь Хотой
52. Нарийннавчит Хөвөнт
53. Монгол Хунчир
54. Дагуур Хүж өвс
55. Эгэл Цагаантүрүү
56. Нарийннавчит Цахилдаг
57. Цагаалин Цахилдаг
58. Шивүүрт Цульхир
59. Урал Чихэрөвс
60. Өлчир Шарилж
61. Ээрэм Шарилж
62. Үмхий Шимэлдэг
63. Мөлхөө Шээрэнгэ
64. Сибирь Ерөндгөнө
65. Хогийн Олс

ДҮГНЭЛТ  
АШИГЛАСАН БҮТЭЭЛ

**ОРШИЛ**

Монгол орны байгаль, ургамлан нөмрөг харьцангуй уугуул байдлаар байгаа хэдий ч үйлдвэр аж ахуйн шинэ чиглэл, цогцолбор бий болж хот суурин, зам тээврийн шинэ сүлжээ эрчимтэй хөгжиж байгаатай уялдан хөрс, ургамал, амьтны аймагт ихээхэн өөрчлөлт гарч байгаагаас байгалийн ургамлан баялгийг зохистой судлан ашиглаж, хамгаалах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд байгалийн ургамлын баялгийг ашиглаж байгаа манай орны иргэд, улс болон хувийн аж ахуйнууд олширч байгаагаас ашигт ургамлын судалгааг улам гүнзгийрүүлэн хийх асуудал чухалчлагдсаар байна.

Сүхбаатар аймгийн ургамлын аймаг дахь ашигт ургамлын судалгаа дагнан хийгдээгүй. Бид энэ бүс нутгийн ургамлын аймагт ургадаг ашигт ургамлын төрөл, зүйлийн жагсаалтыг үйлдэж, тэдгээрийн тархацыг ургамал-газарзүйн тойргоор тоймлон улмаар засаг захиргааны хуваарь (тархсан газар нутаг), ургах орчноор гаргасныг үндэслэн хээрийн хайгуул судалгааг гүйцэтгэж тархац-байршил, гарц-нөөцийг тогтоох зорилт тавьж ажиллав.


Судалгаа явуулсан жил (2014 онд) Сүхбаатар аймгийн ихэнх нутгаар харьцангуй хур тундастай байсан нь ургамлын өсөлт хөгжилтөд сайнаар нөлөөлж захиалгат ажлын ашигт ургамлын тархац-байршил, гарц-нөөц баялгийг тогтооход эерэг үр дүн гарсан боловч энэ нь төгс хийгдсэн ажил хэмээн үзэж болохгүй бөгөөд нарийвчилсан хайгуул судалгааг явуулах шаардлагатай хэмээн үзэж байна.

Эцэст нь тэмдэглэхэд Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газрын Байгал орчны хэлтсийн хамт олон хээрийн судалгааны ажлын явц, үр дүн амжилттай болоход туслалцаа үзүүлсэн явдалд гүн талархалаа илэрхийлье.

## **I. СУДАЛГААНЫ МАТЕРИАЛ, АРГА ЗҮЙ**

### **I.1. Судалгаа явуулсан газар, нутаг, хугацаа.**

Сүхбаатар аймгийн ашигт ургамлын тархац-нөөцийн анхдагч судалгааг төслөөр хийхээр төлөвлөсний дагуу аливаа ургамлын ургалтын үе 7-9-р сард 45 хоногийн хугацаанд ургамал-газарзүйн Дундад Халх, Дорнод Монгол, Дорноговь буюу засаг захиргааны хуваариар Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Дарьганга, Асгат, Онгон, Баяндэлгэр, Халзан зэрэг сумдын нутгаар гүйцэтгэсэн (1-р зураг).



1-р зураг. Судалгааны маршрут

## I.2. Судалгааны аргазүй

Судалгаа явуулсан газар нутагт геоботаникийн бичиглэлийг Друдегийн (1940) аргаар үйлдэж, бүрхэц, арвийг дараахь байдлаар илэрхийлэв.

- Soc-sociales – тухайн зүйлийн бодгалиудын бүрхэц 90%-аас илүү
- Cop<sub>3</sub> –(copiosae)-арвин – 90-70%
- Cop<sub>2</sub> –(copiosae)-олон – 70-50%
- Cop<sub>1</sub> –(copiosae)-нэлээд олон, цөөнгүй- 50-30 %
- Sp- (sparsae) цөөн, сийрэг – 30-10%
- Sol –(solitariae) ховор- 10%
- Un-(unicum) ганц, нэгхэн тохиолдоно.

Судалгааны явцад Мөнххаан, Түмэнцогт, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Дарьганга, Асгат, Онгон, Баяндэлгэр, Халзан зэрэг сумдын нутгуудад 50 орчим цэгт дунджаар 5-10 м<sup>2</sup> талбай сонгон, GPS-ээр солбицлын цэгийг авч ашиглалтанд өртөмтгий ашигт ургамлын тархац-нөөцийн судалгаатай холбоотой бичиглэлийг үйлдэв.

***Сүхбаатар аймгийн нэн ховор, ховор ашиглалтанд өртөмтгий ашигт ургамлын тархац-нөөцийн судалгаа:***

- Ашигт ургамлын тархац-нөөцийг хээрийн хайгуул судалгаагаар гүйцэтгэхдээ тархац-байршлын геоботаникийн бичиглэлийг Друдегийн зарчмаар, тархац-нөөцийг тогтоохдоо Буданцев А.Л., Харитонов Н.П. нарын аргаар гүйцэтгэв. Үүнд: тухайн хавтгай дөрвөлжин метр талбайд буй ургамлын тоог 40-50 давталттайгаар тоолж, нойтон болон хуурай жинг харьцуулан гаргасан.

- Бүс нутаг дахь ерөнхий тархацыг гаргахдаа хээрийн судалгааны бүртгэл, тэмдэглэл болон тухайн ургамлын талаар бичсэн эрдэм шинжилгээний ном, нэгэн сэдэвт бүтээлийг ашиглан ургамал-газарзүйн тойроогоор ба сумаар гаргав.

- Ашигт ургамлын тархац-нөөцийн зургийг гаргахдаа “Монгол орны ашигт ургамлын тархац-нөөц, экологи-биологийн судалгааны аргазүй”-г үндэс болгон GPS-ээр авсан координацыг уртраг, өргөргийг градус, минут, секундээр зураг дээр цэглэн тэмдэглэж, тархац, нөөцийг 1:10000000 масштабтай зураг дээр хийв.

Хээрийн судалгаагаар геоботаникийн бүрэн бичиглэл 36, бүрэн бус бичиглэл 40 гаруйг үйлдэж, хатаадас 250 орчим, химийн задлаг шинжилгээнд 20 гаруй дээж, тархац-нөөцийн тоон материал 1100 орчмийг цуглуулсан.

## **II. СУДАЛГАА ЯВУУЛСАН НУТГИЙН БАЙГАЛИЙН ОНЦЛОГ**

### **II.1. Газрын гадарга, геоморфологи**

Сүхбаатар аймаг нь Дорнод Монголын талархаг хээрийн өмнөд хэсэгт 8228715 га нутгийг эзлэн орших бөгөөд аймгийн хилийн урт нь 1340 км болно. Аймгийн нутгийн зүүн захын цэгээс баруун захын хил хүртэл 411 км, хойд цэгээс урд зах хүртэл 351 км юм. Сүхбаатар аймгийн төв нь 1942 онд байгуулагдсан Баруун урт хот 5450 га талбайг эзлэн оршино.

Баруун-Урт хот нь тал хээрийн уур амьсгалтай жилийн дундаж температур нь 0,6<sup>0</sup>С, аймгийн нутаг бүхэлдээ Дорнод Монголын талархаг нутагт орших бөгөөд нутгийн хойд хэсэг нь доворхог талтай, дунд хэсэг нь хотгор хөндийтэй, урд хэсэг нь өндөрлөг талархаг цөлийн элемент ихтэй. Аймгийн хамгийн өргөгдсөн хэсэг нь 1778 метр өндөртэй Шилийн Богд уул, 1375 метр өндөртэй Зотолхаан, 1354 метр өндөртэй Алтан Овоо уул зэрэг болно.

Аймгийн нутгийн дундуур зүүн хойноос баруун урагш 250 км орчим үргэлжлэх хотгор газар нь Монголын Дорнод хотгор гэж нэрлэгддэг. Энэ хотгор нь Сүхбаатар аймгийн зүүн хойноос Цагаан тэмээт, Хөөврийн хоолой, Жавхлантын талаас эхлэн Дархан хаан уулын урдуур Суврагын говийн цоорхой, Баруун хүрээ, Цэцэнхар худаг, Сахиул, Төхөм, Шүүт, Шороот, Өөш, Ар жирэм, Өвөр жирэм, Зээрдийн говь болон түүнээс цааш Дорноговь аймаг руу ордог.

Аймгийн нутаг бүхэлдээ Дорнод Монголын талархаг хээрт орших бөгөөд нутгийн хойд хэсэг нь уулархаг доворхог тал, дунд хэсэг нь дов хотгор тал, урд хэсэг нь галт уулын үлдэгдэл өндөрлөг тал байдаг. Иймээс аймгийн нутгийн хамгийн өндөрлөг хэсэг нь урдаа байдаг.

Дорнод хотгорын ихэнх хэсэг болох Өөшийн говь манай улсын алдарт 33 говийн нэг. Аймгийн нутгийн хойд хэсэгт орших доворхог талд Мөнххаан 1606 метр, Түмэнцогт 1358 метр, Заанширээ 1336 метр зэрэг уулнууд оршино. Аймгийн нутгийн дундаж өндөр нь 1280 метр орчим бөгөөд энэ нь улсын дундаж өндрөөс 300 орчим метр нам гэсэн үг.

## **II.2. Цаг уур**

Сүхбаатар аймаг нь улсын нийт нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай. Аймгийн нутгийн баруун ба төвийн хотгор газраар тундас бага, хойд ба зүүн талдаа арай их унадаг. Ялангуяа Эрдэнэцагаан сумын орчим 286,6 мм тундас ордог нь нутгийн зүүн захын Хянганы салбар уулсын нөлөө юм. Аймгийн нутгийн нарны нийлмэл цацраг 1300-1500 кВт цаг/м<sup>2</sup> байдаг нь улсын хэмжээнээс их байна. Аймгийн ихэнх нутагт агаарын жилийн дундаж дулаан 0<sup>0</sup>C-+2<sup>0</sup>C байна. Агаарын жилийн дундаж даралт аймгийн ихэнх нутагт 844 гПа улсын хэмжээний бага даралттай нутагт орно. Нутгийн ихэнх хэсэг тогтвортой цасан бүрхэвч 12-р сарын 1-нээс тогтох ба 3-р сарын 1 орчимд ханзардаг.

Хөдөө аж ахуй, уур амьсгалын хувьд авч үзвэл: ургамлын дулаан хангамжын хувьд аймгийн нутгийн хойд зүүн урд хэсэг нь +10<sup>0</sup>C-аас дээшхи дулаантай хоногийн дундаж дулааны нийлбэр 1400<sup>0</sup>-2000<sup>0</sup> нутгийн ихэнх хэсэг болох төвийн нутаг нь 2000<sup>0</sup>-2600<sup>0</sup> буюу улсын хэмжээнд сэрүүн нутагт орох ба чийг хангамжын хувьд гандуувтар буюу чийг дутмаг нутагт ордог.

## **II.3. Ургамалжилт, ургамлын бүрхэвч**

Тус аймгийн нутаг нь ургамалжитын хувьд тал хээр, цөлийн хээр гэж хоёр хуваагдана. Нутгийн баруун өмнөд хэсэг нь (Баяндэлгэр, Онгон сумдын зарим хэсэг) цөлийн хээрт, бусад нь хээрт хамаарна. Тус аймгийн нутагт олон зуун зүйл гуурст ургамал ургах бөгөөд түүн дотор хялганын хэдэн зүйл, дааган сүүл, булган сүүл, дэрс зэрэг үетэн, харгана болон нэлээд хэдэн зүйл хунчир зэрэг сөөг, сөөгөнцөр хийгээд яргуй, тэмээн хөх, хорс, ганга, батраш, төлөгч өвс, хатны өвс зэрэг олон настууд ургадаг. Мөн бүйлс, гүйлс, долоогоно, хармаг, нохойн хошуу, бургас, хус, хайлаас зэрэг мод сөөг бий. Эдгээр ургамлын дотор чихэр өвс, хунчир, зээргэнэ гэх мэт эмийн ургамал ургадгын хамт алдарт чоно голын бонго, гандигаар зэрэг ургамал ургана.

Дээр цухас дурьдсанчилан тус аймгийн нутаг дэвсгэр нь хээрийн ба цөлийн хуурай гэсэн хоёр бүстэй бөгөөд бас “Дорнод хотгор”-ыг голчлон (мөн



Хэрлэнгийн татам, хөндий, гол горхи, нуурын хөндий) дагасан бүс дундын буюу завсрын бүсийн ургамалжилт Элдэвийн говь нэртэйгээр зурвасласан тохиолддог. Энд голчлон тохиолддог ургамалжлыг товчоор дурьдая. Үүнд:

-Аймгийн нэлээд өндөрлөг хэсэг буюу ухаа толгод, тэдгээрийн оройн бараан хүрэн, хүрэн хөрстэй (чулуурхаг) газраар даагансүүл, хазааргана, ерхөг, шивээт хялганат (Түмэнцогт, Эрдэнэцагаан зүр өвстэй)

-Ухаа гүвээ толгодын хормой бэл, талын карбонаттай хүрэн хөрстэй газраар хазааргана (элсэнцэрдүү хөрстэй газраар нь Мөнххаан, Баянтэрэм зэрэгт их хялгана)-тай шивээт хялганат.

-Ухаа, гүвээ, талын шавранцар бараан хүрэн буюу хөрстэй газраар агь, шивээт хялгана, элсэнцэрдүү хөрстэй газраар нь хар түнгэ.

-Хотгор хоолой хөндий, тойрмын хөвөөний мараалаг шавранцар хүрэн хөрстэй газраар таана, хөмөл, улалж, түнгэтэй хялгана, Баяндэлгэр, Онгоны тойром “Говь”-ийн хөвөөний мараалаг цайвар хүрэн өвстэй газраар таана, монгол өвстэй шар бударгана, улаан бударгана, бор бударгана.

-“Дорнод хотгор” зэрэг “Говь” цайдам тойрмын зэрэг марзлаг нугын хөрстэй газраар улалж, түнгэ зэргээр тус тус ургамлын бүрхэвч үүснэ. Энэ бүхэн нь тус аймгийн мал сүргийн голлох бааз-бэлчээр бөгөөд аймгийн дорнод ба умард хэсэг нь хадлангийн эдэлбэр болохуйц арвин сахлаг өвстэй. Тэдгээр нь зудын гамшгаас мал сүргийг удаа дараалан авардаг чухал эдэлбэр, зээр зэрэг ан гөрөөсний таатай нутаг юм.

### **III. СУДАЛГАА ЯВУУЛСАН НУТГИЙН УРГАМЛЫН ЗҮЙЛИЙН БҮРДЭЛ**

Өдгөө Монгол оронд аймгийн нийт 683 төрөлд багтах 3127 зүйл (*Urgamal et al.* 2014) гуурст дээд ургамал ургадгаас Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт 650 орчим зүйл гуурст дээд ургамал тархдаг нь нийт зүйлийн 23 орчим хувийг эзэлдэг байна.

Ургамлын аймгийн хувьд Үетэн (*Poaceae*), Нийлмэлцэцэгтэн (*Asteraceae*), Буурцагтан (*Fabaceae*), Холтсонцэцэгтэн (*Ranunculaceae*), Сарнайтан (*Rosaceae*), Луультаан (*Chenopodiaceae*), Баширтан (*Caryophyllaceae*), Байцаатан (*Brassicaceae*) зэрэголон зүйлтэй томоохон овгууд, түүнчлэн Шарилж (*Artemisia*), Хялгана (*Stipa*), Ботууль (*Festuca*), Лууль (*Chenopodium*), Гичгэнэ (*Potentilla*), Сонгино (*Allium*), Ортууз (*Oxytropis*), Холтсонцэцэг (*Ranunculus*) зэрэг олон зүйлтэй томоохон төрлүүдийн ургамлууд дийлэнх хувийг эзлэн зонхилон ургадаг байна.

Сүхбаатар аймгийн ургамлын аймгийн хувьд хээрийн олон наст, поликарп, хуурайсаг үетнүүд илт зонхилон тархсан. Үүнд: *Stipa krylovii*, *S. gobica*, *S. grandis*, *S. glareosa*, *Festuca lenensis*, *Agropyron cristatum*, *Leymus chinensis*, *Cleistogenes squarrosa*, *C. songorica*, *Koeleria macrantha*, *Poa attenuata*, *Helictotrichon* тэргүүтэн давамгайлж ургана. Ялангуяа Хялганын гүйцэтгэх үүрэг, давамгайлал хамгийн өндөр. Үетнээс гадна улалж (*Carex duriuscula*, *C. pediformis*), сөөг (*Caragana*, *Amygdalus*), заримдаг сөөгөнцөр (*Artemisia frigida*, *A. adamsii*, *A. xerophytica*, *A. caespitosa*, *Ajania achilloides*, *A. fruticulosa*, *Kochia prostrata*), алаг өвс (*Allium polyrhizum*, *Filifolium sibiricum*) элбэг тархана.

Сүхбаатар аймгийн ургамалжил нь Монголын хээрийн хошууны Дундад Халхын хээрийн дэд хошуу, Дорнод Монголын хээрийн дэд хошууд хамаарна (Түвшинтогтох, 2014).

Хээр нь Монгол орны хувьд хамгийн түгээмэл ургамалжлын хэвшинж бөгөөд 1034737,38 км<sup>2</sup> талбай буюу нийт нутгийн 66,12%-ийг эзэлдэг ба Сүхбаатар аймгийн нутагт дээрх хээрийн дийлэнх нь оршдог. Ийнхүү хээрийн хэвшинжийг дотор нь 6 дэд хэвшинж болгон ангилдаг бөгөөд Сүхбаатар аймгийн хувьд уулын болон хуурай хээр зонхилж, харин нугын болон цөлжүү хээр багахан талбайг эзэлнэ (Түвшинтогтох, 2014).

Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт Монгол орны ургамал-газарзүйн 16 тойргоос Дорнод Монголын хээрийн (аймгийн зүүн, зүүн хойд хэсэг), Дундад Халхын хуурай хээрийн тойрог (аймгийн нутгийн баруун, баруун хойд, хойд хэсэг), Монгол Дагуурын уулын ойт хээрийн (төв болон баруун хойд хэсэг) гэх 2 тойрог зонхилон, тус аймгийн баруун урд хэсгийн тун бага нутгаар Дорнод говийн цөлөрхөг хээрийн тойрог тохиолдоно (Зураг 1, 2).

Сүхбаатар аймаг нь Монгол орны байгалийн бүс, бүслүүрийн хувьд хээрийн бүс үндсэнд нь илүүтэй зонхилно. Аймгийн нутгийн ихэнх нутгийг далайн түвшнээс дээш 1200-1500 метр өргөгдсөн. Газарзүйн байршлаар Дундад Халхын өндөрлөг, Дорнод Монголын талархаг мужид багтана. Нутгийн хойд хэсгийн уулын өргөн хөндийнүүд нь газар тариаланд тохиромжтой хүрэн бор хөрстэй, өмнөд хэсэг нь гүвээ толгод бүхий тал хээр газар юм.

Аймгийн нутгийн дийлэнх нутгаар хээр талын хүрэн, цайвар хүрэн хөрстэй, зүүн хойд хэсгээр нь ам хөндийн бараан хөрс, нугын саарал хөрс тархжээ.



2-р зураг. Монгол орны ургамал-газарзүйн тойрог (Н.Өлзийхутаг, 1989)



3-р зураг. Сүхбаатар аймгийн ургамал-газарзүйн тойрог  
8. Дундад Халх, 9. Дорнод Монгол, 12. Дорнод говь

Сүхбаатар аймаг нь ургамал-газарзүйн мужлалд 3 тойргийн нутаг хамрагдахаас Дундад Халхын хуурай хээрийн тойрогтхад чулуутай өндөрлөг газраар нь шивээт хялганат (*Stipa krylovii*) хуурай хээрийн олон хувилбар тохиолдоно. Тухайлбал: Шивээт хялгана-хазаарганат (*Stipa krylovii* - *Cleistogenes squarrosa*), Шивээт хялгана-агь (*Stipa krylovii* – *Artemisia adamsii*), шавагт

(*Artemisia frigida*, *A. adamsii*), дорнод хэсэгт нь хотгор дагаж шивээт Хялгана-Нангиад түнгэт (*Stipa - Leymus chinensis*), шивээт хялгана-таанат (*Stipa krylovii - Allium polyrrizum*, *A. anisopodium*) хуурай хээр тааралдана. Элсэнцэр хөрстэй газар нь харганатай, харгана-агь-үетэнт хээртэй бөгөөд тэнд саман ерхөг, саман дурваа, агь, алтаншар шарилж, жижигнавчит харгана, одой харгана зонхилогч болно. Гол нуур орчмын хужир, марцлаг хотгорт түнгэ бүхий дэрстэй байх ба түүнийг дагаж нэг наст хэрс, шорной, шарилж синузи үүсгэх юмуу хааяа Нангиад түнгэ, судалгүй өлөн, цагаалин цахилдаг ихээр ургана. Энэ тойргийн өмнөд захаар гоолиг шарбударгана, Зүүнгарын улаан бударгана, бор бударгана, ахарнавчит баглуур зэрэг жинхэнэ говийн ургамал оролцсон хужир, марцтай хотгорууд, өдлөг (сайрын ба говийн) хялганатай, өдлөг хялгана-таанатай, өдлөг хялгана-бударгантай хайргархаг, чулуурхаг дэнж дэвсгүүд, хяр гүвээ үргэлжилнэ. Хойд захын бэсрэг уулсаар нь хус, улиангар оролцсон холимог төгөл ойтой тул чийгсэг ойн ургамлууд (сарнай, гичгэнэ, тавилгана, бүйлээс) дагалдан ургана. Дундад Халхын тойрогт ургамлын аймгийн хувьд биеэ даасан өвөрмөц онцлогоор тун бага, хэд хэдэн тойргийн шилжих зааг дээр бусад бүсийн ургамлууд холилдог ургана. Тэдний зарим нь Монголын ба Дагуурын хээрийн, заримнь цөлөрхөг хээрийн, бас умардын уулсын элементүүд оролцоно.

Дээрхээс үзэхэд уг тойрогт гол нь хуурай хээрийн ургамал зонхилохын зэрэгцээ зарим нуур, голын хөнийнүүдэд чийгсэг, говийн нөлөө туссан хотгоруудад давссаг ургамал багагүй үүрэгтэй нь харагдаж байна. Дундад Халхын тойргийн үндсэн төрх үзүүлэх зүйлүүд: *Selaginella sanguinolenta*, *Potamogeton crispus*, *Zannichellia pedunculata*, *Calamagrostis salina*, *Tripogon chinensis*, *Puccinella filifolia*, *Agropyron desertorum*, *Cyperus fuscus*, *Carex relaxa*, *C. tomentosa*, *S. Gordejevii*, *Ulmus japonica*, *Polygonum intricatum*, *Corispermum orientale*, *Dimorphostemon pectinatus*, *Hibiscus trionum*, *Euphorbia kozlovii*, *Cotoneaster mongolicus*, *Potentilla leucophylla*, *Sibbaldianthe sericea*, *Chamaerhodes trifida*, *Oxytropis kossinskyi*, *Rhamnus erythroxylon*, *Asterothamnus alyssoides*, *Achillea ptarmicoides*, *Ajania trifida*, *Artemisia frigida*, *A. halodendron*, *Taraxacum collinum* зэрэг болно.

Сүхбаатар аймгийн ургамал-газарзүйн мужлалын хувьд Дорнод Монголын уужим тэнүүн тэгш тал, ухаа гүвээрхэг газры баруун жигүүр хамаарна. Эндэхийн өндөр д.т.д 532-1775м. зохинлох өндөр нь 800-1000 м-т оршино. Урд хэсгээрээ Зотолхаан, Шилийн Богд, Алтан-Овоо, Гангын Цагаан овоо зэрэг

бэсрэг уулс бүхий хүрмэн чулуугаар бүрхмэл нутаг юм. Бас тэнд Молцог, Онгон алс хэмээх 2 хэсэг манхан элстэй газар бий. Урд хэсгийн бэсрэг уулс, ухаа гүвээрхэг тэгш өндөрлөгийг бие даасан Даригангын тойргийн хэмжээнд авч үзэх тал бий. Энэ тойрогт томоохноос Буйр нуур, жижгээс Хөх нуур, сангийн далай нуур зэрэг давстай тогтмол нуур олон бий. Тойргийн нутаг дээгүүр Хэрлэн, Улз, Халхын голын адаг урсаж өнгөрнө. Нэлээд дулаан, муссоны уур амьсгал зохих хэмжээгээр нөлөөлдөг газар юм. Газрын гадаргын байдлаараа нэг жигд учраас ургамалжилтын хувьд ч мөн тийм байдаг. Хотгор хонхорын дагууд дэрстэй цайдам бий.

Дорнод Монголын хээрийн тойрог нь Сүхбаатар аймгийн зүүн, зүүн хойд, хойд нутгуудаар тохиолддог бөгөөд тус тойргийн ургамалжлын үндсэн хэвшинжид түнгэт (*Leymus chinensis*), Том хялганат (*Stipa grandis*), Крыловын хялганат (*Stipakrylovii*), Дэрвээн хазаарөвст (*Cleistogenes squarrosa*), Саман ерхөгт (*Agropyron cristatum*), Харганат (*Caragana microphylla*, *C. stenophylla*) гэх хэвшил зонхилон тархана. Тухайлбал, Сибирийн хялгана, Крыловын хялгана, нангиад түнгэ, дэрвээн хазааргана, саман дурваа, сунагар биелэг, Ленийн ботууль, саман ерхөг зэрэг үетэн оролцсон хялгана-дурваат, шивээт хялгана-шавагт, шивээт хялгана-хазаарганат, түнгэ-шивээт хялганат хуурай хээр зонхилно. Бэсрэг уулсын хоорондох хөндийд элсэрхэг хүрэн хөрстэй, газраар түнгэ, жижигнавчит харгана, нарийннавчит харгана оролцсон шивээт хялгана-дурваат, хялгана-жижиг дэгнүүлт, үетэн-дурваат хээртэй. Тойргийн дорнод ба умард хэсгийн хар хүрэн хөрстэй газраар зүр өвслөг ургамал-элдэв өвслөг ургамалтэй, зүр өвслөг ургамал-хялганат, элдэв өвслөг ургамал- түнгэ- хялганат хээр зонхилно. Тойргийн өмнөд хэсэгт таана, хөмөл оролцсон хялгана-таанатай болон улаанбударганатай цөлөрхөг хээр; нэгнаст бударганууд, мөн навчлаг ба гоолиг шарбударганатай хужир, марцтай тойром, хотгор нэлээд бий. Бэсрэг уулсын ам хавцлаар хайлас, бургас цөөн, харин бүйлээс, гүйлэс, харгана нэлээд элбэг тааралдана.

Энэ тойргийн үндсэн төрхийг үзүүлэх ургамлуудад: *Alisma plantago-aquatica*, *Sagittaria trifolia*, *Echinochloa crusgalli*, *Zizania latifolia*, *Calamagrostis salina*, *Tripogon chinensis*, *Melica turzcaninoviana*, *Puccinellia filifolia*, *Agropyron desertorum*, *Leymus chinensis*, *Cyperus fuscus*, *Scirpus orientalis*, *Carex argunensis*, *C. relaxa*, *C. seclina*, *Acorus calamus*, *Allium condensata*, *Veratrum nigrum*, *Anemarrhena asphodeloides*, *Iris ventricosa*, *Dactylorhiza incarnata*,

*Aconitum kuznezoffii*, *Clematis aethusifolia*, *C.hexapetala*, *Salix gardejevii*, *Rumex maritimus*, *Suaeda glauca*, *Clausia trichocephala*, *Androsace longifolia*, *Hibiscus trionum*, *Spiraea pubescens*, *Crataegus dahurica*, *Potentilla chinensis*, *P.leucophylla*, *P.semiglabra*, *P.verticillaris*, *Sibbadianthe sericea*, *Chamaerhodos corumbosa*, *Ch.trifida*, *Rosa dahurica*, *Padus asiatica*, *Amygdalis pedunculata*, *Armeniaca sibirica*, *Sophora flavescens*, *Thermopsis przewalskii*, *Caragana stenophylla*, *Astragalus dahuricus*, *A.membranaceus*, *Oxytropis arenaria*, *O.grandiflora*, *O.leptophylla*, *O.micrantha*, *O.micriphylla*, *O.prostrata*, *O.racemosa*, *Lespedeza tomentosa*, *Lathyrus pisiformis*, *Dictamnus dasycarpus*, *Epilobium fastigiato-ramosum*, *Pimpinella thellungiana*, *Nymphoides peltatum*, *Cynotonum purpureum*, *Cuscuta australis*, *C.chinensis*, *Leonurus mongolicus*, *L.glaucescens*, *Solanum septemlobum*, *Adenophora crispata*, *Brachyastis ciliata*, *Inula salicina*, *Achillea ptarmicoides*, *Artemisia desertorum*, *A.halodendron*, *A.macilenta*, *A.superba*, *Scorzonera albicaulis* зэрэг болно.

Сүхбаатар аймгийн баруун өмнөд хэсэгт багахан нутаг нь Дорнод говийн цөлөрхөг хээрийн тойрогт хамаарагдана.

Дорноговийн тойрог ургамалжилтын хувьд тачирхан, сийрэг ургамалтай, өдлөг хялганат, өдлөг хялгана-хазаарганат, өдлөг хялгана-таанат, өдлөг хялгана-боролзойт цөлөрхөг хээр зонхилно. Элсэрхэг хөрстэй газраараа сийрэгхэн заган шугуйтай, эсвэл харган-шаваг (*Caragana bungei*, *Artemisia xanthochroa*, *A.xerophytica*)-т эвшил тааралдана. Шаварлаг, марцлаг хотгоруудад гоолиг шарбударгана, Зүүнгарын улаанбударгана, эсвэл луулийн овгийн нэг наст ургамлууд оролцсон эвслүүд тохиолдоно.

Үүнээс үзэхэд их хуурай халуунд зохилдсон ургамлууд ургамлан нөмрөгт гол үүрэг гүйцэтгэдэг байна. Дорноговийн тойргийн ургамлын аймаг нь жинхэнэ Говийн цөлөрхөг хээр, цөлийн төлөөлөгчдөөс бүрддэг юм. Тойргийн үндсэн төрхийг үзүүлэх ургамлуудаас дурдвал: *Ephedra sinica*, *E.intermedia*, *Pennisetum centrasiaticum*, *Stipa brevifolia*, *Tripogon purpurascens*, *Puccinellia filifolia*, *Elymus trachycaulis*, *Asparagus trichophyllus*, *Limonium gobicum*, *Corispermum tylocarpum*, *Salsola Ikonnikovii*, *S.laricifolia*, *Mollugo cerviana*, *Dontostemon crassifolius*, *Tamarix florida*, *T.laxa*, *Hibiscus trionum*, *Gypsophila desertorum*, *Euphorbia kozlovii*, *E.lunulata*, *Amygdalus pedunculata*, *Caragana stenophylla*, *C. bungei*, *Oxytropis monophylla*, *Cynanchum pubescens*, *Convolvulus tragacantoides*, *Cuscuta chinensis*, *Lycium truncatum*, *Solanum septemlobum*, *Cistanche Feddiana*, *C.salsa*, *Orobanche Korshinskyi*, *Xanthium sibiricum*, *Cancrinia discoidea*, *Artemisia*

*implicata*, *A. mongolorum*, *Jurinea mongolica*, *Olgaea lomonossowii*, *Ajania trifida*, *A. acilleoides* зэргийг дурддаж болно.

## V. СҮХБААТАР АЙМГИЙН АШИГТ ЗАРИМ УРГАМАЛ

Бид Сүхбаатар аймгийн сумдын нутагт ургадаг ашигт ургамлын төрөл, зүйлийн жагсаалтыг гаргасны үндсэн дээр тэдгээрийн тархацыг ургамал-газарзүйн тойргоор хийж, улмаар захиалагчийн хүсэлтийг харгалзан засаг захиргааны хуваарийг (тархсан газар нутаг) оруулан ургах орчноор гаргахын тулд хээрийн хайгуул судалгааг явуулав.

Эхний ээлжинд захиалагч байгууллагын санал болгосон хийгээд урьд хийгдсэн судалгаа, ном бүтээлийг ашиглан дараах ургамлыг судалгаанд хамруулах зүйтэй гэж үзэв. Үүнд: *Astragalus membranaceus* (Fisch.) Bge., *Glycyrrhiza uralensis* Fisch., *Ephedra* L. (2 зүйл), *Saposhnikovia divaricata* (Turcz.) Schischk., *Iris* L. (2 зүйл), *Stellaria dichotoma* L., *Urtica angustifolia* Fisch., *Thymus gobicus* Tschern., *Chiazospermum erectum* Bernh., *Tribulus terrestris* L., *Ferula bungeana* Kitag. г.м. зүйл ургамлуудыг сонгосон бөгөөд бидний судалгаагаар 60 гаруй зүйл ашигт ургамал хамрагдсан.

### АЖИГАНА

Латин нэр: ***Stellaria dichotoma* L.**

Монгол нэр: **Ацан Ажигана**

Адилцаа нэр: Түмэн зангилаа, сороол.

Орос нэр: Зведчатка вильчатая


Англи нэр: Dichotomous Starword

**Ангилалзүйн шинж:** 5-15 мм голчтой, 20 см урт үндэстэй олон наст өвслөг ургамал. Булчирхайт өтгөн богино үсэрхэг, сууриасаа эхлэн ацлаж салаалсан, 30 см хүртэл өндөр, бөмбөлөг хэлбэрийн бут үүсгэдэг, олон салаа иштэй. Навчис өндгөрхүү буюу гонзгойвтор өндгөрхүү, юлдэрхүү юмуу шугаман юлдэрхүү, ишний доод хэсгийнх өргөн, дээд хэсгийнх нарийн олон навчистай. Навчны үзүүр шовгор, суурь зүрхэрхүү. Бага зэрэг цуурсан цагаан дэлбээ бүхий цэцгүүд иш найлзуурын үзүүр ба навчны өвөрт байлада, нарийн сарьслэг эмжээртэй, шовх юлдэн илтэстэй. Цоморлигт.жимс 2-5 үртэй, бараг бөмбөлөгөн хонхорцог(4-р зураг).

**Ургах орчин:** Ихэвчлэн чулуурхаг энгэр дагаж, хааяа хад, чулууны ан цаваар мөн үйрмэг-хайрган хөрстэй сайр дагаж бага ургана.

Уулын болон хуурай хээрийн үетэн-элдэвөст эвшилд тохиолдоно.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Дорноговь, Говь-Алтай тойргуудад ургана.



4-р зураг. Ацан ажигана

5-р зураг. Ацан ажиганын тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (5-р зураг, 1-р хүснэгт).

1-р хүснэгт

### Ацан ажиганын тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр, координат	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Сумын төвөөс хойш 9 км-т, голын хөндийн дэргэдэх бэсрэг уул толгодын хойт налуу. д.т.д. 1054 м. 45° 57'23.7", 115° 22' 55.5	Голын хөндийн дэргэд. Дэрс- үетэн- алагөвст хажуу	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Бичигтийн заставаас баруун тийш 1 км-т, Лхачинвандад уул явах замд. Ар хөндлөн голын дагуу	Дэрс- үетэн- алагөвст хажуу	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уулын энгэр	Үетэн- алагөвст хажуу	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Холбоогийн элс,	Үетэн- алагөвст элсэн хажуу	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Холбоо нуур. Холбоогийн элс. 45° 14' 066", 114° 08' 108"	Бургас- хайлаас бүхий үетэн- алагөвст элсэн довцог.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Сумын төвөөс баруун хойш 51 км-т. Дарьгангаас Баруун-Урт орох замд.	Бударгана- дэрс бүхий хотгор.	Дорнод Монгол (Дарьганга)
Онгон	Онгон элсэнд	Үетэн- алагөвст элсэн манхан	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр.	Сумын төвөөс 50 км-т, Ongon элсний баруун хойт үзүүрт. 45° 35' 596" 112° 49'039"	Харгана- үетэн- алагөвст цөлөрхөг хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	Баянцагаан уулын урд талд. 47° 46' 0.18", 112° 23' 57.5", 966 м-т	Агь- алагөвс-үетэнт (ботууульт)	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Баян овоо уулын хойд талын тэгш орой. 47°32' 44.5", 112° 18' 49.6", 1078 м-т	Чулуусаг алагөвс- агь- хазаарт	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°18'317", 112°12'010", 1093 м-т	Агь- алагөвс- хялганат	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Баян уулын ар хажуу 46° 52' 07.7", 112° 08' 10.5, 1331 м-т	Сөөг бүхий үетэн-баялаг алаг өвс-ботуулт	Дундад Халх (зүүн)



		бүлгэмдэл	
Мөнххаан	Мөнххаан уулын оройд 46°59' 18.8", 111°54' 36.3", 1578 м-т	Баялаг алаг өвс-үетэнт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Сүхбаатар.	Түмэнцогтоос зүүн урагш 116 км-т, Дорнодын Матад сум орох замд. Баян-Овоогийн говийн орчим. 47° 09' 529", 113° 31' 595"	Хялгана- шарилж-элдэвөвст хээр	Дундад Халх (дорнод)

**Хэрэглээ үйлчилгээ:** Үндэс нь *Coli communis*-ын өсөлтийг нэлээд зогсоох үйлдэлтэй ба хоруу чанар багатай. Уушигны өрөвсөл, сүрьеэ, хүүхдийн хөхүүлдэг ханиад анагаадаг олон эм танд зонхилгоч болгон оруулдаг. Бэлдмэл ба нийлбэр үйлчлэгч бодисын ханд нь цэрийг шингэрүүлэн ховхлох үйлдэлтэй.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Нас гүйцсэн болон хөгшин ажиганын үндсийг ухаж авах бөгөөд залуу ургамлын үндсийг ухаж авалгүй үлдээж нөхөн сэргээлтийг хангах нь уг ургамлыг ховордон устахаас сэргийлнэ.

## БАГВААХАЙ

Латин нэр: *Taraxacum officinale Wigg.*

Монгол нэр: **Эмийн Багваахай**

Адилцаа нэр: Багваахай

Орос нэр: Одуванчик лекарственный

Англи нэр: Medicinal Dandelion

**Ангилалзүйн шинж:** Цэцэглэх иш 10-30 см өндөр. Өдлөж ухагдсан, шүдлэг салбан бүхий навчтай, ороолтын гадаад навчинцар, цэцэглэх жимслэх үедээ гадагш эргэж матийдаг. Толгойрхуу хэлбэрийн сагс баг цэцэг нь хурц шар өнгөтэй, олон наст өвслөг ургамал(6-р зураг).

**Ургах (тархацын) орчин:** Ойн болон татмын нуга, нуур ба голын эрэг, суурин газрын орчим, зам дагуу ургадаг.



6-р зураг. Эмийн Багваахай



7-р зураг. Эмийн Багваахайн тархац

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (7-р зураг, 2-р хүснэгт).

2-р хүснэгт

**Эмийн Багваахайн тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр, координат	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Сумын төвөөс зүүн урагш 16 км-т. Ганга нуурын дэргэд Оргихын булаг. 45° 16' 000", 113° 59' 507"	Улалж-үетэн-алагөвст нуга.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Сумын төвөөс баруун тийш 14 км-т, Баянголын эх, Салаагийн элс. 45° 16' 197", 113° 44' 208"	Ширэг улалжтай дэвсэг.	Дорнод Монгол (Дарьганга)

**Биологийн идэвхт бодис:** Газрын дээд хэсэгт флавоноидууд (0.8 мг/г флавон); кумарин агуулагдана. Навчинд кофейн ба п-кумарин фенолкарбонын хүчил, цэцгэнд флавоксантин байгааг тогтоосон. Үндсэнд циклитол, идээлгийн бодис, эфирийн тос, стерин, картоноид зэрэг бодис бий. Мөн цэцэг, навчинд эфирийн тос, тритерпений спирт, стерин, картоноид, В<sub>1</sub>, В<sub>2</sub>, С аминдэм; цэцгэнд К аминдэм; үрэнд өөх тос агуулагдана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Хавар эрт түүсэн залуу навчаар шөл болон мах, загасны махаар хийсэн 2-р хоолонд амтлагч болгож, мөн салат хийнэ. Үндсийг шарж хуураад кофе орлуулагч хийдэг.

Үндсийг бөөр, цэсний өвчинг эмчилэхэд хэрэглэнэ. Газрын дээд хэсгийг ходоод гэдсэнд хэрэглэнэ. Багваахайн газрын дээд хэсэг ба үндэс нь ходоодны хүчил багасах, өтгөн хатах, чихрийн шижин, бөөрний хүчтэй өвдөлт, арьсний өвчин, судас хатуурах өвчинд хэрэглэнэ.

**Зохистой ашиглах, хамгаалахуй:** Эмийн түүхий эдэд газрын дээд хэсэг, үндэсийг бэлтгэдэг. Үндсийг намар буюу хавар эрт навч ургаж гүйцэхээс өмнө ухаж аваад хөрсийг сэгсэрч унаган газрын дээд хэсэг, хажуугийн үндсийг огтолж хаяад хүйтэн усанд угааж хэд хэд огголоод дүүжилж хэд хонуулна. Салхинд тавих юмуу хатаагч шүүгээнд 40-50<sup>0</sup>С-ийн хэмд хатаана. Хатаасны дараа бор хүрэн юмуу бор саарал өнгөтэй болж гашуун амттай, үнэргүй болно. Үндсийг хэрэглэхээс өмнө махны машинаар жижиглээд савхаар сайн хутгаж (хоорондоо барьцалдахгүй болтол) дахин хатаана. Түүхий эдийг чийгтэй байлгаж болохгүй, 5 жил хадгалж болно.

**БАМБАЙ**

Латин нэр: **Valeriana officinalis L. = V. alternifolia Ledeb.**

Монгол нэр: **Эмийн Бамбай**


Адилцаа нэр: Цувраанавчит бамбай

Орос нэр: Валериана очереднолистная

Англи нэр: Alternate-Leaved Valeriana

**Ангилалзүйн шинж:** Ихэвчлэн нэжгээдээр, хааяа багцлан байрласан (60)80-100(120) см өндөр, дээд хэсэгтээ салаалсан, хөндий иштэй олон наст өвслөг ургамал. Хурц үнэр бүхий бүдүүвтэр үндэслэг иштэй. Захаараа шүдлэг, 3-9 хос навчинцраас тогтсон, үслэг өдлөг навчтай; үндэс орчмын навч бүтэн захтай. Цэцэг цайвар ягаан буюу ягаавтар, оройн Бамбайрхуу залаа маягийн сийрэг баг цэцэгт нэгдэнэ. Жимс өдлөг үсэнцэр бүхий цомцогтой(8-р зураг).

**Ургах орчин:** Ойн бүслүүрт шинэсэн ой, тэдгээрийн зах, хусан төгөл, ойн татмын нуга, боролж, бургасан шугуй, сүүдэрсэг ам, хадны ёроолоор ургана.



**Тархац-байршил:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховдын тойрогт тохиолдоно.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Бид Дарьганга сумын Шилийн Богд уулын ( $45^{\circ} 28'15,6''$ ,  $114^{\circ} 35' 01,4''$ . Д.т.д 1688 м) бургасан төгөлд алагөвст эшилд ургаж байгааг тогтоов(9-р зураг, 2-р хүснэгт).

**Гарц нөөц баялаг:** Энэ ургамал Дарьганга сумын Шилийн Богд уулын хээрийн бургасан төгөлд алагөвст эвшилд sol аривтай ургана.

**Хэрэглээ, ач холбогдол:** Төв мэдрэлийн системийн өвчнүүд, ядаргаа, ходоод гэдэсний өвчин, зүрхний өвчин, зүрх дэлсэх зэрэгт өргөн хэрэглэнэ. Ядаргаа (невроз), уналт, нойргүйдэл, толгой таллаж өвдөх (мигрень), сэтгэцийн хөөрлийн үед, мэдрэлээс шалтгаалан цусны даралт ихсэх зэрэгт ууна.

Намар 9-10-р сард үндэс, үндэслэг ишийг ухаж аваад ишийг хярган хаяж, шавар шороог арилган сүүдэр газар хатаана.

**БАШИР**

Латин нэр: ***Dianthus versicolor* Fisch.**

Монгол нэр: **Алагцэцэгт Башир**

Адилцаа нэр: Хадаасан цэцэг, Юмдүүжин,


Орос нэр: Гвоздика разноцветная

Англи нэр: Colour-changing Pink, Versicolor Pink

**Ангилалзүйн шинж:** Иш 10-35 см өнөр, эгц босоо, салаархаг, навч лугаа богино, хатуу тачир үсэнцэртэй, эсвэл нүцгэн. Иш салааны үзүүрт ганц юмуу 2-3 цэцэг оршино. Цэцгийн дагаварх хайрс голдуу 4, тэдгээр тус бүр өндгөрхүү боловч юлдэн-шугамархуу урт үзүүрт огцом шилжинэ. Цоморлиг 13-18 см урт, гуурсархуу үзүүрээдээ нарийн. Дэлбийн хэлтэс 20-25 мм урт, улаан ягаан, дэлбэн нь 10-12 мм урт, оройдоо жиг бус шүдэрхэг. Дэлбийн хэлтэсний шилбэ үсэнцэртэй. Хүрдэрхүү дэлбэнгийн дээд тал улаан ягаан, доод тал цайвардуу юмуу цагаан ягаан тул алаг башир хэмээнэ(10-р зураг).

**Ургах орчин:** Уулын хээрийн бүслүүр, хээрийн бүсэд тэгш тал, хээржүү нуга, чулуурхаг ба хайргархаг хээржүү хажуу, байц цохионд ургана.

**Монгол дахь тархац:**Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуур, Олон нуур, Говь-Алтайн тойрогт ургана.



10-р зураг.Алаг цэцэгт башир

11-р зураг.Алаг цэцэгт баширын тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (11-р зураг, 3-р хүснэгт)

3-р хүснэгт

### Алагцэцэгт Баширын тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Мөнххаан	47°15'062", 112°10'998", 1178 м-т	Алаг өвс-ганга-улалжит	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Баян уулын уулын ар хажуу	Сөөг бүхий үетэн-баялаг алаг өвс-ботуульт бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Баян уулын оройд	Баялаг алаг өвс-үетэнт бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)

Түмэнцогт	Түмэнцогтын ууланд	Баялаг алаг өвс-үетэнт	Дундад Халх (дорнод)
-----------	--------------------	------------------------	-------------------------

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт рутин, изорамнетин, кверцетин болон кемпферол гликозидууд бүхий флавоноидууд бий. Үндсэнд алкалоидууд; газрын дээд хэсэгт С, Е аминдэмүүд, алкалоидууд, стероид сапонинууд, стероидууд, кумаринууд; навчинд Е аминдэм, каритинууд; үрэнд сахар, органик хүчил, стероидууд, карденолидууд, тиогликозидууд, гичийн тос ба өөх тос агуулагдана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Энэ Баширын газар дээрх хэсгийн идээшмэл болон хандыг цусны даралт ихсэх өвчнийг анагаах иж бүрэн эмчилгээнд ашиглах ба умайн агшилт сулрах, төрсний дараа цус алдах сарын тэмдэгийн цус хэт ирэх зэрэг дотуур хэрэглэнэ.

Алагцэцэгт Баширийн хувьд жавхаалаг Башир-юмдүүжингийн адил орон нутгийн эмийн сан, мал эмнэлэгт түүж ашиглаж байна

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Жавхаалаг башир (согоо суман) адил түүж ашиглана.

## БИРЭШ

Латин нэр: *Vupleurum bicaule Helm.*

Монгол нэр: **Хоёр-ишт Бирэш**

Адилцаа нэр: Алтан агь, ямхан бэриш, бэриш өвс.

Орос нэр: Володушка двустебельная, володушка карликовая

Англи нэр: Acicular Thorowax

**Ангилалзүйн шинж:** Шүхэртэн-*Umbelliferae Juss.*-ийн овгийн 15-35 см өндөр иштэй олон наст өвслөг ургамал. Дээд хэсэгтээ салаалж мөчирлөсөн, заримдаа олон тооны нарийхан иштэй. Хатуу хурц, уртаашаа хуйлмал, шугам маягийн навчтай, жижиг шүхэр баг цэцэг нь шар цэцгүүдтэй болно(12-р зураг).

**Ургах орчин:** Уул толгодын чулуу, хайргатай хээр ба цөлийн хээрт тачир ургамал бүхий хээрийн нуга, хээр, хаданд болон түүний хажууд ургана.



12-р зураг. Хоёр-ишт Бирэш

13-р зураг. Хоёр-ишт Бирэшийн тархац

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай тойргуудад тархана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Дарьганга сумын Шилийн Богд ууланд ( $45^{\circ} 28' 307''$ ,  $114^{\circ} 34' 506''$ ), Эрдэнэцагаан сумын Зотол хаан ууланд ( $45^{\circ} 52' 342''$ ,  $115^{\circ} 03' 254''$ ), Ачаа уулаас хойшоо 6-7 км-т тус тус тохиолдоно (13-р зураг, 3-р хүснэгт).

**Гарц-нөөц:** Ачаа уулнаас хойт зүгт 6 км зайд, 5 га талбайд ср ариантай ургана.

**Биологийн идэвхит бодис:** Үндсэнд сапонин (улаан цогцос хайлуулах индекс 1200), кверцетин, изорамнетин, изокверцитрин, рутин, изорамнетин-3-рутинозид, антоцианууд байна. Газрын дээд хэсэгт флавоноид ихтэй, доорх хэсэгт кумарин уламжлалт бодис нилээд их байх ба үндсэндээ 0.30 % нийлбэр кумарин бодистой.

**Хэрэглээ үйлчилгээ:** Гашуун амттай хүйтэндүү чанартай; элгэн халууныг арилгах шарыг дарах, сарын тэмдэг тэгшитгэх, өвдөхийг зогсоох зэрэг чадалтай.

Элэгний өрөвсөл, цээж дүүрэх, хавиргаар хатгуулах, халуун хүйтэн ордослох, сарын тэмдэгийн хэм алдагдах, ходоод унжийсан, сав унжийсан, шүлхий өвчин зэргийг засна.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Хавар намар энэ ургамлын үндсийг авч цэвэрлээд хэрчиж хатааж хэрэглэнэ. Үндсийг ашигладаг учир гарц-нөөцийн нарийвчилсан судалгаа явуулах шаардлагатай.

## СӨӨГӨН БОРОЛЗГОНО

Латин нэр: *Potentilla fruticosa* L.= *Dasiphora fruticosa* (L.) Rydb.

Монгол нэр: **Сөөгөн Боролзгоно**

Адилцаа нэр: Тогооны угаалтуур, шүүр, боролзгонон шүүр, угаагуур, буриагуул.


Орос нэр: Курильский чай, пятилистник кустарниковый, лапчатка кустарниковая

Англи нэр: Bush Cinquefoil


**Ангилалзүйн шинж:** Эгц босоо, заримдаа өндиймөл, маш их салаархаг, 20-150 см өндөр сөөг. Залуу мөчир салаа торгомсог үсэрхэг, хөгшин мөчир улаан хүрэн юмуу саарал хуурдаг аолтостой. Навч 5-7 навчинцартай, тэдгээр тус бүр 10-15 мм урт, 1,5-8 мм өргөн, гонзгой юмуу өндгөрхүү. Цэцэг голдочоороо 1,5-3 см шар, нэг юмуу 3-7-оор салаа мөчрийн үзүүрт оршино. 6-8 сард цэцэглэнэ(14-р зураг, 3-р хүснэгт).

**Ургах орчин:** Ойт хээр, өндөр уулынбүслүүрт голын эрэг, гуу жалга, ам хавцил, сөөгөн ширэнгэ, нугархаг хажуу, бэл хормой, шинэсэн ой, тэдгээрийн зах, торлог, нураг, асга, бул чулуудын дунд ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуур, Говь-Алтайн тойрогт ургана.



14-р зураг. Сөөгөн Боролзгоно



15-р зураг. Сөөгөн Боролзгоно тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (15-р зураг, 4-р хүснэгт)

4-р хүснэгт

**Сөөгөн Боролзгоны тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Түмэнцогт	Баян цагааны урд уул	Агь-Алаг өвс-Үетэнт (Ботуульт)	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Толгойн ар хажуун дээд хэсэг. 47°32' 58.7", 112° 18' 36.7", 1085 м-т	Чулуусаг-алаг өвс-үетэнт	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Баян уулын ар хажуу	Сөөг бүхий үетэн-баялаг алаг өвс-ботуульт бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)

Түмэнцогт	Түмэнцогт ууланд	Баялаг алаг өвс-үетэнт	Дундад Халх (дорнод)
-----------	------------------	------------------------	----------------------

**Биологийн идэвхит бодис:** Үржлийн эрхтэн бүхий навчтай найлзуурт флавоноидууд агуулагдана. Газрын дээд хэсэгт кверцетин, кверцимеритрин, 3-0-β-L-рамнозид кверцетин тус тус илэрсэн. Иш, навч ба цэцэгт кофены хүчил; иш, навчинд цианидин, кемпферол, синапоны, ферулийн болон кумарын хүчлүүд; навч ба цэцгэнд эллагийн хүчил агуулна.

Мөн газрын дээд хэсэг, навч бүхий найлзуур, цэцэг навчинд эдээлгийн бодис; навчинд С аминдэм, каротинууд бий.

**Хэрэглээ үйлчилгээ:** Навч, цэцгийг цус тогтоох, идээ ундаанд дуртай болгох, мэдрэл-сэтгэцийн өвчин болон суулга татраах, цэцгийн чанамлыг бөөрний өвчинд хэрэглэнэ.

Эмийг хэтрүүлэн хэрэглэснээс үүссэн эмийн хордлого (дисбактериоз)-д, уг ургамлын хатаасан навч, цэцэгнээс цайны 1-2 халбагыг авч, аяга буцалсан усанд хийж, 30 мин хандална. Хүүхдэд хоолны 1-2 халбагаар өдөрт 3-4 удаа өгнө.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Энэ сөөг нь тархац-нөөцийн хувьд харьцангуй элбэг боловч цэцгийн ихээр бэлтгэх шаардлагагүй бөгөөд нөхөн сэргэлтийг дэмжих үүднээс нэг бутны тавны нэгийг, тухайн нэгж талбайн гуравны хоёрыг үлдээж бэлтгэх хэрэгтэй. Бэлтгэлийг зуны ургалтын үе буюу 6-7-р сард хайчилж бэлтгээд салхи чөлөөтэй нэвтрэх сүүдэр газарт нимгэн үелэж тараан хатаах ба эсвэл хатаагч шүүгээнд 60-70<sup>0</sup>С хэмд хатаана. Бор цаасан, даавуун болон таар уутанд 1 жил хадгална.

## БӨӨРӨЛЗГӨНӨ

Латин нэр: ***Rubus saxatilis* L.**

Монгол нэр: **Асганы Бөөрөлзгөнө**

Адилцаа нэр: Бөөрөлзгөнө

Орос нэр: Малина костяника, Рубус каменистый, Костянка каменистая

Англи нэр: Scree raspberrу

**Ангилалзүйн шинж:** Үндэслэг найлзуур бүхий босоо 15-20 см өндөр цэцэглэгч иштэй олон наст өвслэг ургамал. Мөлхөө бус, голлосон үндэслэг иш нь өргөстэй, тэр нь ихэвчлэн үндэслэдэг үржлийн бус урт нарийхан найлзуур болон навчилдаг босоо найлзуур төрүүлдэг. Навч гурвалсан, урт шилбэтэй, илтэс ромбон хэлбэртэй, ухаараа хотон, шүдтэй. Цагаан цэцгүүд голдуу



гурваас арваараа богино бамбай маягийн баг цэцэг үүсгэнэ. Жимс час улаан, цөөн (2-6) том яс буюу үртэй. Яс нь атираатай байдаг. 6-7-р сард цэцэглэж, үр жимс 8-9-р сард боловсроно(16-р зураг).

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай (төв, дорнод хэсэгт), Монгол Дагуур, Хянган, Дорнод Монгол.



16-р зураг. Асганы Бөөрөлзгөнө

17-р зураг. Асганы Бөөрөлзгөнийн тархац

**Ургах (тархацын) орчин:** Шинэсэн ба нарсан ой, холимог ой, хус болон улиангаран төгөл, жодоо-гацууран тайга, ойн захад ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (17-р зураг, 5-р хүснэгт).

5-р хүснэгт

#### Асганы Бөөрөлзгөнийн тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр, координат	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга*	Шилийн богд. 45° 28'15,1", 114° 34' 59,9". Д.т.д. 1685 м.	Хүрмэн чулуун дээр тогтсон хар хүрэн хөрстэй үетэн- алагөвст хажуу	Дорнод Монгол (Дарьганга)

\*- Шилийн Богд ууланд ургаж байгааг анх удаа тогтоов.

**Биологийн идэвхт бодис:** Асганы бөөрөлзгөнийн жимсэнд нь сахар, пектины бодис, аргаах бодис, органик хүчил, С витамин 44мг% (25-54 мг%, Батмөнх 1967), навчинд (жингээр) С витамин 0.15 мг%, фенольт нэгдэл, аргаах бодис, флавоноид 3.90 мг% агуулна. Эрхүү хотын ойролцоогоос түүсэн бөөрөлзгөний газрын дээд хэсэгт 0.59% кумаринт нэгдэл, 10.5-13.4% аргаах бодис, 0.36% С витамин, 5.45% давирхай, 5.5-10% арбутин байна (Телятьев,1976). Энэ ургамлын навч ишэнд алкалоид, флавноид, эдээлгийн бодис, рутин байдаг ажээ.

**Хэрэглээ үйлчилгээ:** Ногоон навчийг хатааж цайг орлуулж хэрэглэнэ. Жимсээр морс, желе, чанамал, сироп хийхэд ашиглах ба бялууны гол хийдэг. Асганы бөөрөлзгөнийн шүүс *Paramelum candatium*, *Balantidium Coli*, *Trichomonas hominis* зэрэг бүдүүлэг биетнийг үхүүлэх буюу муужруулах чадалтай. Шүүс нь

эдгээр (эгэл) бүдүүлэг биетнийг тэр дор нь буюу нэг минутын дотор үхүүлдэг байна (Фирчук, 1967).

Орос ардын эмнэлэгт зүрх, ходоод гэдэс өвдөх, чих дүнгэнэж шуугих, толгой өвдөх, ивэрхий, хавдар зэрэг өвчний үед хэрэглэнэ. Газрын дээд хэсгээр (иш, навч, цэцэг) усан ханд бэлтгэж багтраа, шамбарам зэрэг өвчнийг анагаахаар хэрэглэдэг ажээ. Мөөгөнцөртөж, хүрэн, тод шаргал толботой болсон навчийг айж ээрэх, багтрах зэрэг шинж тэмдэг бүхий өвчтэй хүмүүс хэрэглэдэг байна.

Белорусын ардын эмнэлэгт энэ ургамлын мөчир, жимсийг чанаж нүдний хүйтэн өвчнийг эмнэдэг ба толгойн хаг арилгах, үс сайн ургуулах зорилгоор толгой угаадаг байна. Бас хажирс өвчний үед толгой угааж, жимсийг ходоодны өвчин, бам анагаахаар хэрэглэнэ.

**Зохистой ашиглах, хамгаалахуй:** 6-р сарын дундуур, 9-р сарын үед түүсэн дээжид биологийн идэвхит бодис харьцангуй их байх тул энэ үед түүхий эд бэлтгэх нь зүйтэй.

## **БҮЙЛЭС**

Латин нэр: *Amygdalus pedunculata (Pall.) Maxim.*

Монгол нэр: **Бариулт Бүйлэс**

Адилцаа нэр: Буйлас.

Орос нэр: Миндаль черешковый

Англи нэр: Longstalk Peach

**Ангилалзүйн шинж:** Өргөсгүй мөчиртэй 0.5-1.5 м өндөр сөөг. Навчис гонзгойдуу тонгоруу өндгөрхүү, эсвэл гойнзгойдуу зууван, 2-3 см урт, шовх, хөрөөн-шүдлэг, сийрэг тачир үсэрхэг. Цэцэг тод ягаан навчлахаасаа өмнө дэлгэрдэг. Яст жимс нь 4-8 мм урт шилбэтэй. 5-6-р сард цэцэглэнэ. (18-р зураг).

**Ургах орчин:** Уул толгодын чулуурхаг хажуу, байц хад, ам хавцал, элсэрхэг хээр, их элсний зах, сайр садрагын адаг ба ирмэг дагаж ургана.



18-р зураг. Бариулт Бүйлэс



19-р зураг. Бариулт Бүйлэсний тархац

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Зүүнгар, Алашаагийн говь, Алтайн өвөр говийн тойргуудад ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (19-р зураг, 6-р хүснэгт).

6-р хүснэгт

**Бариулт Бүйлэсийн тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр, координат	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Сумын төвөөс урагш Холбоо нуур.	Үетэн- алагөвст элсэн манханы хажуу	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Баянголын эх Салаагийн элс	Элсэн манханы дундах булгийн дэргэдэх суль- үетэн- алагөвст хажуу	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Молцог элсэнд.	Элсэн манханы суль- үетэн- алагөвст хажуу	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Сумын төвийн хойно Алтан-Овоо тахилгат уул	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр	Сумын төвөөс 50 км-т, Онгон элсний баруун хойт үзүүрт.	Элсэн манханы дундах үетэн- алагөвст эвшил	Дорнод Монгол (Дарьганга)
Мөнххаан	Баян ууланд	Чулуусаг алагөвс- бүйлэст хажуу	Дундад Халх (зүүн)
Халзан	Гангын амны орой.	Чулуусаг алагөвс- бүйлэст хажуу	Дундад Халх (зүүн)
Дарьганга.	Холбоо нуурын элс.	Бургас- хайлаас бүхий үетэн- алагөвст элсэн довцог.	Дорнод Монгол (Дарьганга)

**Гарц-нөөц:** Гарц-нөөцийн судалгааны материал бүрдээгүй.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Түүхий эдийг бэлтгэхдээ эхлээд үрийг нь бүрэн боловсорсны дараа түүж аваад хатааж хэрэглэнэ.

**БУДАРГАНА**

Латин нэр: *Salsola collina* Pall.

Монгол нэр: **Толгодын Бударгана**

Адилцаа нэр: Бударгана, хамхаг хамхуул

Орос нэр: Солянка холмовая

Англи нэр: Common Russianthistle


**Ангилалзүйн шинж:** Дэргэвэр салаатай 10(20)-90(100) см өндөр, нэг наст өвслөг ургамал. Урт нарийнхан мөчиртэй ба хол хол байрлах урт (доод хэсэг нь утсархуу) навчтай. Цэцэг нь навчны өвөрт байрлаж, нарийнхан түрүүрхүү баг цэцэг үүсгэнэ. 7-10-р сард цэцэглэж, үрлэнэ(20-р зураг).

**Ургах (тархацын) орчин:** Хээр, уул, толгод, хайрга чулуутай энгэр, бэл, эргийн мараатай элс, хайрга сайрын элстэй ёроол, тариа ногооны талбай, айлын бууц, тарваганы дош, зам шуудууны хөвөөгөөр ургана.

**Монгол дахь тархац:** Хэнтий(өмнөд), Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Зүүнгарын говийн тойргуудад тархан ургана.



20-р зураг. Толгодын Бударгана



21-р зураг. Толгодын Бударгана

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (21-р зураг, 7-р хүснэгт).

7-р хүснэгт

### Толгодын Бударганын тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр, координат	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Наран.	Наран, Онгон сумдын зааг Дөрвөн зуугийн хоолой. 44° 51' 408", 113° 13' 459"	Дэрс- бударганат хөндий	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр.	Дөхөм баг, Бага төхөм, 2-р заставаас урагш 8 км-т. 45° 09' 224", 112° 30' 297"	Дэрс- бударганат хөндий	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Сумын төвөөс баруун тийш 14 км-т, Баянголын эх, Салаагийн элс. 45° 16' 197", 113° 44' 208"	Сулъ- хазаар өвс- харгана бүхий элсэн толгод.	Дорнод Монгол (Дарьганга)

**Биологийн идэвхт бодис:** Газрын дээрхи хэсэгт сальсолийн, сальсолидин зэргээс тогтсон нийт алкалоид 0,1 орчим, трицин, стерин ба тэдгээрийн гликозидууд буй.

**Хэрэглээ үйлчилгээ:** Уламжлалт эмнэлэгт цусан халууныг арилгах, цусны даралтыг бууруулах, тайвшруулах чадалтай. Анхдагч цусны даралтын үед хэрэглэхэд тустай.

**Зохистой ашиглах, хамгаалахуй:** Зун, намар газар дээрхи өвсийг хадаж аваад угааж цэвэрлэн хэрчээд хатааж хэрэглэнэ. Энэ зүйл ургамал тархацын хувьд хязгаарлагдмал боловч гарц-нөөцөөр харьцангуй арвин, түүнчлэн газрын дээд хэсгийг ашигладаг зэрэг нь байгалийн нөхөн сэргэлтэнд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр ашиглах боломжтой юм.

## БУРЖГАР

Латин нэр: *Thalictrum petaloideum* L.

Монгол нэр: **Дэлбэрхүү Буржгар**

Адилцаа нэр: Дэлбээрхүү буржгар, цөс өвс, цасан цэцэг, цагаан сийра,

Орос нэр: Василистник ложнолепестковый

Англи нэр: Petalformed Meadowrue

**Ангилалзүйн шинж:** Холтсонцэцэгтэн-Ranunculaceae Juss.-ийн овгийн эгц босоо иштэй, 30-40 см өндөр олон наст өвслөг ургамал. Навчны илтэс цэгээн, хоёр буюу гурав дахин өдөлж хуваагдсан, үзүүрийн илтэсний урт, өргөн 5-10мм, суурь луугаа шаантаг маягтай болж нарийссан буюу дугуйрсан, орой нь дугариг, бүтэн буюу 2-3 далбантай. Баг цэцэг цагаан, цэх, шигүү, бамбай хэлбэртэй. Дохиурын их бие (баруул) тээглүүрийн зүү адил, 2-5 мм урт, бүдүүн хавиргалаг-судалтай, үзүүр нь хурц, аажмаар дэгээ маягтай нумарсан шонтон болдог. VI сард цэцэглэж, VII сарын эхээс VIII сарын эх хүртэл үрлэнэ. (22-р зураг).



22-р зураг. Дэлбэрхүү Буржгар



23-р зураг. Дэлбэрхүү Буржгарын тархац

**Ургах орчин:** Голын хөндий, эргийн хээржүү нуга, хайргат ба чулуурхаг хажуу хээр, хуурайжуу ойн цоорхой, шинэсэн ой, ойн нуга, уулын хээр, сөөгөн ширэнгэ, шугуй, эргийн хайрганд ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур. Дорнод Монгол, Хянганы тойргуудад ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (23-р зураг, 8-р хүснэгт).

8-р хүснэгт

### Дэлбэрхүү Буржгарын тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр, координат	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хан уул. 45° 52' 342", 115° 03' 254"	Бэсрэг уулсын хүрмэн чулуун дээр тогтсон хөрстэй үетэн- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Талын Агуй	Талын хүрмэн чулуун дээр тогтсон хөрстэй хялгана- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богдын энгэр хажуу. 45° 28' 307", 114°34'506"	Сөнөсөн галт уулын хүрмэн чулуун дээр тогтсон хөрстэй алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)

**Хэрэглээ үйлчилгээ:** Цэцэг нь гашуун амтлаг бөгөөд бүлээн чанартай. Шингэц ширүүн, цасан цэцэг, цагаан сийра зэрэг нэрээр ханиахыг зогсоох, хийг дарах, илчийг үүсгэх, уушигны халуун, бадгана, голын хий өвчин, анагаах болон хоолны шингэцийг сайжруулах зорилгоор хэрэглэдэг.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Зуны сүүл, намрын эхээр үр жимсийг авч шавар шороог угаан цэвэрлээд хэрчиж хатаан хэрэглэнэ. Жимсийг хураан авч наранд хатааж, намар үндсийг бэлтгэн хэрчиж жижиглэн хатааж хэрэглэнэ.

Латин нэр: *Thalictrum foetidum L.*

Монгол нэр: **Үмхий Буржгар**


Адилцаа нэр: Өмхий буржгар, буржгар, огор

Орос нэр: Василистник вонючий

Англи нэр: Meadowrue, Glandularhairy Meadowrue

**Ангилалзүйн шинж:** Холтсонцэцэгтний овог-Ranunculaceae Juss-т хамаарах олон наст өвслөг ургамал. Үндэслэг иштэй, үмхий үнэртэй булчирхайгаар бүрхэгдсэн иш нь 15-30 см өндөр. Навч жижиг, шүдлэг захтай, дугариг өндөг, гурвалсан болон дөрвөлсөн өдлөг хэлбэртэй. Сийрэг залаа баг цэцэгтэй. Дохиур олон. Жимс суумал, өндөгөрхүү ба зууван хэлбэртэй. V сарын сүүлчээс VIII сар хүртэл цэцэглэж, VI-IX сард үрлэнэ. (24-р зураг).

**Ургах орчин:** Байц цохио, хайргат юмуу чулуурхаг хээржүү хажуу, сийрэг хуурай шинэсэн ой, түүний чөлөөнд ургана.



**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Дорнод Монгол, Дундад Халх, Их Нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Монгол Алтай, Говь-Алтайн тойргуудад ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (25-р зураг, 9-р хүснэгт).

9-р хүснэгт

#### Үмхий Буржгарын тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр, координат	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хан уул.	Хүрмэн чулуу дээр тогтсон хөрстэй үетэн-алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Талын Агуй	Хүрмэн чулуу дээр тогтсон хөрстэй үетэн-алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богдын энгэр хажуу	Хүрмэн чулуу дээр тогтсон хөрстэй үетэн-алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Ачаа уулнаас хойт зүгт 7 км-т, 45° 28'14", 114° 31' 09,4". Д.т.д. 1563 м.	Үетэн- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)

**Гарц-нөөц:** Ойролцоогоор 10 га талбайд жигд бус тархан ургадаг.

**Гарц-нөөц:** Нөөцийн судалгаа хийх материал бүрдээгүй.

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээрх өвслөг эрхтэн хэсэгт алкалоид (фетидин, магнофлорин, тальфин, тальфинин, берберин), флаваноид 1.05% хүртэл, рутин, гликозид глюкорамнин, кумарин, давирхай, органик хүчлүүд агуулагддаг.

**Хэрэглээ үйлчилгээ:** Үндсийг нь яр шарх, боом эмчлэхэд мөн халуун намдаах, хорыг тайлах, бам дүмбийг арилгах, цусны халууныг сэрүүн болгох, нян хөнөөх, суулга зогсооход. Няан халуун, төрөлхийн элэгний халуун, нянгаар

овойх, халдварт өвчин, нүдний цагаан нүх сүвэнд нян тархах, суулгах өвчнийг анагаахад хэрэглэдэг.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Цэцэглэлтийн үед нь өвсийг /газар дээрх хэсгийг/ бэлтгэж муудсан хэсэг, элдэв хольцоос цэвэрлэн сүүдэрт хатааж хэрэглэнэ. Газрын дээд хэсгийг түүхий эдэд бэлтгэх тул тодорхой талбайд 4-6 жил сэлгэж бэлтгэвэл зохино.

Латин нэр: ***Thalictrum simplex L.***

Монгол нэр: **Энгийн Буржгар**

Адилцаа нэр: Эгэл буржгар, Цөс өвс, огор

Орос нэр: Василистник простой

Англи нэр: Slimtop Meadow-rue

**Ангилалзүйн шинж:** Холтсонцэцэгтэн-Ranunculaceae Juss.-ийн овгийн 60-70см өндөр эгц иштэй, олон наст өвслөг ургамал. Шаантагархуу уртавтар хэсгүүд болж цуулбарлагдсан, хосолсон өдлөг суумал буюу богино бариултай навчтай. Баг цэцэг хавчигар нарийн уртассан, цагаан өнгөтэй, хааяа улаан туяатай. Дохиур унжгар. VI сард цэцэглэж, VII сарын эхээс VIII сарын эх хүртэл үрлэнэ(26-р зураг).

**Ургах орчин:** Ойт хээрийн бүсэд уулын энгэр /ойн зах/, голын нуга /татам/, эргийн нуга, сөөгөн ширэнгэ, татмын ой, шинэсэн ой, хусан төгөл тэдгээрийн чөлөө, ойн нуга, эргийн хайрга, нугажуу хээрт ургана. Улаан толгойт-түнгэ-биелэг өвс- ботуульт эвшилд мөн үетэн, хялгана-улалж-хиагт эвшилд тохиолдоно.

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хөвсгөл, Монгол Дагуур, Дорнод Монгол, Дундад Халх, Хяangan, Их нууруудын хотгор, Монгол Алтай, Говь Алтай, Зүүнгарын говийн тойргуудад ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Эрдэнэцагааны Зотол хан уулын өмнө хэсэгт үетэн-элдэвөвст хэсэгт ургана(27-р зураг).





26-р зураг. Энгийн Буржгар



27-р зураг. Энгийн Буржгарын тархац

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэг цэцэглэсэн үедээ нийлбэр алкалоид 0.60%-0.77% агуулна. Тальфетидин, тальсимин, тальсимидин, гернандезин, берберин, таликсин,  $\beta$ -аллокриптопин, магнофлорин, таликсимидин, таликтрисин, таликмнинин зэрэг алкалоидтой.

**Хэрэглээ үйлчилгээ:** Цэцэг, үндсийг нь гэдэсний халдварт хижиг анагааж, халуун намдаахад хэрэглэнэ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Цэцэглэлтийн үед хөрснөөс 5-8 см өндөрт хайчлах юмуу хадуураар хадаж бэлтгэн гэмтэж муудсан хэсэг, элдэв хольцоос цэвэрлэн сүүдэр газар хатааж хэрэглэнэ. Газрын дээд хэсгийг түүхий эдэд бэлтгэх тул тодорхой талбайд 4-6 жил сэлгэж, бэлтгэлийн талбайн буржгарын 1/5-ыг үлдээж байх хэрэгтэй.

## ГАЛУУН ТАВАГ

Латин нэр: *Chiazospermum erectum L.=Hypocoum erectum L.*

Монгол нэр: **Цэх Галуунтаваг**


Адилцаа нэр: Барбад, парба

Орос нэр: Гипекоум прямой

Англи нэр: Erect Hypocoum

**Ангилалзүйн шинж:** Нарийн туяхан иштэй нэг наст цайвар ногоон ургамал. Үндэс орчмийн навчис урт бариултай, илтэс гонзгой, 5-10 см урт, хошоод цуулбар өдлөг, саарал өнгөтэй. Иш 5-25 см өндөр навчгүй, эсвэл баг цэцгийнхээ угт утсан салбанцар бүхий суумал бяцхан навчистай. Цэцгүүд шар, ишний үзүүрийн дихазийг (хослож салаалсан баг цэцэг) үүсгэнэ. Цоморлиг 5-6 мм урт; дэлбийн гадаад хэлтэс 1.5 см урт; хонхорцог эгц босоо, 4-7 см урт; 1-2 мм өргөн. Үр хар өнгөтэй, дөрвөлжиндүү хавтгай хажуу талдаа хэрээс маягийн төвгөр хээтэй. (27-р зураг, 9-р хүснэгт)

**Ургах орчин:** Элсэрхэг тал, чулуурхаг ба хайргат хээржүү хажуу, байц, хуурай голдирол, эргийн хужирлаг нугад ургана.



28-р зураг. Цэх Галуунтаваг



29-р зураг. Цэх Галуунтавагийн тархац

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Дорноговийн тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (29-р зураг, 10-р хүснэгт).

10-р хүснэгт

**Цэх Галуунтавагийн тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр, координат	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан.	Лаг нуураас баруун урагш 48 км-т, Эрдэнэцагаан орох замд. 46° 20' 307", 115° 45' 382"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Холбоо нуур. Холбоогийн элс. 45° 14' 066", 114° 08' 108"	Бургас- хайлаас бүхий үетэн- алагөвст элсэн довцог.	Дорнод Монгол (Дарьганга)
Сүхбаатар.	Дорнодын Матадаас баруун тийш 108 км-т, Түмэнцогтоос Матад сум орох замд.	Хялгана- шарилж- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)
Сүхбаатар.	Сумын төвөөс зүүн тийш 34 км-т. Матадаас Сүхбаатар орох замд	Хялгана- шарилж- алагөвст хээр	Дорнод Монгол (умарт)

**Хэрэглээ үйлчилгээ:** Хүнсний дээд зэргийн балт ургамал. Цэцэг, навчийг элэгний цочмог архаг үрэвсэл, цэсний өвчин, шарлах өвчинд хэрэглэж байжээ. Ардын эмнэлэгт их халдвартай хижиг, ханиад эмчилэхэд хэрэглэнэ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Газрын дээд хэсэг буюу цэцэг, навчийг түүхий эдэд бэлтгэхдээ уг талбайг 4-6 жил сэлгэж бэлтгэх ба бэлтгэлийн талбайн 1/5-ыг үлдээж байх хэрэгтэй.

Түүхий эдийг бэлтгэхдээ эхлээд үрийг нь түүж аваад дараа нь нас гүйцсэн болон хөгшин туйпланцарын үндсийг ухаж авах бөгөөд залуу ургамлын үндсийг ухаж авалгүй үлдээж нөхөн сэргээлтийг хангах нь уг ургамлыг ховордон устахаас сэргийлнэ.

## ГАНГА

Латин нэр: *Thymus gobicus Tschern.*

Монгол нэр: **Говийн Ганга**

Адилцаа нэр: Ганга


Орос нэр: Тимьян гобийский, Чабрец гобийский

Англи нэр: Gobian Thyme

**Ангилалзүйн шинж:** Иш үл мэдэгдэм дөрвөн талтай, бүхэлдээ үсэрхэг, 2-5 см өндөр, ёзоороороо салаалсан, газраар ширэлдэн ургадаг заримдөг сөөгөнцөр. Навч дээд гадаргуудаа олон үец бүхий урт сийрэг үслэгтэй боловч доод гадарга нь нүцгэн, 10-12 мм урт, 2-3 мм өргөн, гонзгойвтор-юлдэн, гонзгойвтор-шугаман хэлбэртэй. Баг цэцэг толгойрхуу бөгөөд нягт, хөхөвтөр-ягаан юмуу ягаан өнгийн, анхилуун үнэр бүхий цэцэгтэй(30-р зураг).



30-р зураг. Говийн ганга



31-р зураг. Говийн гангын тархац

**Ургах орчин:** Ойт хээрийн бүсэд бол уулын чулуурхаг хайргат хажуу, нураг, байц; говийн бүсэд бол цөлийн хээр, эргийн хайрга, элсэнд ихэвчлэн ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл (өмнөд), Хангай, Монгол Дагуур, Монгол Алтай (Тайширын уул, Хасагт Хайрхан), Дундад Халх, Дорнод Монгол (Шилийн Богд уул), Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Говь-Алтайн тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (31-р зураг, 11-р хүснэгт).

11-р хүснэгт

### Гангын тархац, ургах эвшил

Сум	Газрын байршил	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Шилийн Богд уул	Чулуусаг алагөвс- агь-хазаарт	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Холбоогийн элсэнд	Харгана бүхий алаг өвс-үетэнт	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Монгол элс., 45° 10'56,1", 114° 05' 40,6". Д.т.д. 1334 м.	Алаг өвс-хазаар өвс-хялганат	Дорнод Монгол (Дарьганга)

Эрдэнэцагаан	Холбоо, Залаа уулын хойт хөндий	Чулуусаг алагөвс- агь- хазаарт	Дорнод Монгол (Дарьганга)
Наран	Молцог элс	Алагөвс- агь- сулыт манхан	Дорнод Монгол (Дарьганга)
Наран	Гурван модотын цар., 45° 00' 59,1", 113° 57' 23,3". Д.т.д. 1471 м	Алагөвс- агь- сулыт манхан	Дорнод Монгол (Дарьганга)
Онгон	Молцог элсний хойт хөндий	Алаг өвс-хазаар өвс- хялганат	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр	Онгон элс	Харгана- үетэн- алаг өвст	Дорнод Монгол (Дарьганга)
Халзан	Сумын төвөөс зүүн хойш 10 км-т.	Алаг өвс-хазаар өвс- хялганат	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	Баянцагааны урд ууланд. 47° 46' 0.18", 112° 23' 57.5", 966 м-т	Агь-Алаг өвс-Үетэнт (Ботууульт)	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Баян овоо уулын хойд талын тэгш орой. 47°32' 44.5", 112° 18' 49.6", 1078 м-т	Чулуусаг алагөвс- агь- хазаарт	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°37'087", 112°25'018", 975 м-т	Харгана бүхий алаг өвс- улалж-үетэнт	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°27'013", 112°17'504", 1052 м-т	Алаг өвс-хазаар өвс- хялганат	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°27'057", 112°17'434", 1026 м-т	Алаг өвс-том хялгана- хазаар өвст	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Баян ууланд 46° 52' 07.7", 112°08'103", 1331 м-т	Сөөг бүхий үетэн-баялаг алаг өвс-ботууульт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	47°15'062", 112°10'998", 1178 м-т	Алаг өвс-ганга-улалжит	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	47°12'969", 112°12'691", 1208 м-т	Алаг өвс-ганга-улалжит	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	46°52'433", 112°07'308", 1306 м-т	Алаг өвс-үетэн-крыловийн хялганат	Дундад Халх (зүүн)
Асгат	Шарга уул. 46° 23'41,1", 113° 21' 20,4". Д.т.д 1205 м	Алаг өвс-үетэн- хялганат	Дундад Халх (зүүн)

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгтээ пинен, камфен, сэбинен, мирцан, лимонен, 1.8-цинеол, терпинен, цимол, камфор, линалоол, терпинен-4-ОЛ, кариофиллен, борнеол, тимилацетат, карвакрилацетат, тимол, карвакрол зэрэг эфирийн тос, флавоноид, тритерпеноид агуулдаг.

**Хэрэглээ үйлчилгээ:** Анагаах ухааны эмнэлэгт гангын ханд, хандмалыг уушигны өвчин, цэр ховхлох, агшилтын эсрэг (спазмын эсрэг), толгойн өвчин (неврит), ууц нурууны өвчин (радикулит), үе мөчний өвчин зэрэгт хэрэглэнэ.

Монгол эмнэлэгт Thymus-ийн төрлийн ургамлуудыг ходоод гэдэс болон амьсгалын замын өвчний үед цэр ховхлох, халуун бууруулах зорилгоор дотуур мөн арьсны өвчинд гадуур хэрэглэдэг байна.

Газрын дээд хэсгийн хандаар сэргээх үйлдэлтэй “Тэрэлж” ундааны жоронд ордог. Мөн ханиад, цэр ховхлох зориулалтаар хэрэглэдэг “Чигатусин” хэмээх эмийн найрлаганд ордог.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Цэцэг дэлгэрсэн үед өвс буюу газрын дээд хэсгийг хайчилж аваад хатаж өгөршсөн, гэмтэж муудсан, хатаж шарласан зэрэг элдэв хольцоноос цэвэрлэж хатаагаад хэрчиж хэрэглэнэ. Түүхий эдийг бэлтгэхдээ эхлээд нас гүйцсэн болон хөгшин иш навчийг авах бөгөөд залуу ургамлыг авалгүй үлдээж нөхөн сэргээлтийг хангах нь уг ургамлыг ховордон устахаас сэргийлнэ.

## ГАНДБАДРАА

Латин нэр: *Veronica incana L.*

Монгол нэр: **Буурал Гандбадраа**

Адилцаа нэр: Гандбадраа

Орос нэр: Вероника седая


Англи нэр: Ash-grey Vetch

**Ангилалзүйн шинж:** Иршимбийн овгийн (10)20-50(60) см өндөр иштэй олон наст өвслөг ургамал. Навчис эсрэг байрлалтай, өндгөрхүү юмуу гонзгой, 1.5-10 см урт, 0.5-2 см өргөн, эсгийрхэг цагаан үсжилттэй, ирмэг нь үл мэдэгдэм жижиг-гүдэнтэй. Баг цэцэг 3-10(30) см урт, 1.2-1.5(2) см өргөн. Цэцэг суумал, зөвхөн доодз хэсгийн цэцэг 1-2 мм урт шилбэтэй (32-р зураг).

**Ургах орчин:** Уулын хээржсэн хажуу, хээрийн нуга, шинэсэн төгөл болон нарсан ойн захад ургана.



32-р зураг. Буурал Гандбадраа



33-р зураг. Буурал Гандбадраагийн тархац

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх (умарт хэсэг), Дорнод Монгол, Говь-Алтайн (Гурван Сайхан, Гурван Богд) тойрогт тархан ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** сумын ууланд ургана(33-р зураг, 12-р хүснэгт).

**Гандбадраагийн тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Шилийн Богд	Агь-алаг өвс-үетэнт	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	Усны хуримтлал ихтэй хоёр гүвээний хоорондахь хөндий жалга 47°42'38.7", 112° 23' 14.9", 920 м	Алаг өвс-түнгэт хээр	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Баянцагааны уул	Агь-алаг өвс-үетэнт (Ботуульт)	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°37'087", 112°25'018", 975 м-т	Харгана бүхий алаг өвс-улалж-үетэнт	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°18'514", 112°12'104", 1004 м-т	Алаг өвс-агь-хазаар өвст	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Дэлгэрийн нуураас баруун тийш 2-4км	Агь-хазаар өвс-крыловын хялганат	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Баян уулын орой	Баялаг алаг өвс-үетэнт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)

**Гарц-нөөц:** Сүхбаатар аймагт хязгаарлагдмал тархацтай учир нөөцийн судалгаа хийгдээгүй.

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт апигенин, лютеолин, цинарозид бүхий флавоноидууд, түүнчлэн кофейнын болон хлоргенийн фенолкарбоны хүчил бий. Газрын доод хэсэгт сапонинууд, мөн газрын дээд хэсэгт кумаринууд, сапонинууд, алкалоидууд, ирдоидууд, карденолидууд; навч, цэцгэнд алкалоидууд, С аминдэм, каротинууд агуулагдана.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Сүхбаатар аймагт хязгаарлагдмал тархацтай учир хамгаалалтанд авах шаардлагатай.

**ГАЗРЫН ХАР-ҮС**

Латин нэр: *Nematonostoca flagelliforme (Bert. et Curt.) Elen.*

Монгол нэр: **Газрын Хар-үс**

Адилцаа нэр: Газрын хар-өвс, хар үс, газрын үс, зодог өвс

Орос нэр: Земляные волосы, черные волосы

Англи нэр: Flagelliforme Nematonostoc

**Ангилалзүйн шинж:** Хөрсөн дээр ургадаг газрын хар-үс хэмээх хөх ногоон замаг нь хөрсний өнгөн хэсэгт бэхлэгдэхгүй оршдог. Хүрэндүү туяа бүхий ногоовтор хүрэндүү өнгөтэй.

Газрын үс хөх ногоон замгийг микроскопоор харахад шаравтар хүрэндүү утаслаг бие шардуу өнгийн бүрхүүлээр хучигдсан байх бөгөөд, өөр хоорондоо нягт байрласан, эгнээ бүхий цайвар шаравтар эсүүдтэй байна(34-р зураг).



34-р зураг. Газрын хар-үс



35-р зураг. Газрын хар-үсний тархац

**Ургах орчин:** Хар-үс замаг нь Зүүнгарын бударгана, бор бударгана, толгодын бударгана, ахар навчит баглуур, таана зонхилж, орог тэсэг, шар хотир, шарилж, манан хамхаг, харгана, дэрс дэд зонхилогч бүхий эвшилд ургадаг болох нь тогтоогдов.

**Тархац-байршил:** Монгол орны цөл, цөлөрхөг хээрийн бүс буюу ургамал-газарзүйн Дорнод Монгол, Дорноговь, Алашаагийн говь, Говь-Алтай, Олон нуурын хөндийн тойргуудад, засаг захиргааны хуваариар Дорнод, Сүхбаатар, Дорноговь Өмнөговь, Баянхонгор, Өвөрхангай аймагт ургана. Дорноговь аймагт Өргөн, Эрдэнэ, Хөвсгөл, Хатанбулаг сумдын нутгуудаар тархан ургасныг тогтоов( -р зураг, -р хүснэгт).

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (35-р зураг, 13-р хүснэгт).

13-р хүснэгт

### Газрын Хар-үсний тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Зүүн булагт	Бударгана-манан хамхаг-таана ( <i>Reaumuria soongorica</i> , <i>Salsola passerina</i> , <i>S. sollina</i> , <i>Bassia dasyphylla</i> , <i>Allium polyrrhizum</i> ) зонхилсон бударганат эвшилд	Дорнод Монгол (Дарьганга)
Наран, Онгон сумын зааг	Дөрвөн зуугийн хоолойд 44° 51' 408"; 113° 13' 459"	Бударгана-манан хамхаг-таана ( <i>Reaumuria soongorica</i> , <i>Salsola passerina</i> , <i>S. sollina</i> , <i>Bassia dasyphylla</i> , <i>Allium polyrrhizum</i> ) зонхилсон бударганат эвшилд	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр	Заставаас баруун урагш 45° 09' 224"; 112° 30' 297", мөн хилийн дагуу 45° 05' 121"; 112° 08' 020" , 45° 06' 666"; 112° 07' 322"	Бударгана-таана ( <i>Reaumuria soongorica</i> , <i>Salsola passerina</i> , <i>S. sollina</i> , <i>Allium polyrrhizum</i> ) зонхилсон бударганат эвшилд	Дорнод Монгол (Дарьганга)
Наран	Хар тойром. 44° 56' 57,3", 113° 53' 53,2".	Бударгана- таана ( <i>Reaumuria soongorica</i> , <i>Allium polyrrhizum</i> ) зонхилсон бударганат эвшилд	Дорнод Монгол (Дарьганга)

**Гарц нөөц баялаг:** Монгол орны газрын үс-замгийн тархац-байршлын ихэнх хэсэг нь Дорноговь аймгийн улсын хил дагуу орших бөгөөд гарц-нөөцийн хувьд гол цөм нь мөн энд ургана. Сүхбаатар аймгийн хувьд Дарьганга, Онгон, Баяндэлгэр сумдын нутагт 100 га талбайд sol аривтай ургана.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Хар-үс нь Монгол Улсын “Ургамлын тухай хууль” болон “Улаан ном”-нд орсон нэн ховор ургамал бөгөөд хадгалалт, хамгаалалтын бүх талын арга хэмжээ авах шаардлагатай, цаашид дэлхий болоод монголд дулаарал, хуурайшилт явагдаж байгааг харгалзан түүхий эд бэлтгэлийн зөвшөөрөл олгохгүй байх хэрэгтэй юм.

### ГИЧГЭНЭ

Латин нэр: *Potentilla tanacetifolia Willd. ex Schlecht.*

Монгол нэр: **Маралнавчит Гичгэнэ**

Адилцаа нэр: Маралзгананавчит гичгэнэ, маралхайнавчит гичгэнэ, туулайн тагнайдуу гичгэнэ,

Орос нэр: Лапчатка рябинолистная

Англи нэр: Tansyleaf Cinquefoil

**Ангилалзүйн шинж:** Сэрэвгэр үсээр өвч хучигдсан, навчирхаг шулуун 30-50 см өндөр иштэй олон наст өвслөг ургамал. Навчис өрөөсгөл өдлөг 3-6 хос навчинцартай, налчгар ширүүн ба урт ширүүн сормослог үс холилдсон, навч нь гонзгойвтор юмуу тонгоруу-юлдэрхүү, захаараа том хурц шүдлэг, цэцэг голчоороо (8)10-18 мм, шар өнгөтөй. Баг цэцэг бамбай хэлбэртэй(36-р зураг).

**Ургах орчин:** Хялгана, харгана-хялганат, элдэвөвс-үетэнт хээр, уулын чулуурхаг-хайргархаг хажуу, хээрийн сөөгөн ширэнгэнд ургах чийгсүү-хуурайсаг ургамал.

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Дорноговийн тойрогт ургадаг.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (36-р зураг, 14-р хүснэгт).

14-р хүснэгт


### Маралнавчит Гичгэний тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хан уул. 45° 52' 342", 115° 03' 254"	Чулуусаг алаг өвс агь-хазаарт	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Лаг нуураас баруун урагш 43 км-т, Эрдэнэцагаан орох замд.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Холбоо нуур. Холбоогийн элс.	Бургас- хайлаас бүхий	Дорнод Монгол



	45° 14' 066", 114° 08' 108	үетэн- алагөвст элсэн довцог.	(Дарьганга)
Дарьганга	Холбоогийн элсэнд	Алаг өвс- үетэнт бүлгэмдэл	Дорнод Монгол (Дарьганга)
Сүхбаатар, Дарьганга. 2007.	Сумын төвөөс зүүн урагш 16 км-т. Ганга нуурын дэргэд Оргихын булаг. 45° 16' 000", 113° 59' 507"	Улалж- үетэн- алагөвст нуга.	Дорнод Монгол (Дарьганга)
Мөнххаан	Мөнххаан ууланд	Баялаг алаг өвс-үетэнт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Баян ууланд	Сөөг бүхий үетэн- алаг өвс-ботуульт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	47°42' 46.1", 112° 12'58.3", 1171 м-т	Харгана бүхий түнгэ-хялганат бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°43' 19.2", 112°31'58.1", 928 м-т	Агь-тарна-хялганат	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°41' 35.1", 112° 29' 24.3", 929 м-т	Алаг өвс-ерхөг-том хялганат	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Баян овоо ууланд	Чулуусаг алаг өвс агь-хазаарт	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Их талхлагдсан сумын төвийн ойролцоох тэгш тал	Шарилж-хазаар өвст-үетэн	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Толгод хоорондын хөндий. 47° 44' 20.8", 112°18'08.1", 937 м-т	Алаг өвс-хиагт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт.	Сумын төвөөс зүүн урагш 44 км-т, Яргайт уулын ар. 47° 22' 835", 112° 43' 295"	Хялгана- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)

**Гарц-нөөц:** Сүхбаатар аймагт хязгаарлагдмал тархацтай учир нөөцийн судалгаа хийгдээгүй.



35-р зураг. Маралнавчит Гичгэнэ

36-р зураг. Маралнавчит Гичгэнийн тархац

**Биологийн идэвхит бодис:** Нийлбэр полифенол навчинд 8.73%, ишэнд 3%, цэцгэнд 15.6%, газар доорхи хэсэгт 10.2% байна. Газар дээрх хэсэгт глюкозид; бүх эрхтэнд кофейн хүчил; навч, ишэнд синапын болон ферулын хүчил, цэцгэнд эллагийн хүчил байна.

Цахиур, кальци, магни, фосфор нилээд ихтэй, хорь шахам бичил ба үлэмж язгуур махбод агуулдагийн дотор титанийг ихээр агуулдаг онцлогтой.

Арьс идээлэн будах, будаг жигдрүүлэх, дүүргэхээр ашиглаж болох ургамал гэдэг нь нотлогдсон.

**Хэрэглээ үйлчилгээ:** Цусны халуун, судлын халуун, уушигны өрөвсөл, бор өвчин, цусаар бөөлжих, цусаар хахирах, цусаар баах, дагшуур хатиг, хавдар зэргийг засна.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Зун, намар үндэс буюу газрын дээд хэсгийг авч цэвэрлээд хэрчин сүүдэр газар хатааж хэрэглэнэ.

## ГИШҮҮНЭ

Латин нэр: *Rheum undulatum L.*

Монгол нэр: **Долгиотсон Гишүүнэ**

Адилцаа нэр: Гишүүнэ, цоор, цооргоно, гишүүнэ, жумз

Орос нэр: Ревень волнистый


Англи нэр: Walyleaved Rhubarb, Bucharian Rhubarb

**Ангилалзүйн шинж:** Тарна-Polygonaceae Juss.-ын овогт хамаарах олон наст ургамал. Доод хэсэгтээ урт зайдам бүхий үетэй, 1.6 м хүртэл өндөр иштэй, хүрэн хайрст бүдүүн бахим үндэстэй. Захаараа үрчгэр атриа бүхий 30 см (заримдаа 60 см) урт, 30 см хүртэл өргөн, зүрхэрхүү суурьтай өндгөрхүү цөөн тооны (ихэвчлэн хоёр) том далвагар навчтай. Ишний навч үүнтэй ижил хэлбэртэй боловч хэмжээгээрээ жижиг байна. Улбар ногоондуу юмуу заримдаа шаргал жижиг цэцэгтэй. Тэдгээр нь ишний оройд салаалсан залаа маягийн урт залаа баг цэцэг үүсгэнэ. Цэцгийн шадар эрхтэн гагцхүү дэлбээнээс тогтсон энгийн бүтэцтэй. 6-7-р сард цэцэглэж, 7-8-р сард үр болосорно(37-р зураг, 14-р хүснэгт).

**Ургах орчин:** Хээрийн бүс, уулын ойн ба ойт хээрийн бүслүүрт уулын хажуу, чулуу, хадтай энгэр, хормой, бэл, эрэг, мөргүү, тарваганы дош, айлын бууц, гуу жалга, эргийн хайрганд мөн түүнчлэн голын эргийн шугуй, сөөг, эрэг орчмын чийгтэй нугад хүртэл ургана. Заримдаа дэд тагийн бүслүүрт ургана. Дээрх ургах орчинд алаг цоог буюу уулын хээрийн үетэн-алаг өвст эвшилд тохиолдоно.



37-р зураг. Долгиотсон гишүүнэ



38-р зураг. Долгиотсон гишүүний тархац

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорноговь, Говь-Алтайн тойргуудад тохиолдоно.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (38-р зураг, 15-р хүснэгт).

15-р хүснэгт

**Долгиотсон Гишүүний тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хаан уулын зүүн урд хөндийд жалга, судгаар.	Алаг өвс-агь-хазаар өвст	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	6-р заставаас 7-р замтав орох замын 28 км-т.	Хялгана- алагөвст хээр	Дорнод Монгол
Эрдэнэцагаан	Зотол хаан уул. 45° 52' 342", 115°03' 254"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Зотол хаан уул. 45° 48' 396", 114° 43' 231"	Таана- үетэнт уулын нуга.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Зотол хаан уулаас урагш 32 км-т, Рашаант нуурын баруун урд.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Зотол хаан уулаас урагш 38 км-т, Рашаант нуурын баруун урагш Шилийн Богд орох замд.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Зотол хаан уулаас урагш 44 км-т, Рашаант нуурын баруун урагш Шилийн Богд орох замд.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Зотол хаан уулаас урагш 48 км-т, Рашаант нуурын баруун урагш Шилийн Богд орох замд. 45°35' 327", 114° 30' 540"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уул	Чулуусаг алаг өвс-хялгана бүлгэмдэл	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Эрээн толгой, Ачаа уулын хээрийн бүсийн чулуурхаг толгод, тарваганы тош зэрэг газарт	Алаг өвс-том хялгана-агьт бүлгэмдэл	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уулаас зүүн хойш 17 км-т, Талын агуй. 45° 35' 237" 114° 30' 029"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уулаас зүүн хойш, Талын агуйгаас урагш 5 км-т, Шилийн Богд орох замд.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уул. 45° 28' 307" 114° 34'506"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уулаас баруун тийш 10 км-т.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт.	Сумын төвөөс зүүн урагш 44 км-т, Яргайт уулын ар. 47° 22' 835",	Хялгана- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)

	112°43' 295"		
Түмэнцогт	47°18'514", 112°12'104", 1004 м-т	Алаг өвс-агь-хазаар өвст	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Талын шандын хөндийд	Алаг өвс-том хялганат бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)

**Гарц-нөөц:** Дарьганга сумын Шилийн богд уулын орчим нийт 15 га талбайд sol ариантай ургана.

**Биологийн идэвхит бодис:** Баг цэцэг, үндсэнд нилээд хэмжээний флавноидтай. Үндсэнд кальци, магни, төмөр, хөнгөн цагаан, фосфор, натри нилээд агуулсан 20 орчим эрдэс бодис түүнчлэн эмодины моногликозид  $C_{21}H_{20}O_{10}$  агуулна. Гишүүний үндсэнд хоёр янзын гликозид байдаг. Навч, цэцгэнд флавант нэгдэл, В<sub>2</sub>, С, Е аминдэм, каритон, пектинүүд, алим нимбэг, хурган чихний хүчил буй. Манай оронд ургадаг долгионтсон гишүүний үндсэнд 10-11% орчим аргаах бодистой.

**Хэрэглээ үйлчилгээ:** Үндэс, навчны шилбэ, цоорыг эм, хүнсэнд өргөн хэрэглэнэ. Гишүүний үндсийг бага тунгаар хэрэглэхэд суулга тогтоох ба дунд тун нь цөс ялгаруурж, их тун нь туулгах үйлдэлтэй. Үндэсний бэлдмэл нь Bact. proteus vulgaris, Bact. subtilis, Bact. friedlandri зэрэг нянгийн өсөлтийг саатуулах үйлдэлтэй нь тогтоогдсон.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Гишүүний үндсийг намар ухаж аваад дагавар жижиг үндэс, ишний үлдэгдлийг огтлон хаяж, том үндсийг усанд түргэн угаагаад хэрчиж жижиглэн наранд тавьж бага зэрэг сэрээсний дараа салхий ордог дулаан байр буюу төмөр дээртэй байшингийн таазан дээр эсвэл гадаа хатаана. Түүхий эдийг бэлтгэхдээ эхлээд үрийг нь түүж аваад дараа нь нас гүйцсэн болон хөгшин үндсийг ухаж авах бөгөөд залуу ургамлын үндсийг ухаж авалгүй үлдээж нөхөн сэргээлтийг хангах нь уг ургамлыг ховордон устахаас сэргийлнэ.

## ДАЛАНТҮРҮҮ

Латин нэр: ***Stellera chamaejasme L.***

Монгол нэр: **Одой далантүрүү**

Адилцаа нэр: Чонын хөлбөдөс, малгай өвс, түвэг залаа

Орос нэр: Стеллера карликовая

Англи нэр: Chinese Stellera

**Ангилалзүйн шинж:** Далан түрүүтний овгийн 20-40 см өндөр, нүцгэн иштэй олон өвслөг ургамал. Үндэслэг иш модлог, хар хүрэн, 40-50 см урттай. Навчис суумал гонзгой зуувгар, 3-8 мм өргөн, 17-30 мм урт. 20-25 цэцэг бүхий

толгой баг цэцэгтэй. Дохиур 10, хоёр хүрээгээр байрлана. Үрэвч зуван, оройдоо цомцогтай бөгөөд амсар бөөрөнхий, бараг суумал. 5-8 сард цэцэглэнэ (39-р зураг).

**Ургах орчин:** Чулуурхаг хээр, хавцал, ой хээрийн нуга, ойн захад ургана

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай (дорнод хэсэг), Монгол Дагуур (баруун хэсэг), Хянган, Дорнод Монгол (умард хэсэг)

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (40-р зураг, 16-р хүснэгт).

16-р хүснэгт

### Долгиотсон Гишүүний тархац, ургах эвшил

Дарьганга	Шилийн Богд уул. 45° 28' 307", 114° 34' 506"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Талын Агуй	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	Сумын төвөөс зүүн урагш 44 км- т, Яргайт уулын ар. 47° 22' 835", 112° 43' 295"	Хялгана- элдэвөвст хээр	Дундад Халх (дорнод)



39-р зураг. Одой далантүрүү

40-р зураг. Одой далантүрүүний тархац

**Биологийн идэвхит бодис:** Үндсэнд 1,87%-ийн кумаринууд олдсон бөгөөд сфондин, изобергаптен, пимпинеллин болон изопимпинеллин зэрэг агуулагдана. Газрын доод хэсэгт флавоноидууд бий. Мөн өвсэнд органик хүчлүүд, сапонинууд, каротинууд, С амин дэм, үндсэнд сахар, органик хүчилүүд сапонидууд, өөх тос тус тус агуулагдана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Үндсийг хоолойн өвчин, ангин, уушигны өвчнүүдийг эмчлэх эмийн найрлаганд орно. Цэцгийг ходоод гэдсний өвчинд хэрэглэнэ.

### ДОГОР

Латин нэр: *Caryopteris mongolica Bunge.*

Монгол нэр: **Монгол Догор**

Адилцаа нэр: Догор, ямаанэвэр, агаруу, сургир


Орос нэр: Кариоптерис монгольский

Англи нэр: Mongolian Bluebeart

**Ангилалзүйн шинж:** Богино цагаан (буурал) үслэгтэй, нарийн мөчир бүхий намхан сөөг. Дээд гадгаргуу ногоон, доод гадгаргуу цагаан өнгөтэй, нарийссан суумал, юлдэн навчис нь ишиндээ чагталж байрлана. Бундуужих үедээ хөх байснаа дэлгэрэхдээ хөхөвтөр ягаан болдог дөрвөлжин жижиг салбантай, гадна тал нь өтгөн үслэг бүхий дэлбээтэй цэцгүүд бамбай баг цэцэг үүсгэн мөчрийн оройд байрлана. Үр жимс торолсон судалтай, гонзгойватор хэлбэртэй далавчитай (41-р зураг).

**Ургах орчин:** Уулын хээр, хээр, заримдаг цөл, цөлийн бүсэд асга хад, чулуу хайргатай уул толгодын хажуу, наран ээвэр энгэр, сайрын дагуу, элс хайргатай судгийн хөвөө, ёроол дагаж, сул элстэй газар ургадаг.

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуурын хөндий, Дорноговь, Сүхбаатар, Алтайн өвөр говь, Алашаагийн говийн тойргуудад тархана.



41-р зураг. Монгол Догор

42-р зураг. Монгол Догорын тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (42-р зураг, 17-р хүснэгт).

17-р хүснэгт

### Монгол Догорын тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Мөнххаан	Баян ууланд	Сөөг бүхий алаг өвс-ерхөг-хялганат	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Баянцагаан ууланд	Агь-Алаг өвс-Үетэнт (Ботууульт)	Дундад Халх (зүүн)
Уулбаян	Гурван модотын ам	Хялгана-сэдэргэнэ-түнгэ-таанат	Дундад Халх (зүүн)
Баяндэлгэр.	Сумын төвөөс 50 км-т, Онгон элсний баруун хойт үзүүрт. 45° 35' 59", 112° 49' 039"	Харгана- үетэн-алагөвст цөлөрхөг хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр.	Дэлгэрэх баг. Сумын төвөөс баруун урагш 20 км-т. Д.т.д. 948. 45° 35' 001", 112° 21' 845"	Хялгана- шарилж-алагөвст хээр	Дундад Халх (дорнод)

**Биологийн идэвхит бодис:** Газарын дээд хэсэгт гиполаетин-7-гликозид зэрэг флавоноид, гликозид 0,65%, алкалоид, сапонин, аргаах бодис 5,5%, эфирийн тос 0,1-1,07% тус тус агуулагдах ба үндсэнд тритерпеноид бий.

**Хэрэглээ үйлчилгээ:** Хүйтэн хийг арилгах, дурыг нээх, бадганыг арилгах, бие махбодыг сайжруулах зэрэг чадалтай. Эс шингэж дуршил хаагдсан, хоолой сөөх, уушигны хийн хаван, мөгөөрсөн хоолойн архаг үрэвсэл, хүйтэн хий өвчин, халуун хүйтэн харшсан хэрх өвчин зэргийг засна.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Цэцэгтэй мөчрийг авч наранд хатааж хэрэглэнэ.

## ДЭГД

Латин нэр: *Gentiana decumbens L.*

Монгол нэр: **Хэвтээ Дэгд**

Адилцаа нэр: Төмөр дэгд, үхэр дэгд

Орос нэр: Горечавка лежачая

Англи нэр: Decumbant Gentian

**Ангилалзүйн шинж:** Дэлбээний салбангуудын завсар хуниастай олон наст өдслөг ургамал. Ишний уг унасан навчны ширхэглэг угларгаар хучигдмал. Навч шугаман-юлдэрхүү, 8-15(20) см урт, 6-15(22) мм өргөн. Цэцгийн дэлбэ хөх. Үрэвч богино шилбэтэй. (43-р зураг).

**Ургах орчин:** Ихэвчлэн ойт хээр, хээрт нугархаг ба хээржүү хажуу, хээрийн ба эргийн нуга, чулуурхаг хажуу, нураг, эргийн хайрганд ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хяangan, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Говь-Алтай, Зүүнгарын говийн тойргуудад тус тус тархан ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** сумын элдэв өвстэй уулын хээрт ургадаг болохыг тогтоолоо. (44-р зураг, 18-р хүснэгт).


18-р хүснэгт

### Хэвтээ Дэгдийн тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Шилийн Богд уулын зүүн хойно	Чулуусаг алагөвст- үетэнт	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	Талын шандын хөндийд	Алаг өвс-том хялганат	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Баян ууланд	Сөөг бүхий үетэн-баялаг алаг өвс-ботуульт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Дарьганга.	Шилийн Богд уул. 45°28' 307", 114° 34'506"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт.	Сумын төвөөс зүүн	Хялгана- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)

	урагш 44 км-т, Яргайт уулын ар. 47° 22' 835", 112° 43' 295"		
--	---	--	--

**Гарц-нөөц:** Сүхбаатар аймагт харьцангуй цөөн цэгт тархсан. Нөөцийн судалгаа хийгдээгүй.



43-р зураг. Хэвтээ дэгд

44-р зураг. Хэвтээ дэгдний тархац

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт 6.1-10.6% флавоноидууд агуулагдана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Газрын дээд хэсгийг ходоод гэдэсний архаг үрэвсэл, цэсний хүүдийн үрэвсэл, ядаргаанд, амьсгалын замын өвчинүүд, шар зэрэг элэгний өвчинд хэрэглэнэ.

## СИБИРЬ ЕРӨНДГӨНӨ

Латин нэр: *Vincetoxicum sibiricum* (L.) Decne.

Монгол нэр: **Сибирь Ерөндгөнө**

Адилцаа нэр: Тэмээн хөх

Орос нэр: Ластовень сибирский

Англи нэр: Siberian Vincetoxicum

**Ангилалзүйн шинж:** Эгц босоо, 15-20 см өндөр иштэй, энгийн салаалалтай олон наст өвслөг ургамал. Навч 4-7 см урт, 3-4 мм өргөн, шугаман эсвэл шугаман зууван хэлбэртэй. Цэцэг жижиг, цайвар шар өнгөтэй(45-р зураг).

**Ургах орчин:** Хээр, говийн бүсэд чулуурхаг энгэр, хайргархаг сайр, жижиг манхан элс ба элсэрхэг хээрт ургана.

**Монгол дахь тархац:** Хангай (дорнод), Монгол Дагуур, Хянгaн, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говь





45-р зураг. Сибирь Ерөндгөнө



46-р зураг. Сибирь Ерөндгөний тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (46-р зураг, 19-р хүснэгт)

19-р хүснэгт

### Сибирь Ерөндгөний тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Мөнххаан	Баян ууланд	Сөөг бүхий алаг өвс-ерхөг-хялганат	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	46°44'545", 112°12'552", 1071 м-т	Үетэн-таанат эвшил	Дундад Халх (дорнод)
Асгат	Шарга уул. 46° 23'43,4", 113° 21' 15,9". Д.т.д. 1162 м.	Шарга уулын чулуурхаг баруун энгэрийн үетэн-таанат эвшил	Дундад Халх (дорнод)

**Хэрэглээ үйлчилгээ:** Сибирь ерөндгөний газар дээрх хэсэг, жимсний ханд нь цусны даралт түр бууруулах үйлдэлтэй эмнэлзүйн судалгаагаар илрүүлсэн бөгөөд уламжлалт эмнэлэгт ходоодн цочмог, архаг үрэвсэл, цусан суулга зэрэг өвчин анагаахад хэрэглэдэг.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Энэ ургамал нь Байгалийн ургамлын тухай хуулийн (1995) нэн ховор ургамлын жагсаалтанд орсон, Монголын ургамлын улаан данс ба хамгааллын төлөвлөгөөний эмхэтгэлд (2012) өргөн тархацтай бөгөөд одоогоор энэ зүйл ургамал дээд аюул занал нүүрлээгүй тул Анхааралд өртхөөргүй гэсэн зэрэглэлд багтаав.

### ЖИРГЭРҮҮ

Латин нэр: *Saposhnikovia divaricata* (Turcz.) Schischk.

Монгол нэр: **Дэрэвгэр Жиргэрүү**

Адилцаа нэр: Гонид, хонин шүүр, шүхэргэнэ, хонин шүхэр, зэгнэ


Орос нэр: Сапожниковия (Ледебуриелла) распоныренная

Англи нэр: Divaricate Saposhnikovia

**Ангилалзүйн шинж:** Шүхэртний овогт хамаарах олон наст өвслөг ургамал. Эгц доош орсон бүдүүн үндэстэй. Үндэс орчмын навчис олон, бариул

богино, хавтгай. Иш сууриасаа эхлэн олонтоо салаалсан, 30-80 см өндөр. Навчны илтэс гонзгой, 6-20 см урт, 2-4 см өргөн, хошоод юмуу гурвантаа хагалбар өдлөг, хөх ногоон өнгөтэй. Ишний үзүүрт байрладаг шүхэр баг цэцэг нь баринтаггүй. Шүхэр 6-7 шилбэтэй. Шүхрэнцэр 4-10 цэцэгтэй. Дэлбэ цагаан, нүцгэн. Үр жимс нүцгэн, өндөг хэлбэртэй, 5-6 мм урт, 3 мм орчим өргөн, тод илэрсэн хавиргатай(47-р зураг).

**Ургах орчин:** Ойт хээр, хээрийн бэсрэг уулс, дов толгодын хайргархаг, чулуурхаг хээржүү хажуу, хуурай хээрийн түнгэ-элдэвөвс-шивээт хялганат эвшилд ургана. Мөн хялгана-элдэвөвс-гүйлс оролцсон бэлчээрт, хааяа атаршсан тариан талбайд хөл газрын (хогжуулагч) ургамал болж ургадаг.



**Монгол дахь тархац:** Монгол оронд ургах ерөнхий тархац нь Хэнтий, Монгол дагуур, Дорнод Монгол, Хянганы тойрог бөгөөд Хангайн тойргийг зүүн хэсэгт, Дундад Халхын тойргуудад ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (48-р зураг, 20-р хүснэгт).

20-р хүснэгт

**Дэрэвгэр Жиргэрүүгийн тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Сүхбаатар	Сумын төвөөс зүүн тийш 50 к-т, Матад явах замд	Үетэн- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Зотол хан уул, Рашаант нуурын орчим	Сөөг бүхий алаг өвс-ерхөг-хялганат	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Талын агуй	Үетэн- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд	Чулуусаг алагөвст- үетэнт	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Гангын цагаан овоо	Чулуусаг алагөвст- үетэнт	Дорнод Монгол (Дарьганга)
Мөнххаан	Чандмань уулаас баруун хойш 15 км	Агь-хазаар өвс-хялганат	Дундад Халх (зүүн)

Мөнххаан	Баян уулын өвөр хажуу	Сөөг бүхий алаг өвс-ерхөг-хялганат	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	46°52'433", 112°07'308", 1306 м-т	Алаг өвс-үетэн-крыловийн хялганат	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°41'35.1", 112° 29' 24.3", 929 м-т	Алаг өвс-ерхөг-том хялганат	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Талын шандын хөндийд	Алаг өвс-том хялганат	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°18'514", 112°12'104", 1004 м-т	Алаг өвс-агь-хазаар өвст	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Сумын төвөөс хойш 5-6 км-т	Алаг өвс- агь-хялганат	Дундад Халх (зүүн)

**Гарц-нөөц:** Түмэнцогт суманд нутагт төв зам дагуу тариан талбайн захаар болон уулын толгодын хөндийд хялгана, саман ерхөг-шарилж-элдэвөст (*Stipa sibirica*, *S. krylovii*, *Potentilla tanacetifolia*, *Thermopsis dahurica*) эвшилд ургана.

- Энд нийт ойролцоогоор 6 х 4.5 км<sup>2</sup> талбайд ургана. 10 х 10 м<sup>2</sup>-д 4.2 ш ургамал бол 14.7 гр (агаарын хуурайгаар) үүнээс га-д 1.5 кг; 2700 га талбайд биологийн нөөц 4050 кг-аас үйлдвэрлэлийн нөөц нь 3240 кг болно. Үүнээс байгаль цаг уурын нөхцөл, ургамлын нөхөн сэргэлт, ашиглалтын зохион байгуулалт зэргээс хамаарч 1 жилд 648 кг буюу 0.6 т бэлтгэж болно.

Эрдэнэцагаан сумын Рашаант нуураас баруун тийш Цулхар уулын баруун хөндий, үетэн-шарилж-элдэвөст хээрт sol арвитай тархан ургана.

- 2 х 1 км<sup>2</sup> талбайд ургана. 10 х 10 м<sup>2</sup>-д 1 ш ургамал бол 3.5 гр (агаарын хуурайгаар) үүнээс га-д 0,35 кг; 200 га талбайд биологийн нөөц 0,07 кг-аас үйлдвэрлэлийн түүхий эд бэлтгэх боломжгүй болно

Дарьганга сумын Шилийн Богд уул болон Талын агуй орчмын хөндий, үетэн-шарилж-элдэвөст хээрт sol арвитай тархан ургана.

- 3 х 1 км<sup>2</sup> талбайд ургана. 10 х 10 м<sup>2</sup>-д 1.6 ш ургамал бол 4.2 гр (агаарын хуурайгаар) үүнээс га-д 0.42 кг; 300 га талбайд биологийн нөөц 0.12 кг-аас байгаагаас түүхий элийн бэлтгэл явуулах боломжгүй болно.

Мөн сумын Гангын Цагаан овооноос зүүн тийш үетэн-элдэвөст хөндийд sol арвитай тохиолдоно.

- 2.5 х 1.5 км<sup>2</sup> талбайд ургана. 10 х 10 м<sup>2</sup>-д 3.1 ш ургамал бол 11.9 гр (агаарын хуурайгаар) үүнээс га-д 1.19≈1.2 кг; 375 га талбайд биологийн нөөц 0.45 кг-аас үйлдвэрлэлийн нөөцгүй болно.

**Биологийн идэвхит бодис:** Газар доорхи хэсэг /үндэс/ алкалоид 0.08% хүртэл; цэцэг алкалоид, флавант гликозид, сапонин; үр алкалоид, эфирийн тос;

навч алколоид; газар дээрх хэсэг (өвс) кумарин, флавоноид агуулдаг. Үрэнд эфирийн тос 0.05мл /100g. хүртэл агуулагдаг.

**Хэрэглээ үйлчилгээ:** Дэрэвгэр жиргэрүүгийн үндсийг Дорнын уламжлалт анагаахад даарч хөрснөөс хатгалга туссан үед халуун болон толгойн өвчин намдаах, хөлөргөх, *arthritis, myositis, paralysis* - саа, *neuralgia*- мэдрэлийн эмгэг, *fever* - үргэлжилсэн буюу даамай халуурах, чичрэх зэрэгт хэрэглэдэг.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Түүхий эд бэлтгэх ажлыг атаршиж буй болон атаршсан талбайгаас зохих зөвшөөрөл, технологийн дагуу, тухайн газар нутагт нь сөрөг нөлөө үүсгэлгүйгээр, орон нутгийн захиргаатай урьдчилан тохиролцсоны үндсэн дээр хавар (4 дүгээр сарын сүүлч, 5 дугаар сарын эхээр); намар (8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр), зориулалтын багажийн тусламжтай гүйцэтгэж, сүүдэрт, ус чийг, шороо тоосгүй нөхцөлд хатааж савлан хадгалах юмуу тээвэрлэнэ.

Дэрэвгэр жиргэрүү нь хялгана- агь- шарилжит болон хялганат хээрт ургадаг байгалийн унаган төрхөөрөө буй цэгүүдээс түүхий эд бэлтгэлийг хоригловол зохино. Учир нь:

1. Түүний газар доорх хэсэг (үндэс) - ийг түүхий эдэд бэлтгэдэг.
2. Хялганат хээрийн хөрс нь хөнгөн бүтэцтэй байдаг тул хөрсний элэгдэлд хялбар өртөх сөрөг талтай.
3. Байгалийн нөхцөлд ургаж буй жиргэрүүний үндэс (түүхий эдийн) гарц багатай байдаг.

## **ЗАНГУУ**

Латин нэр: *Tribulus terrestris L.*

Монгол нэр: **Зэлэн Зангуу**

Адилцаа нэр: Нохой зангуу, наангий зангуу, хэвтээ зангуу, хээрийн зангуу

Орос нэр: Якорцы наземные, якорцы стелющиеся

Англи нэр: Puncturevine Caltrap

**Ангилалзүйн шинж:** Мөчирлөн салаалсан 50 см хүртэл урт дэлхээ иштэй, тавчилсан шаравтар цэцэг нь нэжгээдээр байрласан, олон наст өвслөг ургамал. Навчис 6-8 хос өдлөг, дээд тал нүцгэн, доод тал нь ишний адил урт үсэрхэг. Үр жимс нь бөөрөнхий, хуурай нэг үрт 5 хэсэг болон салдаг. Хэсэг тус бүрт хурц хатгууртай.(49-р зураг).

**Ургах орчин:** Цөл, цөлөрхөг хээр, хээрт талхлагдсан бэлчээр, суурин газар, зам дагуу, худаг орчим, мөн сайр элстэй ёроолоор ургана.

**Монгол дахь тархац:** Хангай (өмнөд), Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаа говь, Зүүнгарын говийн тойргуудад тархсан.



49-р зураг. Зэлэн зангуу

50-р зураг. Зэлэн зангуугийн тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (50-р зураг, 21-р хүснэгт).

21-р хүснэгт

### Зэлэн Зангуугийн тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга.	Сумын төвийн захиргааны хашаан дотор.	Алагөвст эвшил.	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр.	Сумын төвөөс 50 км-т, Онгон элсний баруун хойт үзүүрт. 45° 35' 596", 112° 49' 039"	Харгана- үетэн-алагөвст цөлөрхөг хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Халзан.	Аймгийн төвөөс урагш 16 км-т, Баруун-Уртаас Дарьганга орох зам дагуу Хар худагийн дэргэд	Үетэн- алагөвст хээр.	Дундад Халх (дорнод)
Баяндэлгэр.	Дэлгэрэх баг. Сумын төвөөс баруун урагш 20 км-т. 45° 35' 001", 112° 21' 845". Д.т.д. 948.	Хялгана- шарилж-алагөвст хээр	Дундад Халх (дорнод)
Баяндэлгэр.	Дэлгэрэх багийн төв. Адгийн худаг.	Хялгана- шарилж-алагөвст хээр	Дундад Халх (дорнод)

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт, мөн жимсэнд 0.32%-ийн флавоноидууд агуулагдана. Өвсөнд рутин, кемпферол, жимс ба навчинд кемпферол, 3-глюкозид болон 3-рутинозид кемпферол хийгээд трибулозид агуулагддаг болохыг тогтоосон. Жимсэнд кумаринууд бий. Түүнчлэн үндэс газрын дээд хэсэг болон үр жимсэнд стероидын сапонинууд, навчинд С аминдэм, жимсэнд нүүрс-ус, алкалоидууд, үрэнд өөх тос бий.

**Хэрэглээ үйлчилгээ:** Монгол, Түвд уламжлалт анагаах ухааны эмнэлгийн олон эмийн найрлагад ордог. Бөөр, давсагны өвчинд шээс хөөх, хаван бууруулах хэрэглэдэг. Хятад эмнэлэгт жимсийг биеийн эсэргүүцэл сайжруулахад, үрийг сарын тэмдэг алдагдахад хэрэглэнэ. Орос эмнэлэгт газрын дээд хэсгийн бэлдмэлийг судасны хатуурлын эсрэг хэрэглэнэ.

## ЗЭЭРГЭНЭ

Латин нэр: *Ephedra sinica Stapf.*

Монгол нэр: **Нангиад Зээргэнэ**


Адилцаа нэр: Ямаан зээргэнэ

Орос нэр: Эфедрa китaйскaя

Англи нэр: Chinese Ephedra

**Ангилалзүйн шинж:** Олон үе зайдмалтай, бараг хэвтээ найлзууртай 10-20 см өндөр мөнх ногоон сөөг. Ногоон мөчрийн орой тахийж мушгирсан байна. Жимс нь махлаг улаан өнгөтэй, 2 үртэй. (51-р зураг, 21-р хүснэгт)

**Ургах орчин:** Монгол орны цөлийн хээрт зонхилон тархсан боловч хээрийн бүсэд энд тэнд алаг цоог тохиолдоно. Хайргатай хээр, толгодын хайрга чулуутай энгэр хормой, бэл газар ургасан байдаг.



51-р зураг. Нангиад зээргэнэ

52-р зураг. Нангиад зээргэнийн тархац

**Монгол дахь тархац:** Хангай, Монгол Дагуур, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтайн тойрогт тархан ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (52-р зураг, 22-р хүснэгт)

22-р хүснэгт

### Нангиад Зээргэний тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Лаг нуур охчим	Алаг өвс- шарилж- хазаар өвст	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Лаг нуураас баруун урагш, 6 км-т.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	2-р заставаас зүүн тийш 1 км-т	Хялгана- алагөвст хээр	Дорнод Монгол
Эрдэнэцагаан	Эрдэнэцагаанаас баруун тийш 18 км-т, Зотол хаан уул орох замд.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Эрдэнэцагаанаас баруун тийш 42 км-т, Зотол хаан уулын зүүн талд.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Зотол хан уул. 45° 52' 342",	Алаг өвс-үетэн-хазаар	Дорнод Монгол

н	115° 03' 254"	өвст	(Дарьганга)
Дарьганга	Холбоо нуур. Холбоогийн элс. 45° 14' 066", 114° 08' 108"	Бургас- хайлаас бүхий үетэн- алагөвст элсэн довцог.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Сумын төвийн хойно, Алтан-Овоо тахилгатай уул. 45° 18' 284", 113° 50' 248"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр	Онгон-Баяндэлгэр сумдын заагт Онгон элсэнд	Алаг өвс-шарилж-хазаар өвст	Дундад Халх (зүүн)
Баяндэлгэр	Сумын төвөөс 50 км-т, Онгон элсний баруун хойт үзүүрт. 45° 35' 596", 112° 49' 039"	Харгана- үетэн- алагөвст цөлөрхөг хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	47°37'053", 112°24'485", 968 м-т	Алаг өвс-шарилж-хазаар өвст	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Талын шандын хөндийд	Алаг өвс-том хялганат	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	46°52'266", 112°07'109", 1279 м-т	Амугдалус бүхий чулуусаг алаг өвс-сонгино-крыловийн хялганат	Дундад Халх (зүүн)
Халзан	Яргайтын ам, 46° 16'28,1", 113° 07' 20,2". Д.т.д. 1194 м	Алаг өвс-шарилж-хазаар өвст	Дундад Халх (зүүн)
Асгат	Шарга уул. 46° 23'41,2", 113° 21' 21,6". Д.т.д. 1207 м	Алаг өвс-шарилж-хазаар өвст	Дундад Халх (зүүн)
Сүхбаатар.	Сумын төвөөс зүүн тийш 26 км-т. Матадаас Сүхбаатар орох замд. 46° 48' 567", 114° 12' 079"	Хялгана- шарилж-алагөвст хээр	Дорнод Монгол (умарт)

**Гарц- нөөц:** Наран сумын Цагаан уулын урд хээрт 1 м<sup>2</sup> талбайд 20-30 бут тохиолдох бөгөөд нийт тархсан талбай 10 х 18 км<sup>2</sup>, нутгийн малчин Ц.Балчинпүрэвийн ам мэдээгээр Мандал толгойд энэ зээргэнэ элбэг ургадаг.

Асгат сумын Шарга уулсаар 2,5 га-д талбад sol ариантай ургана.

**Биологийн идэвхит бодис:** Ногоон мөчирт эфедрин (85%), псевпоэфедрин (15%) зэргээс тогтсон алкалоид 0.6-1.3% , эпикатехин, эпигаллокатехингаллат, эпикатехингаллат зэргээс тогтсон катехин 0.1%, каротин 20 мл/кг байна.

**Хэрэглээ үйлчилгээ:** Дэлүү элэгний халууныг арилгах, усан хаван, хавдар хариах, шарх ангаах, ханиах, амьсгаадахыг дарах, шээлгэх, хөлөргөх зэрэгт хэрэглэнэ.

Латин нэр: ***Ephedra equisetina Bunge.***

Монгол нэр: **Шивлээхэй Зээргэнэ**

Адилцаа нэр: Морин зээргэнэ, хар зээргэнэ


Орос нэр: Эфедрин хвоцевидная

Англи нэр: Mongolian Ephedra

**Ангилалзүйн шинж:** Эгц босоо, 30-100 см өндөр сөөг. Илэрхий мэдэгдэм гол иштэй, гөлгөр, хөх ногоон эгц, шулуун огцом дээш чиглэсэн багц мөчир салаатай. (53-р зураг).

**Ургах орчин:** Уул толгодын хад, чулуутай хажуу, сайрын чулуурхаг ирмэгээр ургасан байдаг.

**Монгол дахь тархац:** Хангай(өмнөд хэсэг), Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Дорноговь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаагийн говь, Зүүнгарын говийн тойрогт тархан ургана.



53-р зураг. Шивлээхэй зээргэнэ

54-р зураг. Шивлээхэй зээргэнийн тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (54-р зураг, 23-р хүснэгт)

23-р хүснэгт

### Шивлээхэй Зээргэний тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Алтан-Овоонд. 45° 18'42,2", 113° 50' 10,4". Д.т.д. 1355 м.	Алаг өвс- шарилж- үетэнт (харганатай) эвшил	Дорнод Монгол (Дарьганга)
Наран	Цагаан уулын урд хээрт. 45°10'31,5", 110°08'05,0". Д.т.д. 1199 м,	Алаг өвс- үетэнт (харганатай) эвшил	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	Баянцагаан ууланд	Алаг өвс- үетэнт (харганатай) эвшил	Дундад Халх (зүүн)
Асгат	Шарга уул. 46° 23'43,4", 113° 21' 14,7". Д.т.д. 1193 м.	Шарга уулын чулуурхаг баруун энгэрийн үетэн-таанат эвшил	Үетэн-таанат эвшил

**Гарц- нөөц:** Наран сумын Цагаан уулын урд хээрт 1 м<sup>2</sup> талбайд 20-30 бут тохиолдох бөгөөд нийт тархсан талбай 10 х 18 км<sup>2</sup>, нутгийн малчин Ц.Балчинпүрэвийн ам мэдээгээр Мандал толгойд энэ зээргэнэ элбэг ургадаг.

**Биологийн идэвхит бодис:** Ногоон мөчирт эфедрин (90%), псевпоэфедрин (10%) зэргээс тогтсон алкалоид 2.3-2.5%, лейкоантоцианид, лейкодельфинидин, лейкоэфедрин, катехин зэргээс тогтсон идээлгийн бодис 8-14.04% байна.



**Хэрэглээ үйлчилгээ:** Зээргэний найрлагатай эм нь цус тогтоох, усан хаван, хавдар хариах, шарх анагаах, ханиах, амьсгаадахыг дарах, шээлгэх, хөлөргөх чадалтай.

## МОГОЙН ИДЭЭ

Латин нэр: *Sedum aizoon L.*

Монгол нэр: **Үлдэн Могойн идээ**

Адилцаа нэр: Могойн идээ

Орос нэр: Очиток живучий

Англи нэр: Aizoon Stonecrop

**Ангилалзүйн шинж:** Crassulaceae DC. - Зузаалайн овогийн Бүдүүн, богинохон үндэслэг иштэй ургамал. Иш цөөвтөр, эгц босоо, 25-45 см өндөр. Навчис цувраа байрласан, 5-8 см урт, юлдэрхүү, ирмэгээрээ жигд бус шүдэрхэг, шаантган суурьтай. Баг цэцэг бамбайрхуу хавтгайдуу, ишний үзүүрийн олон навчаар хүрээлэгдсэн. Цэцэг 5 илтэстэй, алтан шаргал өнгөтэй. VIII-IX сард үрлэнэ. (55-р зураг)

**Ургах орчин:** Тайга, уулын ойт хээрийн бүсэд нураг чулуу, уулын чулуурхаг хажуу, хад асга, голын элсэрхэг-хайрган хөрсөнд ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд (Түргэн уул), Монгол Алтай, Дундад Халх (Хойт хэсэг), Дорнод Монгол, Дундад Халх, Олон нуурын хөндий, Говь-Алтайн (Гурван Богд, Гурван Сайхан) тойргуудад тархана.



55-р зураг. Үлдэн Могойн-идээ

56-р зураг. Үлдэн Могойн-идээний тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (56-р зураг, 24-р хүснэгт)

24-р хүснэгт

### Үлдэн Могойн идээний тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаа	Зотол хан уул	Сөөг бүхий үетэн- алаг өвст	Дорнод Монгол

н		эвшил	(Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд ууланд	Агь- үетэн- алаг өвст эвшил	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Ачаа уул	Агь- үетэн- алаг өвст эвшил	Дорнод Монгол (Дарьганга)
Наран	Баяндулаан уул	Агь- үетэн- алаг өвст эвшил	Дундад Халх (зүүн)
Асгат	Шарга уул. 46° 23'41,2", 113° 21' 21,6". Д.т.д. 1192 м	Алаг өвс-шарилж-хазаар өвст	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Мөнххаан ууланд	Баялаг алаг өвс-үетэнт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Баян ууланд	Сөөг бүхий үетэн-баялаг алаг өвс-ботуульт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Түмэнцогт ууланд	Баялаг алаг өвс-үетэнт	Дундад Халх (зүүн)

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт полифенолт нэгдэл 4.5%, флавоноид агуулна. Мөн газрын дээд хэсэгт глюкоз, фруктоз, сахароз, кумарин, эфирийн тос 4.33% агуулагдана. Хурган чихний, гликолийн, алимны, хувны, фумарын хүчил зэргүүдийг агуулна. Мөн газрын дээд хэсэгт нийт органик хүчил 9.6%-иас чөлөөт хүчил 3.6%, полифенол 6.5%, арбутин 2.0%, стероид, антрагликозид, тритерпений хүчил, сапонин бий. Газрын доод хэсэгт органик хүчил, стероид, антрагликозид, тритерпений хүчил, сапонин агуулагдана. Навчиндаа 3% арбутинтай. Навч болон цэцгэнд органик хүчил, алкалоид, С аминдэм илрүүлсэн.

**Хэрэглээ үйлчилгээ:** Навч болон өвснөөр бэлтгэсэн усан ханд нь цусны даралт багасах, цус тогтоох, шархыг аниулах, үрэвслийн эсрэг үйлчилгээ үзүүлнэ. Зүрхний ажиллагааг сайжруулах, ясны бэртэлтийг эмчилэх, мөн найруулсан хандаар гадуур идээт шархыг угаах ба ууц нурууны өвчин (радикулит)-д шавшиж хэрэглэнэ.

Дотор гэмтэж цус гарах, цусаар бөөлжих, өтгөн цустай гарах, хавдаж өвдөх, тайвшруулах, нойр хулжих зэргийг эмчилнэ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Зун цэцэглэж байх үед газар дээрх хэсгийг авч, цэвэрлээд шинэ нойтноор буюу хэрчиж хатааж (60-70°C-ийн хэмд), модон сав болон таар уутанд хийж 2 жил хадгална.

## МОНОС

Латин нэр: *Padus asiatica Kom. =P. avium Mill.*

Монгол нэр: **Ачлагийн Монос**

Адилцаа нэр: Азийн монос, монос, мойл

Орос нэр: Черемуха уединенная, Черемуха азиатская

Англи нэр: Mazzard Cherry Gean

**Ангилалзүйн шинж:** Тэргүүлэгч цэцэгтэн буюу сарнай-Rosaceae Juss.-н овогт хамаарах модлог ургамал. Зуувгар өргөн юмуу урвуу-өндөг хэлбэртэй навч нь 4-10 см урт, 2-4 см өргөн. Сийрэг цацаг хэлбэртэй баг цэцгийн 2 см орчим голчтой цэцэг нь доош унжиж байрладаг. Ястай, хар өнгийн шүүслэг жимсгэнэ /мойл/ 2-8 мм голчтой. 5-6-р сард цэцэглэж 8-9-р сард үр жимс болсордог. (57-р зураг)

**Ургах орчин:** Голын сав хөндий, шугуй, горхины эрэг, хусан төгөл, уулын ам, хөндийн эх, энгэр хяраар ургана. Хусан төгөл, сөөгөн ширэнгэнд тохиолдоно.

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дорнод Монгол (Молцог элс)-ын тойргуудад ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Дарьганга сумын Холбоогийн элс, Молцог элсэнд ( $45^{\circ}10'54,8''$ ,  $114^{\circ}05'38,1''$ . Д.т.д. 1329 м) ургана. Мөн Холбоо нуурын баруун талын Ганц шороон манхны зүүн хойт, хойт хажуугаар ургана. Энэ жил мойл их гарсан, нутгийн иргэд их түүжээ. Молцог элсний Мойлтын бэрх, Тошимогийн элсэнд ургах ба энэ цэг нь мойлын хувьд анх удаа тэмдэглэгдэж байгаа болно. Дарьганга сумын засаг дарга асан, түүхийн багш Дугарсүрэнгийн ярьснаар тус сумын 2-р багийн Монгол элсний баруун хойт манхан, Байшинт, Сөдөтийн шарнуу, Холбоогийн шарнуудын манх, Их, Бага бургас, хилийн 7-р заставаас хойш 8-9 км зайд мойл ургадаг гэнэ. (58-р зураг)

**Биологийн идэвхит бодис:** Жимс нь аминдэм С агуулалтаараа 8-9-р сард дээд хэмжээндээ хүрч дундажаар 20 мг% байдаг ба навчны аминдэм С 200 мг% хүрдэг.



57-р зураг. Азийн Монос



58-р зураг. Азийн Моносын тархац

**Хэрэглээ үйлчилгээ:** Жимсээр сэрүүн ундаа, хатаагаад сүү, цөцгийтэй хольж ааруул, тос бэлтгэхээс гадна ястай нь хатааж нунтаглан янз бүрийн бялуу, зууш, хар хүрэн өнгөтэй архи, дарс, ундаа хийнэ.

Хатаасан юмуу чанамал мойл суулгалтыг зогсоох үйлчилгээтэй аргаах бодис алимны ба нимбэгний хүчил агуулдаг тул түүгээр дээрх өвчнүүдийг анагаана.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Мойлыг бүрэн боловсорсон үед нь шилбэний хамт хур бороогүй өдөр түүж наранд юмуу бололцоотой тохиолдолд хатаагчид /40<sup>0</sup>-50<sup>0</sup>-65<sup>0</sup>С-д/ хатаан савлаж чийг багатай өрөөнд хадгална. Мөн чимэглэл, ногоон байгууламжинд тохиромжтой ургамал.

## ӨРӨМТҮҮЛ

Латин нэр: *Galium verum L.*

Монгол нэр: **Жинхэнэ Өрөмтүүл**

Адилцаа нэр: Шар будаг, өрөмтүүл, зод, шар хойг


Орос нэр: Подмареник настоящий

Англи нэр: Yellow Bedstraw

**Ангилалзүйн шинж:** Иш эгц босоо, дугараг, гөлгөр. Навчис шугамархуу, эрмэг нь ар талаадаа эрэгэсэн, 0.5-2 мм өргөн гөлгөр. Цэцэг хурц шар өтгөн залаа баг цэцэг үүсгэдэг. Бүдүүн мөчирөрхөг, үндэслэг иштэй өвслөг ургамал. (59-р зураг, 24-р хүснэгт)

**Ургах орчин:** Шинэсэн ой түүний зах, ой ба татмын нуга, хээржүү нуга, хялганат хээр, сөөгөн ширэнгэнд ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Говь-Алтайн тойргуудад ургана.



**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (60-р зураг, 25-р хүснэгт).

25-р хүснэгт

**Жинхэнэ Өрөмтүүлийн тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хан уул	Агь- алагөвс-хялганат	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уулаас баруун тийш 18 км-т ургадаг	Алаг өвс- хялганат	Дорнод Монгол (Дарьганга)
Мөнххаан	Чандмань уулаас баруун хойш 15 км	Агь-хазаар өвс-хялганат	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Мөнххаан уулын оройд	Баялаг алаг өвс-үетэнт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Баян ууланд	Сөөг бүхий алаг өвс-ерхөг-хялганат	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Хоёр гүвээний хоорондахь хөндий жалга 46°49'36.5", 112°02'06.9, 1296 м-т	Шарилж-түнгэт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°40' 57.1", 112° 24' 55.8", 923 м-т	Алаг өвс-агь-хялганат	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°39' 49.9", 112°27'55.1", 943м-т	Алаг өвс-түнгэ-хялганат	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	47°43' 19.2", 112° 31' 58.1", 928 м-т	Агь-тарна-хялганат	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Талын шандын хөндийд	Алаг өвс-том хялганат	Дундад Халх (зүүн)

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт 1.09-219%, ишэнд 1.5%, навчинд 4.9%, баг цэцгэнд 0.27% флавоноидууд бий. Газрын дээд хэсэгт иридоидууд, газрын доод хэсэгт антрахинонууд агуулагддаг.

**Хэрэглээ үйлчилгээ:** Үндэсийг зүрх судасны өвчин, ходоод гэдэс, бөөрний өвчин эмчлэх эмийн найрлагад ордог.

**САДАГНАГВА**

Латин нэр: *Lophanthus chinensis (Rafin.) Benth.*

Монгол нэр: **Нангиад Садагнагва**

Адилцаа нэр: Садагнагва


Орос нэр: Лофант китайский

Англи нэр: Chinese Lophanthus

**Ангилалзүйн шинж:** Олон иштэй 20-50 см өндөртэй булчирхайлаг олон наст өвслөг ургамал. Навч өндгөрхүү юмуу гонзгойвтор, сууриадаа өргөн, долгиотсон шүдлэг ирмэгтэй. Навчны өврийн тал шүхэр баг цэцгүүд нэгдэж ерөнхий баг цэцэг бүрдүүлнэ. Цоморлиг хоолойрхуу хонхон хэлбэртэй, 6-10 мм урт, дотор талдаа үсэрхэг цагирагтай. Дэлбэ цэнхэр хөх ихэвчлэн цоморлигоосоо 2 дахин урт.(61-р зураг)



61-р зураг. Нангиад садагнагва



62-р зураг. Нангиад садагнагвын тархац

**Ургах орчин:** Ойт хээр, хээр, говийн бүсэд чулуурхаг хайргат хажуу, энгэр, асга, нураг, сайр садрагын ёроол, эргийн хайрганд ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хангай, Монгол Дагуур, Дорнод Монгол, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Говь-Алтай, Дорноговь, Алашаагийн говийн тойргуудад алаг цоог тархсан ургамал юм.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (62-р зураг, 26-р хүснэгт).

26-р хүснэгт

#### Жинхэнэ Өрөмтүүлийн тархац, ургах эвшил

Эрдэнэцагаан	Зотол хан ууланд	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Шилийн Богд уулаас зүүн хойш 17 км-т, Талын агуй. 45° 35' 237", 114° 30' 029"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)

**Биологийн идэвхит бодис:** Цэцэглэлтийн үед цуглуулсан түүхий эдэд 0.54% эфирийн тос, флавоноид бий. Эфирийн тос нь өвөрмөц үнэртэй, тунгалаг, өнгөгүй эсвэл шар юмуу цайвар шар өнгөтэй. Түүний бүрэлдэхүүнд кариофиллен, n-цимол, α-гумулен, β-бисаболол зэрэг бодис багтана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Газрын дээд хэсгийг ходоод гэдэсний өвчин, навч болон цэцгийг элэг, ходоодны архаг үрэвсэл, ходоод гэдэсний замын өвчин анагаахаг хэрэглэдэг байна.

#### САРААНА

Латин нэр: *Lilium pumilum DC. = L. tenuitolum Fisch.*

Монгол нэр: **Одой Сараана**

Адилцаа нэр: Нарийн навчит сараана, цагаан төмс, агдаргана, төмсний улаан, намхан сараана, улаан сараана.

Орос нэр: Лилия карликовая, лилия тонколистная


Англи нэр: Low Lily

**Ангилалзүйн шинж:** Liliaceae Juss. - Сараанын овогт хамаарах гадагш нумарч эргэж дэрвийсэн, улаан өнгийн дэлбэтэй, 2-6 цэцэг бүхий цацаг баг цэцэгтэй, (18)20-60(80) см өндөр нарийн, гөлгөр иштэй олон наст өвслөг ургамал. Суумал, маш нарийн шугамархуу навч нь ишийг тойрч цуваа байрлана. Хонхорцог нь гонзгойвтор-өндгөрхүү. Цагаан хайрснаас тогтсон гонзгойвтор өндгөрхүү, голчоороо 2-2.5 см булцуутай. VI сарын дундаас эхлэн 4 долоо хоногийн турш цэцэглэнэ. IX сарын эхээр үр нь боловсорно(63-р зураг)

**Ургах орчин:** Уулын наранд ээвэр энгэр, нугат хээр, чулуурхаг хажуу, хааяа элсэрхэг хөрстэй нарсан шугуйд ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх (хойт хэсэг), Дорнод Монголын тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (64-р зураг, 27-р хүснэгт).



63-р зураг. Одой сараана

64-р зураг. Одой сараанын тархац

**Биологийн идэвхит бодис:** Нийт алкалоид газрын дээрх хэсэгт уг ургамлыг ургаж эхлэх үед 0.08-0.16%, цэцэглэх үед 0.11-0.32%, үрлэх үед 0.10-0.13%, навчинд 0.06-0.16%, ишэнд 0.09-0.12%, цэцгэнд 0.94% байна. Газрын доорх хэсэгт алкалоид дөнгөж мэдэгдэх төдий илэрнэ. Жил бүр алкалоидын хэмжээ ижил бус 0.11%, 0.32% гэхчилэн хэлбэлзэлтэй байна. Газрын дээрх хэсэгт флавноид (12.20 мг/г) агуулна. Булцуунд (цагаан төмс) 0.8-0.9мг% аминдэм С агуулагдана.

27-р хүснэгт

### Одой Сарааны тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хаан уул. 45° 48' 396" 114° 43' 231"	Таана- үетэнт уулын нуга.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Зотол хан уулын баруун урд хажууд жалганы энгэрт	Үетэн- алагөвс- бүйлэст	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Эрээн толгой, Зүүн Нартын гуугаар	Үетэн- алагөвст бүлгэмдэл	Дорнод Монгол (Дарьганга)

Дарьганга	Холбоо нуур, Гангын нуурын баруун элсний манхны зүүн хажуугаар. 45° 14'11,5", E 114° 04' 46,4". Д.т.д. 1330 м	Сөөг бүхий үетэн- алагөвст бүлгэмдэл	Дорнод Монгол (Дарьганга)
Мөнххаан	Баян уулын ар хажууд	Сөөг бүхий үетэн-баялаг алаг өвс-ботуульт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)

**Гарц- нөөц:** Дарьганга сумын Эрээн толгой, Зүүн Нартын гуугаар Төмсний улаан 6 x 10 км<sup>2</sup> талбайд sol аривтай, сийрэг ургана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Монгол ардын эмнэлэгт цагаан төмсийг цус тогтоох, ясны гэмтэл анагаахаар хэрэглэнэ. Мөн уламжлалт эмнэлгийн ном сударт эм нь амтлаг амттай, ялимгүй гашуун, сэрүүн, хөнгөн, мохдог, хуурай, ширүүн чанартай, ясыг залгах, шарыг анагаах, шар усыг хатаах, хорыг тайлах, ханиахыг зогсоох, халууныг арилгах, цусыг зогсоох зэрэг чадалтай хэмээн дурьдсан байдаг. Булцууг хүнсэнд хэрэглэнэ. Сүүнд хийж өрөм загсаах, цагаан тосонд холих зэргээр хүнсэнд нэмэрлэнэ. Цэцэг үзэсгэлэнтэй сайхан учир чимэглэлд хэрэглэнэ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Эмийн түүхий эд бэлтгэхдээ намар хайрслаг булцууг малтаж аваад муудаж гэмтсэн, ялзарсан, харласан, хүрэлтсэн хэсгийг огтлон хаяж бусад элдэв хольцоос сайтар цэвэрлээд шавар шороог угааж арилгаад хайрслаг хумсыг буцламгай халуун усанд түр хийж байлгаад гаргаж сүүдэр газар хатаана.

Хот суурин газрын ойролцоо ургадаг сарааныг хүнс, эм болон баглаа цэцгэнд өргөн ашигласнаас ховордох төлөвтэй байгааг харгалзан энэ ургамлыг хайрлан хамгаалж үржүүлэх шаардлагатай. Сарааны төрөлд хамаарагдах эдгээр сайхан ургамлыг тарималжуулахдаа юуны өмнө зүйл тус бүрийн тархалт орчинзүй, аминзүйн онцлогуудыг харгалзан үзэх нь зүйтэй юм.

## САРНАЙ

Латин нэр: ***Rosa acicularis Lindl.***

Монгол нэр: **Өргөст Сарнай**

Адилцаа нэр: Өргөст нохойн хошуу, нохойн хошуу

Орос нэр: Роза иглистая, шитовник иглистая

Англи нэр: Prickly Rose

**Ангилалзүйн шинж:** Иш, мөчир, навчны бариул нэлэнхүйдээ хурц өргөслөг сөөг. Навчис 15 см хүртэл урт, навчинцар том, 5-7, гонзгойвтор өндгөрхүү, 1.5-6 см урт, 1-3.5 см өргөн бөгөөд энгийн шүдэрхэг захтай. Цэцэг



голчоороо 3-6 см, тод ягаан юмуу улаан ягаавтар, ихэвчлэн ганцаараа, хааяа 2-3-аараа байрладаг(65-р зураг).

**Ургах орчин:** Шинэсэн ой түүний зах, хусан ой, голын шугуй, ширэнгэ, хад асгаар ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Дорнод Монгол, Говь-Алтайн (Гурван Сайхан, Гурван Богд) тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (66-р зураг, 28-р хүснэгт)

28-р хүснэгт

### Өргөст сарнайн тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Лхачинвандад ууланд	Үетэн- алагөвст уулын хойт хажуу	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд. 45° 28'15,0", 114° 35' 02". Д.т.д. 1680 м.	Чулуусаг алагөвс- үетэн-боролзгонот уулын ар	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	Баянцагаан уулын ар хажууд	Агь-Алаг өвс-Үетэнт (Ботууульт)	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Түмэнцогт ууланд	Баялаг алаг өвс-үетэнт	Дундад Халх (зүүн)

**Гарц-нөөц:** Шилийн Богд уулынд 2 га талбайд ургана.

**Биологийн идэвхит бодис:** Үндэс, навч, цэцгэнд идээлгийн бодис, флавоноид; навчинд эллагоны хүчил, С аминдэм агуулагдана. Жимсэнд сахар, пектин, пентозан, органик хүчил, В<sub>2</sub>, С, К аминдэмүүд, каротин агуулагдах ба астрагалин, кверцимерин болон гиперин төрлийн флавоноид илэрсэн. Үүнээс жимсэнд 1444-3376 мг/% аминдэм С байгааг тогтоосон байдаг.

**Хэрэглээ үйлчилгээ:** Залуу найлзуурыг хүнсэнд хэрэглэнэ. Цэцгийн дэлбээгээр анхилуун үнэрт цай хийх ба чихрийн үйлдвэрт хатуу чихрийн хольцонд оруулж болно. Мөн савангийн үйлдвэрт хэрэглэнэ. Жимсгэнээр чанамал хийдэг. Эмийн түүхий эдэд навч, жимс, цэцгийг ашиглана. Жимсгэний бэлдмэлээр аминдэм дутагдах, элэгний өвчин, судас хатуурах (атеросклероз), ходоод гэдэсний өвчинг анагаана.

Аминдэм дутагдах (авитаминоз ба цинга), элэгний өвчин, судас хатуурах (атеросклероз), ходоод гэдэсний өвчинг эмчилэхдээ жимсгэний хандыг; ядаргаа, ханиад, аминдэм дутагдах (авитаминоз ба цинга) өвчинд цэцгийн дэлбийг; цэсний өвчин, аминдэм дутагдах (авитаминоз ба цинга), хаврын цаг агаарын эрс өөрчлөлтөнд бие махбодийг сэргээхэд жимсийг хэрэглэнэ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Жимсгэнийг хүйтэрснээс болж хорчийн унахаас өмнө түүж халуун пийшингийн ойролцоо юмуу хатаагч шүүгээнд 90-100<sup>0</sup> С хэмд түлэлгүй хатаана. Зөв хатсан дээж хүрэн улаан ба улбар шар өнгөтэй болох бөгөөд хуурай газар битүү саванд хийж 2 жил хадгална.

## СОНГИНО

Латин нэр: *Allium odorum L. = A. ramosum*

Монгол нэр: **Анхил Сонгино**

Адилцаа нэр: Гогод, шулуун сонгино, салаат сонгино

Орос нэр: Лук дуцистый, лук ветвистый

Англи нэр: Fragrant-flowered Onion, Branchy Onion

**Ангилалзүйн шинж:** 20-40 см өндөр иштэй, хүрэвтэр өнгийн торлог ширхэглэг бүрхүүлтэй, цөөн тооны булцуутай, нарийн шугаман навч, сум ишний үзүүрт олон жижиг цайвардуу ногоон цэцэг бүхий багцалсан шүхэр баг цэцэгтэй ба ногоовтор юмуу ягаавтар судал бүхий гурав гурваар хоёр хүрээг үүсгэсэн 6-9 мм урт шадар навчинцараас бүрдэнэ. 7-8-р сард цэцэглэнэ(67-р зураг).

**Ургах (тархацын) орчин:** Уулын ойт хээр, хээрийн бүсэнд тархсан хааяа говийн бүсийн хойт хэсэг рүү түрж орно. Хуурай нуга, хээрээр ургах ба толгодын чулуутай энгэр, хайрга дээр ургана. Үетэн- алагөвст татам, алагөвст уулын хээр, хээрт ургана.

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Дорноговь, Говь-Алтай.



67-р зураг. Анхил Сонгино



68-р зураг. Анхил Сонгинын тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (68-р зураг, 29-р хүснэгт)

29-р хүснэгт

**Анхил Сонгинын тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Наран	Хар нуурын урд хуурай хээрт. 45° 59'13,0", 113° 56' 0,3". Д.т.д. 1421 м	Толгодын чулуутай хажуу, үетэн- алагөвст хээрт	Дорнод Монгол (Дарьганга)
Наран	Цогийн уулын энгэр	Хялганат хуурай хээрт	Дорнод Монгол (Дарьганга)
Онгон	45° 10'18,1", 113° 13' 29,0". Д.т.д.1183 м.	Хялганат хуурай хээрт	Дундад Халх (зүүн)

**Гарц-нөөц:** 1м<sup>2</sup> талбайд үнэмлэхүй хуурай жин 47,2 гр жинтэй.

**Биологийн идэвхт бодис:** Навчинд нь аскорбины хүчил 70 мг%, каротин 8 мг%, 0.21% алкалоидтой ба уг бодис 5-6-р сард 22 мг%, 8-р сард 15.42 мг%, аминдэм С тус тус агуулна. Нийт сахар 0.5-0.9%, хүчиллэг 0.6%.

**Хэрэглээ үйлчилгээ:** Навч булцуу үндэсний нухаш, шүүс нь *Staph aureum*, *Bactcoli* зэрэг нянг үхүүлэх ба харин навч үндэсний шүүс илүү үйлчилгээтэй байна. Навч булцуу үндэсний нухаш шүүс нь цацраг мөөгөнцөрийг үхүүлэх чадалтай боловч шүүс нь илүү хүчтэй байдаг. Мөн шүхэр баг цэцгийг сорслон хоол хүнсэнд амт оруулагчаар хэрэглэнэ.

Хүнсний ач холбогдол бүхий энэ зүйл ургамлын навчийг дэвслэж дараад, хоол хүнсэнд өргөн хэрэглэж иржээ. Түүсэн навчийг хүйтэн усаар угааж 2-5 мм хэмжээтэй хэрчээд 1 кг гогодонд 150-200 г давс хийхээр бодож даршлана. Гогод бундуулахаас үрлэж эхлэх үе хүртэл хугацаанд цэцгийг тасдаж түүгээд, угааж цэвэрлэн жижиглээд 1 кг цэцгэнд 200-250 г давс хийж шил, ваар, паалантай сав, модон торхонд даршлана.

Латин нэр: ***Allium mongolicum Rgl.=A. krylovii***

Монгол нэр: **Монгол Сонгино**


Адилцаа нэр: Хөмөл, хөмүүл, Крыловын сонгино.

Орос нэр: Лук монгольский

Англи нэр: Mongolian Onion

**Ангилалзүйн шинж:** Сараанын овог-Liliaceae Juss.-ийн олон наст ургамал 10-20 см өндөр бөөрөнхий гөлгөр иштэй. Хөрсөнд хөндлөн байрласан үндэслэг иштэй, нарийн булцуунуудтай, багавтар дэгнүүл үүсгэдэг. Навч нь үндэснийхээ орчмоос багцлан гарсан бортгон хэлбэрийн, шүүсээр дүүргэгдсэн цайвар хөх, хөх ногоон өнгө, өвөрмөц өнгөртэй. Шүхэр нь олон цэцэгтэй, сийрэг цэцэг нь том, улбар ягаан өнгөтэй байна. 5-р сард ургаж эхлэх ба 7-8-р сард цэцэглэнэ. (69-р зураг).

**Ургах орчин:** Говийн уул толгодын бэл, хормой, тал хөндий, дэрс, товцог, бут бударганы зай чөлөөгөөр ургана. Хөмөл нь заримдаг цөл, цөлийн ургамалжилтанд зонхилогч болон дэд зонхилогчоор ургана.



69-р зураг. Монгол Сонгино

70-р зураг. Монгол Сонгинын тархац

**Монгол дахь тархац:** Хангай, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн цаад говь, Алашаа говийн тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Сүхбаатар аймагт Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр, Асгат, Халзан, Түвшинширээ, Мөнххаан сумдын нутагт ургана. Дарьганга сумын Молцог элс, Баянголын эх Баруун, Зүүн салаанд ( $45^{\circ}16'24,5''$ ,  $113^{\circ}44'18,2''$ . Д.т.д. 1137 м.), Наран сумын Өлзийт булаг ( $45^{\circ}15'34,0''$ ,  $110^{\circ}42' 10,0''$ . Д.т.д. 1195 м.) ургаж байгааг тогтоов. Онгон сумын төвөөс урагш Хошуу худаг, Онгон элс, Цагаан шанд, Хар дэрс (Д.т.д. 1011 м,  $45^{\circ}19'18,1''$ ,  $113^{\circ}09'05,8''$ ) зэрэг газарт хэсэг хэсгээр ургана. (70-р зураг).

**Биологийн идэвхит бодис:** Хөмөл нь тэжээлийн шимт чанараар /бундуужих үедээ 29.5-38.6% протеинтэй/ дээгүүр ургамлын тоонд орно. Цэцэглэж байхдаа 20 мг% аминдэм С, 0.2 мг% протеинтэй

**Хэрэглээ үйлчилгээ:** Фитонцид, төрөл бүрийн аминдэмээр баялаг учир говийн хүмүүсийн дуртай хэрэглэдэг хүнсний ногоо юм. Шинээр нь түүж хоол хүнсэнд хольц болгон хэрэглэх ба даршилж юмуу хатааж зоодой /сорс/ болгон удаан хугацаагаар хадгалж хэрэглэнэ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Хөмөлийг түүсний дараа 1-3 хоногийн дотор угааж цэвэрлээд 0.5-1 см хэмжээтэй жижиглэн хэрчээд 1 кг хөмөлд 150-200 г давс байхаар бодож даршлана. Хадгалах хугацаа 5 сар.

Латин нэр: ***Allium polyrrhizum Turcz. ex Regel.***

Монгол нэр: **Таана**

Адилцаа нэр: Үндсэрхэг сонгино, багалгар сонгино, тана.

Орос нэр: Лук многокорешковый, лук многокорневой

Англи нэр: Manyroot Onion

**Ангилалзүйн шинж:** Сараанын овгийн тэжээлийн олон наст ургамал. Сонгинолог булцуу үл мэдэгдэм бөгөөд үндэслэг ишэн дээр хэд хэдээрээ чигжүү сууж, нягт бор сааралдуу дэгнүүл үүсгэдэг. Булцууны гадар бүрхүүл ширхэглэг, бараг эсгийлэг, үл мэдэгдэм торлог. 7-9-р сард үрлэнэ. (71-р зураг).


**Ургах орчин:** Чулуурхаг, хайргархаг цөл, цөлөрхөг хээр, уулын чулуутай хажуу, бэл, хад чулууны ёроол, цав толгодоор ургана.

**Монгол дахь тархац:** Хангай (өмнөд бэл), Монгол Алтай (зүүн сэжүүр), Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаа говийн тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Сүхбаатар аймагт Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр, Асгат, Халзан, Түвшинширээ, Мөнххаан зэрэг ихэнх сумдын нутагт ургана (72-р зураг).

**Гарц- нөөц:** Наран сумын Баавхайн говь болон Логийн чулуунд (д.т.д. 1277 м, 44° 55'0,48", 113° 28' 40,2") 1 м<sup>2</sup> талбайд үнэмлэхүй хуурай жин 19,52 гр, 7 х 4 км<sup>2</sup> талбайд сор<sub>1</sub> аривтай, мөн сумын Хашаатын булагийн хялгана - таанат хээрт (45°06'0,07", 113°44'17.7", д.т.д. 1319 м) 8 км х 4 км талбайд сор аривтай, Гүн худагийн (44° 57'10.6", 113° 29' 14.6", Д.т.д.1207 м,) таанат хээрт ургадаг. Онгон сумын Бударын чулууны чулуурхаг таанат хээрт (тусгагийн бүрхэц – 25-30%,) 1м<sup>2</sup> талбайд таанын дэгнүүл 26 ширхэг тоологдлоо.

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт уураг 37.8-45.3%, өөх тос 1.9-3.8%, сахар 1.4-1.5%, эслэг 22.3-34.5% тус тус агуулагдана.



**Хэрэглээ үйлчилгээ:** Фитонцид, төрөл бүрийн аминдэмээр баялаг учир говийн хүмүүсийн дуртай хэрэглэдэг хүнсний ногоо юм. Шинээр нь түүж хоол

хүнсэнд хольц болгон хэрэглэх ба даршилж юмуу хатааж зоодой /сорс/ болгон удаан хугацаагаар хадгалж хэрэглэнэ.

Латин нэр: *Allium senescens* L.

Монгол нэр: **Хижээл Сонгино**

Адилцаа нэр: Мангир

Орос нэр: Лук стареющий

Англи нэр: Aging Onion

**Ангилалзүйн шинж:** 20-60 см өндөр сонгинолог иш нь ганцаараа үндэслэг ишэндээ бэхлэгддэг, сийрэг дэгнүүлтэй олон наст ургамал. Булцуу нь бараан өнгийн хальслаг бүтэн бүрхүүлтэй. Сонгинолог иш хальсархуу юмуу сарьсархаг, ишний уг орчимд бөөгнөрсөн хөх ногоон, сааралдуу өнгийн эгц эсвэл хадуур маягийн нугаларсан 5-8 ширхэг хавтгай шугаман навчтай. Цайвар ягаандуу, хөхөвтөр ягаан цэцгээс тогтсон дэвүүр маягийн тал бөмбөлөг өтгөн шүхэр баг цэцэг ишний оройд байрлана. Ургах (ургалтын) хугацаа: 5-р сарын эхний хагсаас эхлэн ургаж 6-р сарын сүүлч 7-р сарын эхээр цэцэглэдэг(73-р зураг).

**Ургах (тархацын) орчин:** Уулсын хээр, хээрийн бүсийн ихэнх хэсэгт өргөн тархсан ургамал. Мөн голын эргийн нуга, нугын дээд дэнжүүд, голын хөндий, зөөлөн хөрстэй уулын энгэр бэлээр сайн ургадаг. Татмын дэнжид элдэв өвст-үетэнт улиасан II ташингад тохиолдоно.



**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хөндий, Говь-Алтай /Гурван Богд, Гурван Сайхан/

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (74-р зураг, 30-р хүснэгт)

30-р хүснэгт

### Хижээл Сонгинын тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Наран	Хэцийн ширээ. 45° 00'56,9", 113° 57' 45,6". Д.т.д. 1462 м	Толгодын чулуутай хажуу, үетэн- алагөвст хээрт	Дорнод Монгол (Дарьганга)
Наран	Цогын уулын энгэр	Хялганат хуурай хээрт	Дорнод Монгол (Дарьганга)

**Гарц-нөөц:** Наран сумын Хэцийн ширээ гэдэг газар 1 м<sup>2</sup> талбайд 214 гр хуурай жинтэйгээр ургана.

Балт ургамал бөгөөд 100 ширхэг цэцгээс, цэцэглэлтийн эхний хагаст 47.15±1.23 мг, цэцэглэлтийн сүүлийн хагаст 11.32±0.21 мг сахар ялгарна.

**Биологийн идэвхт бодис:** Навчинд 44 /38-50.6/ мг%, булцуунд 4.5 мг%, аминдэм С 198.%, газрын дээрх хэсэгт протеин 23%, сахар 7.58%, цардуул 6.05, лигнин 7.81%, тос 3.13%, сапонин нэлээдтэй, үнэмлэхүй хуурай бодисондоо 111.7 мг/кг каротинтой.

**Хэрэглээ үйлчилгээ:** Мангирын нялх навч сонгинолог булцууг хүнсэнд хэрэглэхдээ ид ургаж байгаа ногоон үед нь түүж шууд буюу даршлан хэрэглэх бөгөөд цэцэглэсний дараа навчны өнгөнд шар туяа сууж үзүүр нь гандаж эхлэх ба энэ үед идэхэд нялуун амттай болж даршлахад амархан мууддаг тул тодорхой хугацаанд түүж ашиглана. Балт ургамал бөгөөд 100 ширхэг цэцгээс, цэцэглэлтийн эхний хагаст 47.15±1.23 мг, цэцэглэлтийн сүүлийн хагаст 11.32±0.21 мг сахар ялгарна.

Мангирыг түүхдээ газрын дээд хэсгийг хутга буюу хайчаар угаар нь хяргаж авна. Түүсэн мангирыг угааж цэвэрлэсний дараа 1.5-3.5 мм хэмжээтэй хэрчиж 1 кг-д 250-300 г давс хийж давслах, савлах, ашиглах, тээвэрлэх ажиллагааг гүйцэтгэнэ.

### СӨД

Латин нэр: *Sanguisorba officinalis* L.

Монгол нэр: **Эмийн Сөд**

Адилцаа нэр: Сөд өвс, чивга өвс, хүрэн түрүү

Орос нэр: Кровохлебка аптечная

Англи нэр: Garden Burnet

**Ангилалзүйн шинж:** Тэргүүлэгч цэцэгтэн(сарнайн)-Rosaceae Juss. овог, сөдийн төрөлд хамаарах 20-100 см өндөр эгц нүцгэн иштэй, олон наст өвслөг ургамал. Навчис өдлөг нийлмэл, 10-15 см урт, 5-10 см өргөн. Навчинцар шүдэрхэг 4-6 хос, гонзгой-өндгөрхүү, урт бариултай, доод гадаргуу нь сийрэг

үслэг. Баг цэцэг бөөрөнхийдүү, зуувандуу, толгойрхуу. Цэцэг хүрэн улаан, дан шадар эрхтэнтэй. Цоморлигийн навчинцар 4. Дохиур 4. Үр боловсрох орон 1. Цэцгийн суудлын хамт унадаг нэг үрэнцэртэй.

Жимс өндгөрхүү, 4 талтай, эдгээрийг дагасан хянгатай. VI-VIII сард цэцэглэнэ. Үр ба үндэслэг ишээрээ үрждэг. (75-р зураг)

**Ургах орчин:** Монгол орны хээрийн бүслүүрээс тагийн бүслүүр хүртэлх нутгийн хусан төгөл, шинэсэн шугуй, тэдгээрийн зах, ойн нуга, голын эргийн ширэнгэ, элдэв өвст хээр, услагддаг юмуу намгархаг нугад ургана. Голчлон улалж-үетэн-элдэв өвст нугад элдэв өвснөөс зонхилогч болон ургадаг.



75-р зураг. Эмийн Сөд

76-р зураг. Эмийн Сөдийн тархац

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хяangan, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол (хойт хэсэг), Их нууруудын хотгор (Улаангом), Олон нуурын хөндийн тойргуудад тархана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (76-р зураг, 31-р хүснэгт).

31-р хүснэгт

**Эмийн Сөдийн тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хан уулын орчим	Алагөвст хээрт	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн богд. 45° 28'18,4", 114° 35' 10,1". Д.т.д. 1702 м.	Алагөвст хээрт	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Баянгол, Зүлэгт. 6 45° 16'21,4", 113° 44' 21,0". Д.т.д. 1212 м.	Алагөвст хээрт	Дорнод Монгол (Дарьганга)
Наран	Сөдөтийн гол. 45° 03'39,3", 113° 53' 43,1". Д.т.д. 1344 м.	Алагөвст хээрт	Дорнод Монгол (Дарьганга)
Наран	Зүлэгт. 45° 04'49,6", 113° 52' 33,8". Д.т.д. 1328 м.	Алагөвст хээрт	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	47°47' 26.4", 112° 38'24.1", 871 м-т	Алаг өвс-улаан толгойт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	46°49' 36.5", 112° 02' 06.1", 1296 м-т Хоёр гүвээний хоорондахь хөндий жалга	Шарилж-түнгэт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Мөнххаан	Мөнххаан уулын баруун хойд бэл	Сөөг бүхий алаг өвс-үетэнт	Дундад Халх (зүүн)



Мөнххаан	46°59' 18.8", 111°54' 36.3", 1578 м-т	Баялаг алаг өвс-үетэнт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Түмэнцогт уулын оройн тэгшивтэр хэсэг	Баялаг алаг өвс-үетэнт бүлгэмдэл	Дундад Халх (зүүн)
Түмэнцогт	Хар ямаатад 47°37'40,8", 112°07'25,7", 1143 м-т	Үетэн сөдөт бүлгэмдэлд	Дундад Халх (зүүн)

**Биологийн идэвхит бодис:** Эмийн сөд үндэс, үндэслэг ишэндээ пирогалл бүлэг зонхилсон эдээлэгч бодис 12-20 (40) %, сангвисорбин хэмээх сапонин, будагч бодис, эфирийн тос 1.8% хүртэл, цардуул 29% хүртэл, флавоноид бодис, фитонцид, С аминдэм болон каротин түүнчлэн марганец, төмөр, кальций, магни, ванадий; навчиндаа С аминдэм, кверцетин ба кемпферол бүлгийн флавонол-гликозид агуулдаг.

**Хэрэглээ үйлчилгээ:** Гашуун амттай бөгөөд сэрүүн чанартай, цусан халууныг арилгах, суулгахыг зогсоох, цусыг тогтоох зэрэг чадалтай. Цусан халуун, уушигны сүрьеэгээр цустай ханиах, өтгөн цустай гарах, цусаар бөөлжих, цустай шээх, хамраас цус гарах, улаан ёлхдос, цусаар буулгах, сарын тэмдэг хэвийн хэмжээнээс илүү ирэх, гадар шархнаас цус гарах, галд халаасан шарх зэргийг засна.

Анагаах ухааны эмнэлэгт баг цэцэг болон үндэсийг ходоод, гэдэсний өвчин, гэдэсний халдарт өвчин (дизентери), цагаан мах гарах (геморрое) эмчилэхэд хэрэглэнэ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Хавар, намар үндэсийг авч угаан цэвэрлэж хатаагаад хэрэглэнэ.

## СУЛЬ

Латин нэр: *Psammochloa villosa (Trin.) Bor*

Монгол нэр: **Үсхий Суль**

Адилцаа нэр: Суль, хар суль, монгол төмрөө

Орос нэр: Псамохлоа волосистая

Англи нэр: Pilose Psammochloa

**Ангилалзүйн шинж:** Poaceae Barnhart.-Биелэгтний овгийн олон наст ургамал. Урт үндэслэг иштэй, 10-20 см гүнд салаалж салбарласан мөлхөө урт найлзууртай. Навч өргөн, хумираа 30-40 см урт; цэцэгт иш 50-150 см өндөр, оройдоо 20-25 см хүртэл урт, нарийвтар өтгөн залаатай; цэцгийн доод хайрс үсэрхэг; үрэнцэр 0.5-0.8 см хүртэл урт, хөх ягаан туяа бүхий харавтар өнгөтэй. 6-р сард цэцэглэнэ (77-р зураг)


**Ургах орчин:** Цөл, цөлөрхөг хээрийн элсэн манхан, нүүдэг, нүүдэггүй элс болон сул элсэнд ургана.

**Монгол дахь тархац:** Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алашаа говийн тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Холбоогийн элс, Молцог элс, Онгон Баяндэлгэр сумдын заагт орших Онгон элс зэрэгт ургасан байна. Онгон сум, Шар бүрдний элсэнд (45° 39'05,1", 113° 05' 04,60". Д.т.д. 1111 м) тархацтай. (78-р зураг)

**Гарц-нөөц:** Молцог элсэнд хийсэн судалгаагаар 8-16 кг/га ургацтай байлаа.

**Биологийн идэвхит бодис:** Сулийн гурилд уураг 23.03%, цардуул 63.9%, өөх тос 1.42% тус тус агуулагдана.



**Хэрэглээ үйлчилгээ:** Манай ард иргэд эрт дээр үеэс сулийн үрнээс гурил бэлтгэж хүнсэнд болон эмийн журмаар хэрэглэж байв. Үүнд сулийн гурилаар хийцтэй цай болон гурилтай шөл, сулийн сүүтэй цай хийж хэрэглэнэ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Үсхий (хар) суль нь элс нүүдлийг тогтворжуулах гол ургамал бөгөөд цөлжилтийг бууруулах үүднээс элсийг салхиар хийсч нүүхээс хамгаалж, цөлжиж элс ихтэй болсон нутагт тариалах шаардлагатай юм.

## ТАВАНСАЛАА

Латин нэр: *Plantago major L.*

Монгол нэр: **Их Тавансалаа**

Адилцаа нэр: Тавансалаа

Орос нэр: Подорожник большой, Подорожник обыкновенный

Англи нэр: Rippleseed Plantain

**Ангилалзүйн шинж:** Навч нь зүрхэн хэлбэртэй юмуу хааяа шаантгархуу суурьтай, өндгөрхүү эсвэл юлдэрхүү өндөг хэлбэртэй, 5-7 судалтай, урт бариултай олон наст ургамал. Цэцэглэх иш голдуу нэг хааяа 2-3 бөгөөд 30 см хүртэл өндөр, түрүү нь 60 см хүртэл урт (79-р зураг).

**Ургах орчин:** Нуур, голын эрэг, эргийн нуга, голын хужирлаг хөндийн сайр, мөн суурин газар тариалангийн талбай, булаг шандны дагуух зүлэг, айлын бууцанд ургана.

**Тархац-байршил:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Их нуруудын хотгор, Олон нуурын хөндий, Говь-Алтайн, Зүүн гарын говийн тойргуудад тохиолдоно.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (80-р зураг, 32-р хүснэгт).

32-р хүснэгт

### Их Тавансалааны тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга.	Сумын төвөөс баруун тийш 14 км-т, Баянголын эх, Салаагийн элс. 45° 16' 197", 113° 44' 208"	Ширэг улалжтай дэвсэг.	Дорнод Монгол (Дарьганга)
Сүхбаатар.	Дорнодын Матадаас баруун тийш 110 км-т, Түмэнцогтоос Матад сум орох замд. 47° 07' 131", 114° 11' 661"	Хялгана-шарилж-алагөвст хээр	Дундад Халх (дорнод)



79-р зураг. Их Тавансалаа



80-р зураг. Их Тавансалааны тархац

**Гарц-нөөц:** Судалгаагаар Сүхбаатар аймагт өргөн тархацтай боловч маш сийрэг ургах тул гарц-нөөцийн материал бүрдээгүй болно.

**Хэрэглээ, ач холбогдол:** Энэ ургамлын газрын дээд хэсгийг шинжлэн ухааны болон уламжлалт анагаахын эмнэлэгт навчаар бэлтгэсэн хандыг ходоод гэдэсний үрэвсэл суулгах өвчин зэргийг эмчлэхэд хэрэглэнэ.

Түүхий эд бэлтгэхдээ навтгар Таван салаатай адил гүйцэтгэнэ.

## ТАРВАГАН ШИЙР

Латин нэр: *Thermopsis lanceolata R.Br.=Th. Dahurica Czefr.*

Монгол нэр: **Юлдэн Тарваган шийр**

Адилцаа нэр: Дагуур тарваган шийр, тарваган шийр

Орос нэр: Термопсис ланцетовидный, Термопсис даурский

Англи нэр: Lanceolata Thermopsis, Dahurian Thermopsis

**Ангилалзүйн шинж:** Навчинцар 32-50 мм урт, 9-18 мм өргөн, гонзгой-зуувгар, голдуу үзүүрээдээ доош эргэсэн. Буурцаг 50-60 мм урт, 9-10 мм өргөн, шулуун. (81-р зураг)

**Ургах орчин:** Хээрийн чулуурхаг, хайргархаг хажуу, нуур, гол, булгийн эрэг, хээрийн хужирлаг нуга, уулын хээрийн хотос дагуу ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монголын тойрог ургана.



81-р зураг. Юлдэн Тарваган шийр

82-р зураг. Юлдэн Тарваган шийрийн тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:**, (82-р зураг, 33-р хүснэгт)

33-р хүснэгт

### Юлдэн Тарваганшийрийн тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Сумын төвөөс хойш 9 км-т, голын хөндий. д.т.д. 45° 57' 23.7" 115° 22' 55.5, 1054 м.	Дэрс- үетэн- алагөвст хажуу	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Лаг нуураас баруун урагш, 11 км-т.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Зотол хан уул	Таана- үетэнт уулын нуга.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Зотол хаан уулаас урагш 48 км-т, Рашаант нуурын баруун урагш Шилийн Богд орох замд. 45° 35' 327", 114° 30' 540"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Холбоогийн элс, 45° 14' 066" 114° 08' 108"	Бургас- хайлаас бүхий үетэн- алагөвст элсэн довцог.	Дорнод Монгол (Дарьганга)

Дарьганга	Молцог элс. Сумын төвөөс баруун тийш 25 км-т. Молцог элсний баруун хэсэг	Үетэн- алагөвст эвшил.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Сумын төвөөс баруун тийш 14 км-т, Баянголын эх, Салаагийн элс. 45° 16' 19", 113° 44' 208"	Үетэн- алагөвст элс.	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт.	Түмэнцогтоос баруун урагш 12 км-т, Өндөрхаанаас Түмэнцогт орох замын дэргэд. 47° 28' 809", 112° 12' 959"	Хялгана- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)
Сүхбаатар.	Дорнодын Матадаас баруун тийш 110 км-т, Түмэнцогтоос Матад сум орох замд.	Хялгана- шарилж-алагөвст хээр	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Их талхлагдсан сумын төвийн ойролцоох тэгш тал. 47° 35' 07.0", 112° 21' 13.6", 978 м-т	Шарилж-хазаар өвст-үетэн	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Талбулгийн хөндийд	Алаг өвс-хазаар өвс-хялганат	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	46°52'266", 112°07'109", 1279 м-т	Amygdalus бүхий алаг өвс-сонгино- хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Талын шандын хөндийд	Алаг өвс-том хялганат	Дундад Халх (дорнод)

**Хэрэглээ үйлчилгээ:** Ханиад, амьсгалын замын болон уушигний өвчинд хэрэглэнэ.

## ТАРНА

Латин нэр: *Polygonum divaricatum* L.

Монгол нэр: **Дэрвээн Тарна**

Адилцаа нэр: Үхэр тарна, Усан шимэлдэг


Орос нэр: Горец растопыренный

Англи нэр: Divaricate Khotweed

**Ангилалзүйн шинж:** Сууриасаа эхлээд их салаалсан, ацан салаа мөчиртэй, 1 м хүртэл өндөр, бараг, бөөрөнхий бөөн бут үүсгэх ургамал. Навчис нарийн юмуу шугаман юлдэрхүү, хоёр үзүүрээдээ жигд нарийссан, ишний адил, нүцгэн эсвэл судал дагуу тачир үсэрхэг. Урт цацагаас бүрдэх том, сийрэг залаа баг цэцэгтэй, самранцар том 4-7 мм урт.( 83-р зураг)

**Ургах орчин:** Хээр тал, хээржүү хажууд ургана. Дорнод Монголын биелэгөвс- алагөвст дэнжид, нарс- хусан ойн захын элсэн хөрсөнд, бургасан шугуйн үетэн- алагөвст татамд, бэсрэг уулын хоорондох хөндийн хялгана- алаг өвст хээрт, уулсын дунд сибирь гүйлс- тарна- алагөвст энгэрт, элсэрхэг, хайргархаг хөрстэй толгодын дунд хялгана- тарна- алагөвст хээрт, тэгш толгодын дунд хялгана- зүрөвс- алагөвст хээрт тус тус ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол (умард)-ын тойрогт ургана.



83-р зураг. Дэрвээн Тарна



84-р зураг. Дэрвээн Тарнын тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (84-р зураг, 34-р хүснэгт)

34-р хүснэгт

### Дэрвээн Тарнын тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Түмэнцогт	Толгод хоорондын хөндий- 47° 44' 20.8", 112° 18' 08.1", 937 м-т	Алаг өвс-хиагт бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47° 40' 57.1", 112° 24' 55.8", 923 м-т	Алаг өвс-агь-хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47° 39' 49.9", 112° 27' 55.1", 943 м-т	Алаг өвс-түнгэ-хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47° 41' 35.1", 112° 29' 24.3", 929 м-т	Алаг өвс-ерхөг-том хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47° 43' 19.2", 112° 31' 58.1", 928 м-т	Агь-тарна-хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Талын шандын хөндийд	Алаг өвс-том хялагант	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	47° 18' 51.4", 112° 12' 10.4", 1004 м-т	Алаг өвс-агь-хазаар өвст	Дундад Халх (дорнод)

**Хэрэглээ үйлчилгээ:** Монгол эмнэлэгт түүний үндсийг ходоод гэдэсний үйл ажиллагааны хямрал анагаахад олгохын зэрэгцээ эмэгтэйчүүдийн сарын тэмдэг их ирэх, умайнаас цус алдах зэрэгт энэ ургамлыг жоронд оруулж хэрэглэнэ.

Латин нэр: ***Polygonum aviculare L.***

Монгол нэр: **Шувуун Тарна**

Адилцаа нэр: Бүднээн сүүл, Гахайн ногоо


Орос нэр: Горец птичий, спорыш

Англи нэр: Common Knotweed

**Ангилалзүйн шинж:** Тарнын овог- Polygonaceae Juss.-т хамаарах ургамал. Цэцгийн шадар эрхтэн дөнгөж дундаа хүртэл цуулбар, иш мөчрийн навчис адилхан хэлбэртэй, зуувангаас өргөн-хүрээрхүү, хэлэрхүү, ихэнхдээ

мохоо. Иш ихэвчлэн дэлхээ, эсвэл нумраа юмуу өндиймөл 60 см хүртэл урт. (85-р зураг)

**Ургах орчин:** Голын эрэг, хайрга, хаэгалсан газар, чийглэг хужирлаг нуга, төв суурин газар, зам дагуу ургана.



**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Говь-Алтай

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Дарьганга сумын Шилийн Богд ууланд ургана. (84-р зураг)

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт кверцетин, кемпферол, мирицетин, изорамнетин, кверцитрин, гиперин, авикулярин зэрэг флавоноид (9.4%) олдсон. Галлын, кофейны, хлорогены ба η-кумарын фенолкарбоны хүчил; эдээлгийн бодис 1.8-4.8%, болон умбеллиферон, скополетин бүхий кумарин агуулагдана. Үндсэнд дельфинидин, антрахинонууд; газрын дээд хэсэгт сахар, катехинууд, С витамин, каротинууд бий

**Хэрэглээ үйлчилгээ:** Газрын дээд хэсгийг Монгол эмнэлэгт элэг, бөөр, гэдэс, давсагны үрэвслийн үед хэрэглэдэг. Мөн бодисын солилцооны өөрчлөлт, хавдарт хэрэглэдэг. Газрын дээд хэсгийг астам, сүрьеэ, гуурсан хоолойн үрэвсэл, шарлалт, цэс чулуужихад дотуур, арьсны үрэвсэлд гадуур (түрхлэг) хэрэглэдэг. Оросын шинжлэх ухааны эмнэлэгт үндэсний хандыг үрэвслийн эсрэг, бөөр, давсагны чулуу хөөх зорилгоор, газрын дээд хэсгийг савны үрэвсэлд, мөн халуун бууруулах, цус хөөхөд хэрэглэнэ.

## ТӨЛӨГЧӨВС

Латин нэр: *Achillea asiatica* Serg.


Монгол нэр: **Азийн Төлөгчөвс**

Адилцаа нэр: Төлөгч өвс, бамба

Орос нэр: Тысячелистник азиатский

Англи нэр: Asiatic Yarrow

**Ангилалзүйн шинж:** Иш 25-50 см өндөр, олон наст өвслөг ургамал. Навчис хошоод өдлөг-цуулбар. Навчны гол тэнхлэг 0.5-1 мм өргөн, сегментүүд хоорондоо 1-1.5 мм зайтай. Цэцэг улаан юмуу хааяа (ховор тохиолдолд) цагаан(87-р зураг).



87 -р зураг. Азийн Төлөгч-өвс

88р зураг. Азийн Төлөгч-өвсний тархац

**Ургах орчин:** Шинэсэн ой, түүний зах, ойн ба голын эргийн нуга, сөөгөн ширэнгэнд ургана. Хуш- гацуур- хус бүхий үетэн- алагөвст холимог ойн зах, алагөвст уулын хээр, нарс- хус бүхий үетэн- алагөвст ойн цоорхой, улалж- алагөвст бургас- улиасан шугуй, үетэн- алагөвст уулын хээрт ургана.

**Тархац-байршил:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Их нууруудын хотгор (Тагнын нурууны урд хажуу)

**Орон нутаг дахь тархац-байршил:** (88-р зураг, 35-р хүснэгт)

35-р хүснэгт

#### Азийн Төлөгч-өвсний тархац, ургах эвшил

Аймаг, сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Шилийн богд. 45° 28'15,0", 114° 34' 54". Д.т.д. 1680 м	Үетэн- алагөвст уулын хээрт	Дорнод Монгол (Дарьганга)

**Хэрэглээ, ач холбогдол:** Энэ ургамлын хандыг уушигны болон умайн цус алдалт, цагаан мах гарах, ходоод гэдэсний шархлаанд хэрэглэнэ. Мөн төлөгч өвсний хандаар таримал ургамлын хортон шавьжийг устгахад хэрэглэдэг тухай мэдээ бий. ОХУ-ын анагаах ухааны эмнэлэгт эгэл төлөгч өвсийг



хэрэглэдэг. Ходоодны архаг үрэвсэл (*гастрит*), ходоодны шархлаа өвчнүүдэд төлөгч өвсний газрын дээд хэсгийг хэрэглэнэ.

Газрын дээд хэсгийг цэцэглэлтийн хугацаанд хур тунадасгүй үед 15 см-ээс багагүй урттай хайчилж авна. Сагс баг цэцгийг элдэв хогоос цэвэрлэж сүүдэр газар цаас юмуу даавуун дээр 5-7 см зузаантайгаар дэлгээд байн байн эргүүлж, цаг агаар хэвийн үед 7-10 хоног байлгаж хатаана. Мөн хатаагч шүүгээнд 40-50°C хэмд хатааж болно. Хатаасны дараа хугархай байгаа эсэхийг тогтоож зөвхөн баг цэцэгтэй хэсгийг гараар хугалж авна. Таар, даавуун бол цаасан уутанд 2 жил хадгална.

### ТУЙПЛАНЦАР

Латин нэр: *Phlomis tuberosa* L.=*Phlomoides tuberosa* (L.) Moench.

Монгол нэр: **Булцуут Туйпланцар**

Адилцаа нэр: Туйплин, Угалзан туруу


Орос нэр: Зопник клубненосный

Англи нэр: Tuberosroot Jerusalem-sage

**Ангилалзүйн шинж:** Үзүүрээдээ мөчирлөг нэг юмуу хэд хэдэн салаа иштэй, 70-100 см өндөр олон наст өвслөг ургамал. Үндсэндээ булцуу үүсгэдэг. Навч өндгөрхүү, эсвэл зүрхэрхүү-юлд хэлбэртэй, гүн зүрхэн суурьтай, ирмэгээрээ мохоо шүдлэг. Цэцэг ягаан, хоорондоо зайтай олон тойруулгад (ишээ бүслэж) нэгдэж, улмаар ишний үзүүрийн баг цэцэг үүсгэнэ. (89-р зураг)

**Ургах орчин:** Ойт хээр, хээрийн бүсэд нугархаг хээр, нугархаг хажуу, ойн чөлөө, эргийн хайрга, сайрын ёроол, хуурайвтар нугад ургана.

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монголын тойрог ургадаг.



**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (90-р зураг, 36-р хүснэгт).

## Булцуут Туйпланцарын тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Шилийн Богд. 45° 28'16.4", 114° 35' 02,32". д.т.д. 1679 м	Хялгана- агь- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Ачаа уулнаас зүүн хойт зүгт 8 км зайд	Хялгана- агь- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уулаас зүүн хойш 17 км-т, Талын агуй. Бэсрэг уулсын дундах хөндий. 45° 35' 237", 114° 30' 029"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уулаас зүүн хойш, Талын агуйгаас урагш 5 км-т, Шилийн Богд орох замд. Бэсрэг уулсын дундах хөндий.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уулаас баруун тийш 5 км-т.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	Тээг уулын хойд уулын бэл	Алаг өвс-үетэнт хээр	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47°18'317", 112°12'010", 1093 м-т	Хялгана- агь- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Түмэнцогт ууланд	Баялаг алаг өвс-үетэнт	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	47°18'514", 112°12'104", 1004 м-т	Алаг өвс-агь-хазаар өвст	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	46°44'289", 112°12'314", 1062 м-т	Хялгана-сэдэргэнэ-түнгэ-таанат	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Мөнххаан уулын баруун хойд бэл	Сөөг бүхий алаг өвс-үетэнт	Дундад Халх (дорнод)
Халзан	Яргайтын ам	Алаг өвс-агь-хазаар өвст	Дундад Халх (дорнод)
Асгат	Шарга уул. 46° 23'41,4", 113° 21' 20,4". Д.т.д. 1205 м.	Шарга уулын чулуурхаг баруун энгэрийн үетэн-таанат эвшил	Дорнод Монгол (Дарьганга)

**Биологийн идэвхит бодис:** Өвсөнд лютеолин, апигенин, тэдгээрийн 7-глюкуронид, лютеолины 7-глюкозид, ориентин, гомориентин, кофеин, ферулын болон хлорогенийн, неохлаорогенийн зэрэг фенолкарбоны хүчлүүд, идээлгийн бодис, стероид, алкалоид, лав байдаг. Үндсэнд сапонин, алкалоидтой. Үрэнд өөх тос бий.

**Хэрэглээ үйлчилгээ:** Бага зэрэг хортой, халуун дарах, ханиахыг зогсоох, шинэ мах түрүүлж шарх эдгэрүүлэх чадалтай.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Үндсийг 9-10 сард ухаж аваад сахал үндсийг таслаж хаяад, шороо, чулуунаас цэвэрлэн угааж зөвхөн булцуу үндсийг хэрчиж хатаана. Түүхий эдийг бэлтгэхдээ эхлээд үрийг нь түүж аваад дараа нь нас гүйцсэн болон хөгшин туйпланцарын үндсийг ухаж авах бөгөөд залуу ургамлын үндсийг ухаж авалгүй үлдээж нөхөн сэргээлтийг хангах нь уг ургамлыг ховордон устахаас сэргийлнэ.

## УЛААГАНА

Латин нэр: *Ribes diacanta* Pall.

Монгол нэр: **Хос шивүүрт Улаагана**

Адилцаа нэр: Ухнын шээг, тэхийн шээг

Орос нэр: Смородина двуиглая, таранушка


Англи нэр: Siberian Currant

**Ангилалзүйн шинж:** Цэцэг дан бэлэгтэй, хоёр гэрт сөөг. Навчис 3-3.5 см өргөн, илтэс гялгар, хар ногоон, үзүүртээ гурван бяцхан салбантай. Навчныхаа угт хос өргөстэй. (91-р зураг)

**Ургах орчин:** Чулуурхаг энгэр, уулын хажуу, голын эрэг, өндийгөөр ургана.

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дорнод Монголын тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Холбоогийн элсэнд, Молцог элсний манханд (45°14'15,2", 114° 04' 50,7". Д.т.д. 1337 м.) тохиолдоно (92-р зураг)



91-р зураг. Хос шивүүрт Улаагана

92-р зураг. Хос шивүүрт Улааганын тархац

**Гарц-нөөц:** Дарьганга сумын II баг, Холбоо нуурын баруун манх, малчин Батсүхийн өвөлжөөнөөс баруун урагш 1 км зайд манхны зүүн хажуугийн бэлээр тэхийн шээгний 4-5 бут тохиолдоно.

**Хэрэглээ үйлчилгээ:** Монгол ардын эмнэлэгт бөөр, шээсний замын өвчинд хэрэглэнэ.

## ХАВРАГ

Латин нэр: *Ferula bungeana* Kitag.

Монгол нэр: **Бунгийн Хавраг**

Адилцаа нэр: Хавраг

Орос нэр: Ферула Бунге, Горичник твердый

Англи нэр: Bunge Giantfennel

**Ангилалзүйн шинж:** Олон наст өвслөг ургамал. Поликарп. Үндэс голлосон. Иш салаархаг, 30-50 (70) см өндөр. Навчис нүцгэн, хошоод ба гурвантаа цуулбар өдлөг. Гол шүхэр 6-12 (15) см голдочтой, адил урттрай 6-12 шилбэтэй. Шүхэр үрлэх үедээ томордог. Хажуугийн шүхэр 1-3 см голдочтой, ишнийхээ суганаас гарсан. Цэцэг цагаан. Дэлбийн хэлтэсний орой бүтэн. Үр жимс гонзгой зуувгар, 10-14 (18) мм урт, 5-7 мм өргөн, хавиргалаг.  $2n=22$ . (93-р зураг)

**Ургах орчин:** Цөлөрхөг хээр, хээрийн бүсэд уулын бэл, хуурай сайр, элсэрхэг товцог болон элсэнд ургана.

**Монгол дахь тархац:** Хянган (Нөмрөгийн застав), Дундад Халх, Дорнод Монгол (Дарьганга, Молцог элс), Их нууруудын хотгор (Төгрөгийн гол, Хар-Ус нуур), Олон нуурын хөндий, Дорноговь (Баянзаг, Зүүнбаян, Хутаг уул), Говь-Алтай (Гурван Сайхан, Арц Богд), Зүүнгарын говь (Байтаг Богд, Их Алаг уул, Тэхийн шар нуруу), Алтайн Өвөр говь (Энгэрийн ус), Алашаа говь (Хутаг уул, Баян уул) зэрэг тойрогт тархсан.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Дарьгангын Холбоогийн элс, Молцог элсэнд ургах бөгөөд Онгон элсэнд шинээр тэмдэглэсэн. (94-р зураг)



93-р зураг. Бүнгийн Хавраг

94-р зураг. Бүнгийн Хаврагийн тархац

**Биологийн идэвхит бодис:** Үндэс, газрын дээд хэсэг, жимсэнд кумаринууд бий бөгөөд хуурай жимсэнд 1.2%-ын кумарин агуулагдаг. Жимсэнд 1.08%-ын шар, цайвар шар өнгийн эфирийн тостой. Тэр эфирийн тосны бүрэлдэхүүнд мирцен, лимонен,  $\alpha$ -пинен,  $\beta$ -пинен, сабинен, цис- $\alpha$ -оцимен,  $\eta$ -цимол оролцоно. Мөн жимсэнд тритерпеноидууд агуулагдана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Монгол эмнэлэгт халууныг арилган хорыг тайлах, хавдрыг хариулах, сүрьеэг дарах, өвдөлтийг зогсоох чадалтай. Мөн ясны сүрьеэ, лимфийн сүрьеэ, өгөрлөсөн шархлаа, бамбай булчирхайн өрөвсөл зэрэг нянтай өвчин болон хавирган завсрын мэдрэл өвдөх зэргийг засна.

## **ХАЙЛААС**

Латин нэр: *Ulmus pumila L.*

Монгол нэр: **Одой Хайлаас**

Адилцаа нэр: Тарваган хайлаас


Орос нэр: Ильим приземистый

Англи нэр: Siberian Elm

**Ангилалзүйн шинж:** Залуу мөчир найлзуур үйсэн далавчгүй, бөөрөнхий; шаргал саарал холтос бүхий (3)4-12(16) м өндөр мод. Навчны илтэсний суурь бараг тэнцүү талтай, мөчрийн хоёр хажуугаар цувж байрласан, богино бариултай, бүтэн, шүдлэг навчистай. Далбанцар буюу далавчит жимс хэлтгий суурьтай, өргөн-зуувгар, 1.5-2 см голчтой, үр нь төвдөө байна. 4-5-р сард цэцэглэнэ.(95-р зураг)

**Ургах (тархацын) орчин:** Хад чулуутай хажуу энгэр, бэл, ам хавцал түүний ёроол, сайр садрагын ирмэг, голын хуурай хөндий, элс, элсэнд ургасан сийрэг нарсан ойд ургана. Тэхдээ ойт хээр, хээрийн бүсийн голын эрэг, мөргүүгийн чулуутай хормой, голын хаялгаас гарсан сайр дээгүүр ихэвчлэн ургах ба толгодын чулуутай энгэрээр хааяа тохиолдоно. Говь нутагт хөрсний ус ойртой хуурай сайр дагаж зурваслан ургана. Дорнодын талд ул хөрсний өнгөцхөн хотгоруудад бас тохиолдоно.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл(баруун), Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Монгол Алтай(баруун хойт), Дундад Халх, Дорнод Монгол, Дорноговь, Говь-Алтай, Алашаа говь.



95-р зураг. Одой Хайлаас

96-р зураг. Одой Хайлаасны тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (96-р зураг, 37-р хүснэгт).

37-р хүснэгт

**Одой Хайлаасны тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Молцог элс. 45° 28'16.2", 114° 35' 01.1".	Хялгана- агь- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Халзан	Гангын ам. 44° 26'23,4", 112° 50' 11,4". Д.т.д. 1031 м	Гангын амны жалгаар хялгана- агь- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Асгат	Шарга уул. 46° 23'42,1", 113° 21' 16,9". Д.т.д.1180 м	Хялгана- агь- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)

**Гарц-нөөц:** Нөөц, тархацыг тусгай судалгаагаар нарийвчлан тогтоох шаардлагатай.

**Биологийн идэвхт бодис:** Холтсонд рутин, астрагалин, кемпферол, кверцетин, изокверцитринээс бүрдсэн флавоноидууд илэрсэн. Навчинд кверцетин, кемпферол, рутин, изокверцитрин, 3-глюкуронид кверцетина, 3-0-β-D-глюкопиранозид кемпферола зэрэг флавоноидууд бий.

**Хэрэглээ үйлчилгээ:** Монгол эмнэлэгт навч, холтос нь ходоод, гэдэсний үйл ажиллагаа хямрах, биж зэрэг өвчнийг эмчлэхэд; Солонгос эмнэлэгт холтсыг цэр ховхлох, их шээлгэх, зөөлөн туулгах зориулалтаар олгох ба үүнийг бас өтгөн хатах, шээхэд бэрхшээх, хаван, хуурай ханиалга, уушигны мөгөөрсөн гуурсны үрэвсэл зэргийг анагаахад хэрэглэнэ.

**ХАЛГАЙ**

Латин нэр: *Urtica angustifolia Fisch. ex Hornem.*

Монгол нэр: **Нарийн навчит Халгай**

Адилцаа нэр: Халгай

Орос нэр: Крапива двудомная

Англи нэр: Narrowleaf Nettle, Narrow leaved Nettle


**Ангилалзүйн шинж:** Эгц шулуун, 50-100 см өндөр иш, мөлхөө үндэслэг иш бүхий олон наст өвслөг ургамал. Уртассан юлд юмуу өндгөрхүү-юлд хэлбэртэй, 15 см урт навчтай. Баг цэцэг үслэгтэй, үр нь 1 мм орчим урт самранцар(97-р зураг).

**Ургах орчин:** Голын эрэг, сөөгөн ширэнгэт шугуйн зах хөвөө, хад асга, үхэр чулууны ёроол, шинэсэн ой, ам хөндийн эхэнд ургадаг. Малын хашаа, айлын бууц, хогийн газраар ч тохиолдоно.

Үетэн-шарилж-лууль зонхилсон /хуучин бууц орчим/ эвшилд Sp арвитай тохиолдоно.

**Монгол дахь тархац:** Хангай, Монгол Дагуур, Хөвсгөл, Хэнтий, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Говь-Алтай, Зүүнгарын говийн тойргуудад ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Сүхбаатар аймгийн ихэнх сумдын нутагт ургана(98-р зураг, 37-р хүснэгт).



97-р зураг. Нарийннавчит Халгай

98-р зураг. Нарийннавчит Халгайн тархац

**Биологийн идэвхит бодис:** Цэцэглэж байхдаа газрын дээрх хэсгийн үнэмлэхүй хуурай түүхий эдэд 156.7 мг/кг каротинтой. Тэр нь үрлэх үед буурна. Иш, навчинд уураг, цардуул, аминдэмт нэгдлүүд агуулагддаг.

**Хэрэглээ үйлчилгээ:** Ишний хальсны ширхэгээр нэхмэл эдлэл хийх (утас ээрч, нэхмэл бөс даавуу) ба иш, навч нь арьс эдээлгийн түүхий эд болно. Түүнчлэн халгайг ганга, бэр цэцэг, зээргэнэ болон бусад ургамалтай хольж хандлан үс уналтыг зогсоох зорилгоор навчны идээшмэл бэлтгэн толгойгоо (үсээ) угааж хэрэглэнэ. Монголчууд халгайг залуу байхад нь (сөөм хиртэй) түүж чийг бам хөдлөхөд тамир тэнхээ оруулах зорилгоор буцалгаж юмуу битүү (бууз,

хуушуур г.м.) хоолонд хольж хэрэглэгдэг бөгөөд хоол амт оруулах, ногоотой шөл бэлтгэхэд навчийг хэрэглэдэг.

## ХАРГАНА

Латин нэр: *Caragana microphylla (Pall.) Lam.*

Монгол нэр: **Жижигнавчит Харгана**

Адилцаа нэр: Бяцханнавчит харгана, үхэр харгана, үхэр бут,

Орос нэр: Карагана мелколистная

Англи нэр: Littleleaf Peashtub

**Ангилалзүйн шинж:** Энэ нь 1 м орчим өндөр сөөг. Навч үзүүртээ оньтой буюу мухар оройтой бяцхан, нүцгэн навчинцараас тотсон өдлөг навчтай. Цэцэг шар, хоолойрхуу буюу хонхорхуу-хоолой маягтай, түүний урт нь өргөнөөсөө илүү, цоморлигийн шүд томдуу 1.5-2.5 мм урт. Буурцаг шугамархуу(99-р зураг).

**Ургах орчин:** Элсэрхэг хээр, хээрийн хайргархаг, чулуурхаг хажуу, довцог сэвхүүл элс, хад нуранганд ургана.

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай(дорнод, зүүн хойд хэсэг), Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монголын тойргуудад тархана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (100-р зураг, 38-р хүснэгт)

38-р хүснэгт

### Харганы тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хан уул	Таана- үетэнт уулын нуга.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уул	Хялгана- агь- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Гангын цагаан уул	Хялгана- агь- алагөвст хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Холбоогийн элс	Бургас- хайлаас бүхий үетэн- алагөвст элсэн довцог.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Молцог элс. Сумын төвөөс баруун тийш 25 км-т. Молцог элсний баруун хэсэг	Үетэн- алагөвст эвшил.	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр	Онгон элсэнд	Харгана бүхий агь- үетэн- алагөвст	Дундад Халх (дорнод)
Асгат	Сумын төвөөс зүүн урагш Эрдэнэцагаан явах замд	Алаг өвс-хазаар өвс- хялганат	Дундад Халх (дорнод)
Халзан	Төхөмийн тал	Алаг өвс-үетэнт (харганатай) эвшил	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Өндөрлөг тэгш тал-47°44'38.5", 112°23'25.1", 969 м-т	Алаг өвс-Шарилж-Үетэнт (харганатай) эвшил	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Баян цагааны урд уулын баруун хойд ар	Агь-Алаг өвс-Үетэнт (Ботуульт)	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Бэрлэг уулын бэл, Хэрлэн голын урд тэгш хөндий	Харгана бүхий ерхөг-агь- хазаар өвст	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Талбулгийн хөндий	Алаг өвс-хазаар өвс- хялганат	Дундад Халх (дорнод)



Түмэнцогт	47°37'087", 112°25'018", 975 м-т	Харгана бүхий алаг өвс-улалж-үетэнт	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47°31'238", 112°19'497", 1028 м-т	Алаг өвс-хялгана-улалжит	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47°27'034", 112°17'351", 1043 м-т	Хазаар өвс-улалж-хялганат	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Тэгш тал бүрэнцогт орох зам дагуу	Харгана бүхий-түнгэ-улалж хазаар өвст бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Уулын тэгш орой, 47°00' 51.8", 112°09' 11.1", 1208 м-т	Харгана бүхий шарилж-түнгэ-хазаар өвст бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)



99-р зураг. Жижигнавчит Харгана



100-р зураг. Жижигнавчит Харганын тархац

**Хэрэглээ үйлчилгээ:** Үр шарыг дарах, хорыг тайлах чадалтай. Үндэс нь халууныг арилгаж, сарисныг хураах чадалтай. Мөн шарын өвчин, хор харшсан, сахуу зэргийг засна.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Намар үр, үндсийг авч хальсыг нь хусаж арилгаад угаан цэвэрлэж сүүдэр газар хатаана. Түүхий эдийг бэлтгэхдээ эхлээд үрийг нь түүж аваад дараа нь үндсийг ухаж авахдаа залуу ургамлын үндсийг ухаж авалгүй үлдээж нөхөн сэргээлтийг хангах нь уг ургамлыг устахаас сэргийлнэ. Ер харганын төрлийн ургамал элсэрхэг хээр, хуурай хээрийн элсэн хөрс, довцог сэвхүүл элсийг салхиар нүүдэллэхээс хамгаалж, хөрсийг бэхжүүлэх зэрэг орчинзүйн чухал ач холбогдолтой ургамал тул түүж бэлтгэхэд онцгой хяналт тогтоож, үйлдвэрлэлийн бэлтгэл явуулахыг хориглох шаардлагатай юм.

## ХАРМАГ

Латин нэр: *Nitraria sibirica* Pall.

Монгол нэр: **Сибирь Хармаг**

Адилцаа нэр: Товцог, сондуул

Орос нэр: Селитрянка сибирская

Англи нэр: Siberian Nitraria

**Ангилалзүйн шинж:** Хотир-Zygophyllaceae R.Br.-овгийн Хармаг-Nitraria L.-ийн төрөлд хамрагдах 50-80 см өндөртэй навтгар сөөг. Элсэн довцог үүсгэдэг бөгөөд 1 м хүртэл урт дэлхээ нумран тахийсан мөчир нь салаа ихтэй, цайвар хальсаар хучигдсан хучигдсан өргөслөг байна. Навчис юлдэрхүү 1-2.5 см урт, 8 мм хүртэл өргөн. Жижгэвтэр цагаан цэцэгтэй. Яст жимсгэнэ хүрэн улаан, өндгөрхүү юмуу бөмбөлөгөрхүү, жижигхэн өндгөрхүү үртэй. VI-VII сарын эх хүртэл цэцэглэж, VII-VIII сард жимслэнэ (101-р зураг)

**Ургах орчин:** Цөл, цөлөрхөг хээрт марц хужиртай, элсэнцэр хөрстэй хотгоруудаар сондуул үүсгэж ургана

**Монгол дахь тархац:** Монгол Дагуур (баруун хойт хэсэгт, Буурын голын хөндий), Монгол Алтай (Хасагт хайрхан нуруу, Как кулийн нуур), Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Зүүнгарын говь, Алтайн өвөр говь, Алашаа говийн тойргуудын ургана.


**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (102-р зураг, 39-р хүснэгт).

39-р хүснэгт

### Сибирь Хармагны тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Лаг нуурын орчимд	Таана- үетэнт нугын хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Наран	Хар тойромын (44° 56'30,0", 113° 58' 52,0". Д.т.д.1345 м)	Хармагт элсэн тарамцагт	Дорнод Монгол (Дарьганга)
Мөнххаан	Дэлгэрийн Хөдөө нуурын орчим	Таана- үетэнт элсэн хонхор	Дундад Халх (дорнод)
Онгон	Баавхайн говь, Зүрхийн говьд	Хармагт элсэн тарамцагт	Дундад Халх (дорнод)

**Гарц- нөөц:** Наран сумын Хар тойромын хармагийн бут 1,5 х 0.7 км<sup>2</sup> талбайд тохиолдоно.



101-р зураг. Сибирь Хармаг

102-р зураг. Сибирь Хармагийн тархац

**Биологийн идэвхит бодис:** Сибирь хармагны навч 1.03-1.15%, иш 1.11-1.16 %, үндэс 1.13-1.17 % алкалоидтай, найрлаганд нь изонитрамин, нитрамин, нитрарамин, вазацинон, сибирин, шоберин, нитрабирин, нитрарамины эсэл,

дезоксивазицинон байна. Жимсэнд органик хүчил 0.65-2.43%, С аминдэм 21.4-32.1 мг%, нийт сахар 9.42-11% агуулагдана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Амтлаг, эсгэлэн амттай бөгөөд бүлээн чанартай, биеийг шимжүүлэх, хоол шингээх, сарын тэмдгийн хэм хэмжээг тэгшитгэх чадалтай. Навчнаас бэлтгэсэн эм нь тайвшруулах үйлдэлтэй, жимсний чанамал, хандмал, ханд нь зүрхний ажиллагааг эрчимжүүлж цусны даралт бууруулна. Гөлгөр булчингийн ажиллагааг сулруулна. Зүрхний ажиллагаа суларч цусны даралт ихсэх, гэдэс базлан суулгах зэрэгт тунг тохируулан хэрэглэнэ. Тун хэтэрвэл амьсгалын төв саатах аюултай ажээ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Намар боловсорсон жимсийг түүж цэвэрлээд сайтар хатааж хэрэглэнэ. Хармаг нь хүнс, эмийн өндөр ач холбогдол ургамал боловч манай орны говь цөлийн бүсийн ургамлан бүрхэвчийг хамгаалахад голлох үүрэгтэй ургах тул хамгаалж, зохистой ашиглах нь зүйтэй.

## **ХОНИНЗАЖЛУУР**

Латин нэр: *Linaria buriatica Turcz.*

Монгол нэр: **Буриад Хонинзажлуур**

Адилцаа нэр: Хонинзажлуур, зажлуургана, хонинзажлагч

Орос нэр: Льянка буриадская


Англи нэр: Manybranch Toadflax

**Ангилалзүйн шинж:** Иш нь навчирхаг бөгөөд нумарч өндийсөн 10-20 см өндөр 1-4 иштэй олон наст өвслөг ургамал. 1-2 см урт шугамархуу юмуу шугаман-юлдэрхүү навчтай. Завжиндаа тод улаан шаргал толбо бүхий шар дэлбээтэй. Иш мөчрийн оройд чигжүү түрүүрхүү баг цэцэгтэй.Цоморлигийн навчинцар 5-6 мм урт(103-р зураг).

**Ургах орчин:** Ойт хээрийн ба хээрийн бүсийн нутгийн нугат хээрт сийрэг боловч олон тааралдана.Заримдаа чулуурхаг, хайргархаг хажуу, ойн хаяа, голын эрэг, сөөгөн дунд ургасан байдаг.



103-р зураг. Буриад хонинзажлуур



104-р зураг. Буриад Хонинзажлуурын тархац

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монголын тойрогт тархсан.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (104-р зураг, 40-р хүснэгт)

40-р хүснэгт

**Буриад Хонинзажлуурын тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Зотол уул	Агь-алаг өвс-үетэнт	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд ууланд	Харгана бүхий алаг өвс-үетэнт	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	Усны хуримтлал ихтэй хоёр гүвээний хоорондахь хөндий жалга	Алаг өвс-түнгэт бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Баян цагааны урд уулын баруун хойд ар	Агь-алаг өвс-үетэнт (Ботуульт)	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47°37'087", 112°25'018", 975 м-т	Харгана бүхий алаг өвс-улалж-үетэнт	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47°18'514", 112°12'104", 1004 м-т	Алаг өвс-агь-хазаар өвст	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Дэлгэрийн нуураас баруун тийш 2-4 км	Агь-хазаар өвс-крыловын хялганат	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	47°15'051", 112°10'496", 1163 м-т	Алаг өвс-үетэн-хялганат	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Баян уулын орой 46°59' 18.8", 111°54' 36.3", 1578 м-т	Баялаг алаг өвс-үетэнт бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэг флавант гликозид, алкалоид агуулагдана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Гашуун амттай, хүйтэн чанартай бөгөөд халууныг арилгах, хорыг тайлах, хавдрыг хариулах зэрэг чадалтай. Хижиг шарын халуун, нуугдсан халуун, хавдар, галд халсан шарх зэргийг засна.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Газрын дээрх цэцэглэж буй хэсгийг хураан авч гэмтэж муудсан хэсгийг хаяж бусад элдэв хольцоноос цэвэрлээд сүүдэр газар хатааж хэрэглэнэ.

## ХОРС

Латин нэр: *Aconitum kuznezoffii Reich.= Aconitum birodshanicum Woroschilov.*

Монгол нэр: Кузнецовын Хорс

Адилцаа нэр: Чоноголын бонго

Орос нэр: Аконит Кузнецова

Англи нэр: Kuznetsov's Monkshood

**Ангилалзүйн шинж:** Гялгар нүцгэн иштэй, 1.5 м хүртэл өндөр ургадаг олон наст өвслөг ургамал. Нягт ширүүвтэр навч сууриндаа тултал цуурч хурц шүдлэг 3-5 том ромбон салбанг /сегмент/ үүсгэнэ. Навч 5-12 см урт, 10-17 см өргөн, дундах жижиг илтэс ромбо хэлбэртэй өдлөг гүн хуваагдмал, жижиг сэжүүр илтэс өндөгөрхүү хэлбэртэй. Бөмбөгөр оройт намхан дуулган хөх цэцэгтэй. Балын булчирхайн илтэс цүндгэр, 3-5 см өргөн, үзүүртээ тахир нарийн годойтой, үрэвч 5, нүцгэн. Багцэцэг өтгөн багсгар(105-р зураг).



105-р зураг. Кузнецовын Хорс.



106-р зураг. Кузнецовын Хорсын тархац

**Ургах орчин:** Үетэн-алаг өвст нугад ургана.

**Тархац-байршил:** Хянган, Дорнод Монголын тойрогт тохиолдоно.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (106-р зураг, 41-р хүснэгт).

41-р хүснэгт

### Кузнецовын Хорсын тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Ачаа толгойн баруун талд Асгатын горхины эх орчим	Бэсрэг уул толгодын дундах үетэн- алагөвст нуга	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн богд. 45° 28'16,2", 114° 35' 01,1". Д.т.д. 1685 м	Уулын ар хормойд алагөвст эвшил	Дорнод Монгол (Дарьганга)

**Гарц-нөөц:** Өнгөрсөн зуунд ардын эмнэлэгт өргөн хэрэглэж байснаас эзлэн ургах газрын тоо хэмжээ, бие гүйцсэн бодгалийн тоо байнга буурч байна.

Шилийн Богд уулны хойт хажууд 1м<sup>2</sup> талбай дахь хуурай навчны жин-74,9 гр, ишний үнэмлэхүй хуурай жин-174,1 гр. Энд хорс 10 x 35 м<sup>2</sup> талбайд жигд ургана.

**Хэрэглээ, ач холбогдол:** Их хортой, мэдээ алдуулна. Нян хорхойг хөнөөх, хижиг, хаван, өрөвслийг намдаах, хорын хүчийг сааруулах, шар усыг хатаах, бадгана хүйтнийг арилгах зэрэг чадалтай.

## ХОТОЙ

Латин нэр: **Leonurus sibiricus L.**

Монгол нэр: **Сибирь Хотой**

Адилцаа нэр: Хотой

Орос нэр: Пустырник сибирский

Англи нэр: Siberian Motherwort

**Ангилалзүйн шинж:** Ёзоороосоо эхлэн салаалсан дөрвөн талтай, 30-100 см өндөр иштэй, нэг юмуу хоёр настай өвслөг ургамал. Навч өндгөрхүү юмуу уртавтар шугамархуу, лав цуурч үссэн 3-5 далбантай. Дээд уруул нь юлдэн адил, ягаан дэлбээтэй. Цоморлиг шөвгөрхүү хатгуурт шүдтэй(107-р зураг).

**Ургах орчин:** Хээрийн чулуурхаг хажуу, хуурай жалга, дэнж, ёроол, айлын бууц болон тариан талбайд ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Дундад Халх, Дорнод Монгол, Дорноговийн тойрогт тархан ургадаг.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (108-р зураг, 42-р хүснэгт).


42-р хүснэгт

### Сибирь Хотойн тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хан уул	Алаг өвс-хялгана-хазаар өвст бүлгэмдэл	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Талын агуй	Алаг өвс-хялгана-хазаар өвст талхлагдсан бүлгэмдэл	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уулын орчим	Алаг өвс-үетэнт хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Мөнххаан	46°45'203", 112°12'762", 1122 м-т	Алаг өвс-хялгана-хазаар өвст талхлагдсан бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	46°44'545", 112°12'552", 1071 м-т	Харгана бүхий түнгэт бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	46°44'289", 112°12'314", 1062 м-т	Нэг настын синузи бүхий түнгэ-ишгэн шарилжит бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Түмэнцогт уулын орчимд	Баялаг алаг өвс-үетэнт бүлгэмэл	Дундад Халх (дорнод)



107-р зураг. Сибирь Хотой



108-р зураг. Сибирь Хотойн тархац

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт алкалоид (стахидрин, леонурин), идээлгийн бодис, хүчиллэг сапонин, эфирийн тос, рутин, кумарины хүчил, зүрхэнд үйлчлэгч глюкозид; үрэнд леонуринин агуулдаг.

**Хэрэглээ үйлчилгээ:** Цэцэг, навчийг цусны гүйдлийг сайжруулах, сарын тэмдэг зохицуулах, халууныг арилгах, шээлгэх, нүдний цагааг арилгах чадалтай. Үр нь элэгний халууныг арилгах, цусны даралтыг бууруулах, нүдэнд туслах чадалтай.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Зун, намар иш өндөр болж навч, цэцэг жигдрэх үед ишний цэцэг, навчтай хэсгийг хураан авч хэрчээд сүүдэр газар хатааж хэрэглэнэ.

## ХӨВӨНТ

Латин нэр: *Chamaenerion angustifolium (L.) Scop.*

Монгол нэр: **Нарийннавчит Хөвөнт**

Адилцаа нэр: Хөвөн оройт, уртнавчит хөвөнт, уулын цай

Орос нэр: Хамерион узколистый, кипрей узколистый, иван-чай

Англи нэр: Greet Willowherb, Fireweed

**Ангилалзүйн шинж:** Шулуун, нүцгэн иштэй 50-150 см өндөр, олон наст өвслөг ургамал. Навчис гонзгойвдор, налуудуу шугаман-юлдэрхүү шовх оройтой, тод судалтай. Дөрвөлсөн илтэстэй, цоморлог ягаан, урт том цацагтай. (109-р зураг).

**Ургах орчин:** Голын эрэг, хус шинэсэн ой, түүний цоорхой, шатсан ой, ойн захын нуга нугархаг бэлээр ургана.



109-р зураг. Нарийннавчит Хөвөнт



110-р зураг. Нарийннавчит Хөвөнтийн тархац.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монголын тойрогт тархан ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (110-р зураг, 43-р хүснэгт).

43-р хүснэгт

**Нарийн навчит Хөвөнт тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хан уул	Чулуусаг алагөвс- үетэнт хажуу.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан	Лхачинвандад уулын орчим	Алагөвс- үетэнт хажуу.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уул. 45° 28'15,6", 114° 35' 01.4". Д.т.д. 1688 м	Сөөг бүхий алаг өвс-үетэнт хээр	Дорнод Монгол (Дарьганга)
Мөнххаан	Мөнххаан уулын урд энгэр	Сөөг бүхий алаг өвс-үетэнт	Дундад Халх (дорнод)

**Гарц-нөөц:** 1 м<sup>2</sup> талбай дахь навчны үнэмлэхүй хуурай жин 88,4 гр, ишний хуурай жин 106,2 гр. Энд хөвөн оройт 1,5 га талбайд жигд бус тархдаг.

**Биологийн идэвхит бодис:** Навчинд С аминдэм 388 мг/%, каротин, аргаах бодис, сахар, пектин, алкалоид, кумарин, антоциан, флавоноид агуулна. Залуу үндэслэг ишэнд аргаах бодис 20% хүртэл, алкалоид, цардуул, чихэрлэг бодис, С аминдэм; үрэнд өөх тос 40-45% хүртэл байна. Газрын дээд хэсэгт аклалоид 0.01-0.79%, сапонин бага бус байх ба үндсэнд 0.06-0.22% акалоидтой, мөн навчинд нилээд флавоноид агуулдгийг эрдэмтэд тогтоосон.

**Хэрэглээ үйлчилгээ:** Чих булагтах, хамар хоолойн өвчин, түрүү булчирхай, давсагны үрэвсэл, нойргүйдэх, толгойн өвчин, арванхоёр нугалаа гэдэс болон ходоодны шархлаа, ходоодны үрэвсэл, бүдүүн гэдэсний үрэвсэл, цус багадах, цус алдах, хандаар нь хоолой өвдсөн үед амаа зайлах ба шарх, шархлааг шавшиж угаана.



## МОНГОЛ ХУНЧИР

Латин нэр: *Astragalus mongolicus* Bge. = *Phaca macrostachys* Turcz.

Монгол нэр: Монгол Хунчир

Адилцаа нэр: Хунчир, Түвд нэрээр: Сарадсэр, созисэрпо, сарадма, хуанци, бүрүланагзадзор, жисранганбужан

Орос нэр: Астрагал монгольский


Англи нэр: Mongolian Milkvech.

**Ангилалзүйн шинж:** Ховилтой шулуун бараг нүцгэн иш хөгжил сайтай 15-30 см өндөр олон наст өвслөг ургамал. Дээд гадаргуу нь нүцгэн, доод гадаргуу нь сийрэг үслэг, гозгойвтор урвуу өндөгөрхүү, зууван дугуй буюу гогзгойвтор-зууван дугуй, 4-10 мм хүртэл урт, 2-5 мм өргөн, 10-18 хос навчинцар бүхий навчтай. Шар дэлбэтэй, 10-18 мм урт, гонзгойвтор, сийрэг, цацаг баг цэцэгтэй. Сэлүүр нь завинаасаа урт. Буурцаг гөлгөр юмуу үл мэдэг үрчгэрдүү, нимгэн сарьслаг, илэрхий мэдэгдэх тэгш бус хажуутай тал дугариг юмуу бараг тал дугаригдуу, 15-30 см урт. Үрэвч, буурцаг нүцгэн нэг тасалгаатай. VI-VII сард цэцэглэнэ.(111-р зураг)

**Ургах (тархацын) орчин:** Хээр, сайрын элсэрхэг-хайргархаг ёроол, хайргатай дэнж, элстэй чулуутай асга, байц хадны ёроол сөөгөн ширэнгэ шинэсэн ойн захаар д.т.д 1250-1650 м өндөрт ургана. Шинэс- улиас бүхий алагөвст холимог ойн зах, бургас- хайлаас бүхий үетэн- алагөвст элсэн довцог болон элдэв өвст- үетэнт уулын хээр, хээрт ургана.



111-р зураг. Монгол Хунчир



112-р зураг. Монгол Хунчирын тархац

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хангай, Монгол Дагуур, Дорнод Монгол, Монгол Алтай, Дундад Халх, Их нууруудын хотгор (Увс нуур, Зүүн Жаргалантын нуруу), Олон нуурын хөндий, Говь-Алтай

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (112-р зураг, 44-р хүснэгт).

44-р хүснэгт

### Монгол Хунчирын тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хан уул	Алаг өвс-хялгана-хазаар өвст бүлгэмдэл	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Талын агуй	Алаг өвс-хялгана-хазаар өвст талхлагдсан бүлгэмдэл	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Монгол элс, Сөдөтийн баруун элсээр	Алаг өвс-хялгана-хазаар өвст бүлгэмдэл	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Холбоо нуур. Холбоогийн элс. 45° 14' 066", 114° 08' 108"	Бургас- хайлаас бүхий үетэн- алагөвст элсэн довцог.	Дорнод Монгол (Дарьганга)

**Гарц-нөөц:** Молцог элсний урд хэсгээр элбэг ургадаг. 1920-1950 онд Өвөр монголоос хүмүүс хууль бусаар ирж, үндсийг түүдэг байсан гэж багш Дугарсүрэн ярьсан.

**Биологийн идэвхт бодис:** Газрын дээд хэсэгтээ кверцетин, изорамнетин, кверцетинин зэрэг 4.16%-ийн флавоноидтой, рамноцитрин, 3-D-глюкопиранозид изорамнетина, пропингозид ба гликозидууд, кумаринууд, эдээлгийн бодис, сапонин агуулах бөгөөд үндсэнд сапонин байдаг.

**Хэрэглээ үйлчилгээ:** Манай оронд ургадаг хунчируудаас 2 зүйл (Монгол, Сарьслаг) хунчирыг биеийг тордон тэнхрүүлэх, элдэв гэмтэл шархыг эдгээх чадалтай хэмээн уламжлалт эмнэлэгт хэрэглэдэг. Эм нь амтлаг амттай, бөгөөд өчүүхэн бүлээн чанартай, шимжүүлэх, хөлөрхийг зогсоох, идээт шар усыг татах, цус тогтоох, шарх анагаах, шинэ мах төрүүлэх, шээлгэх зэрэг чадалтай.

Бие ядарч хөлрөх, архаг суулга, цагаан мах урвах, усан хаван, шээс алдах, дотор цул савны гэмтэл, анидаггүй шарх, судлын халуун зэргийг засна. - Хий, цусан тамир хүрэлцэхгүйд хунчир 37.3 г, Дагуур цоор-18.5 г-ыг чанаж уулгана.

- Архаг суулга, цагаан мах урвасанд, хунчир 18.5 г-ыг сүүн орхоодой (Codonopsis clematidea) 14.8 г, Дагуур жавай 3.7 г, цагаан хуз 11.0 г-ыг (хуурсан) чанаж уулгана.

- Бөөрний архаг өрөвсөлд, хунчир 37.2 г, Дагуур цооргоно юм уу хэрээн нүдний үндэстэй найруулан чанаж уулгана.

- Битүү буглаа эдээлэн гадгишлахгүйд, хунчир 18.5 г, үхэр сондууны үрийн (Gleditsia sinensis Lam.) нүүрс 3.7 г-ыг чанаж уулгана.

- Битүү буглаа нэвчин задарсан ач мах түрж хумигдан эдгэрэхгүйд хунчир 22.2 г, чихэр өвс 37.7г-тай нягт талхдан өглөө, үдэш удаа бүр 11.0 г-ыг буцалсан усаар уулгана гэжээ.

Хавар, намар хунчирын үндэсийг авч цэвэрлэн хэрчээд сүүдэр газар хатаана. Хатаах буюу балаар номхотгон хэрэглэнэ.

### ХҮЖ ӨВС

Латин нэр: *Harlophyllum daurivum* (L.) G. Don.


Монгол нэр: **Дагуур Хүж өвс**

Адилцаа нэр: Хүж өвс

Орос нэр: Цельнолистник даурский

Англи нэр: Daurian Harlophyllum

**Ангилалзүйн шинж:** Иш эгц босоо, 10-25 өндөртэй, намхан заримдаг сөөгөнцөр. Навчис жижигхэн, энгийн бүтэн, суумал, тонгоруу-юлдэрхүү юмуу юлдэрхүү, бүтэн. Бамбай баг цэцэгтэй. Цэцэг 5 хэлтэстэй, зөв бүтэцтэй, шар, жижигхэн 12 мм урт. VI-VII сард цэцэглэнэ. (113-р зураг).



113-р зураг. Дагуур Хүж өвс

114-р зураг. Дагуур Хүж өвсний тархац

**Ургах орчин:** Уулархаг, цөлөрхөг, элдэв өвст хээр, хээрийн чулуурхаг, хайргархаг хажуу, бэл, асга нурга, цөлөрхөг хээрийн элсэрхэг хэсэгт ургана.

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтайн тойргуудад ургадаг.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Сүхбаатар аймгийн ихэнх сумдын нутагт харьцангуй сийрэг тархацтай боловч Эрдэнэцагаан, Дарьганга (Шилийн Богд уул), Наран, Онгон, Баяндэлгэр зэрэг сумдын говийн хэсэг буюу цөлөрхөг хээрт өргөн тархсан ургана. (114-р зураг, 45-р хүснэгт).

45-р хүснэгт

### Дагуур Хүжөвсний тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан.	Лаг нуураас баруун урагш, 35 км-т. Хашаат хоолой.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Шилийн Богд уул. 45° 28' 307",	Хүрмэн чулуун дээр	Дорнод Монгол

	114° 34'506"	тогтсон хар шороон хөрс бүхий үетэн- алагөвст хээр.	(Дарьганга)
Дарьганга.	Сумын төвөөс баруун тийш 14 км-т, Баянголын эх, Салаагийн элс. 45° 16' 197", 113° 44' 208"	Суль- хазаар өвс- харгана бүхий элсэн толгод.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Сумын төвөөс баруун тийш 42 км-т. Молцог элсний баруун хэсэг. 45° 22' 014", 113° 25'375"	Үетэн- алагөвст эвшил.	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр.	Сумын төвөөс 50 км-т, Онгон элсний баруун хойт үзүүрт. 45° 35' 596", 112° 49'039"	Харгана- үетэн- алагөвст цөлөрхөг хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Сүхбаатар.	Түмэнцогтоос зүүн урагш 116 км-т, Дорнодын Матад сум орох замд. Баян-Овоогийн говийн орчим. 47° 09' 529", 113° 31' 595"	Хялгана- шарилж- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)
Сүхбаатар.	Сумын төвөөс зүүн тийш 29 км-т. Матадаас Сүхбаатар орох замд. 46° 49' 193", 114° 14' 334"	Хялгана- шарилж- алагөвст хээр	Дорнод Монгол (умарт)
Түмэнцогт	Өндөрлөг тэгш тал. 47° 44' 38.5", 112° 23' 25.1", 969 м-т	Алаг өвс-Шарилж-Үетэнт (харганатай) эвшил	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Баянцагаан уулын орчим	Агь-Алаг өвс-Үетэнт (Ботуульт)	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Талын шандын хөндийд	Алаг өвс-том хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47° 41' 35.1", 112° 29'24.3", 929 м-т	Алаг өвс-өрхөг-том хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	46° 45'14.0", 112° 12'53.9", 1140 м-т	Шарилж-үетэн-хазаар өвст	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	46° 45'157", 112° 12'594", 1137 м-т	Хазаар өвс-хялгана-түнгэт	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	46° 45'203", 112° 12'762", 1122 м-т	Алаг өвс-хялгана-хазаар өвст талхлагдсан бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Хоёр гүвээний хоорондох хөндий-46° 44' 28.9", 112° 12'54.2", 1069 м-т	Алаг өвс-таанат	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Тэгш талд Бүрэнцогт орох зам дагуу	Харгана бүхий-түнгэ-улалж хазаар өвст бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)

**Биологийн идэвхит бодис:** Үндсэнд 2.17%, газрын дээд хэсэгт 0.23% кумарин агуулагдана. Үндсэнд алкалоидууд, карденолидууд; газрын дээд хэсэг, үндсэнд лигнаныууд агуулагдана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Энэ ургамлын үндэс нь өмөн хавдрын өсөлтийн эсрэг үйлчилдэг бодис агуулдаг болох нь батлагдсан. Сүүлийн үед манай эрдэмтэн судлаачид гадаадын эрдэмтэдтэй хамтарч газрын дээд хэсэг болон үндсэнд зүрхэнд болон өмөн хавдрын эсрэг үйлчилдэг бодис бүхий алкалоидыг илрүүлсэн нь цаашид тарималжуулж, нутагшуулах ажлыг хийх шаардлагатай харуулж байна. Учир нь энэ ургамал өргөн тархац нутагтай боловч маш сийрэг ургадаг ургац багатай ургамал юм.

## ЦАГААНТҮРҮҮ

Латин нэр: *Leontopodium leontopodioides (Willd.) Beauvd.*

Монгол нэр: **Эгэл Цагаантүрүү**

Адилцаа нэр: Уул өвс, эгэл уул өвс, дэрэн түрүү, цагаан түрүү

Орос нэр: Эдельвейс обыкновенный

Англи нэр: Common Edelweiss

**Ангилалзүйн шинж:** Баг цэцгийг 5-30 сагс нийлж үүсгэдэг. Цэцэг хавийн навчис дээшээ дэрвэгэр, 3-4 нарийнхан, ишний навчнаасаа хэмжээнээс бусад шинжээрээ ялгагдахгүй. Бүх ургамал, торгомсог саарал үсэрхэг, хааяа үнэсэн саарал бөөгнөсөн үстэй. V-VI сард цэцэглэнэ. (115-р зураг).

**Ургах орчин:** Хээржүү хажуу, хуурай хээрт ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл(Эгийн гол), Хэнтий, Хангай, Хянган, Монгол Дагуур, Дорнод Монголын тойрог ургана.



**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Сүхбаатар аймгийн ихэнх сумдын нутагт харьцангуй өргөн тархацтай боловч Түмэнцогт, Эрдэнэцагаан, Дарьганга, Мөнххаан, Сүхбаатар зэрэг сумдын нутагт буюу хээрийн бүсэд өргөн тархан ургана(116-р зураг, 45-р хүснэгт).

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт флавоноидууд, алкалоидууд, сапонинууд агуулагдана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Газрын дээд хэсгийг бөөр, элэг, дэлүү, цус тогтоох, шарх цэвэрлэх зэрэгт хэрэглэдэг байна.

## ЦАХИЛДАГ

Латин нэр: *Iris lactea* Pall..

Монгол нэр: Цагаалин Цахилдаг

Адилцаа нэр: Хосхайрст цахилдаг, цахилдаг, сах


Орос нэр: Ирис (касатик) молочно-белый, пикулька

Англи нэр: Whiteflower Iris

**Ангилалзүйн шинж:** Өтгөн саглагар олон үндэс бүхий, бахим үндэслэг иштэй, том дэгнүүл үүсгэн ургадаг 30-40 см өндөр ургамал. Ишний уг орчмоос

бөөндүү гарсан шугаман буюу сэлмэн хэлбэрийн ногоон навчистай, тэр нь цэцэглэх ишнээс өндөр байдаг. Том сайхан цайвар, цайвар хөх буюу хөх хөхөвтөр нил цэцэгтэй. Цэцгийн шадар эрхтний хоолой нь дэлбэнгээсээ олон дахин богино(117-р зураг).

**Ургах орчин:** Нуур, гол булгийн марцлаг эрэг, хайрга, марцлаг нугад ургах бөгөөд Цахилдагт нуга, гол горхийн шанд, булаг, давстай нуурын ойролцоо хуурай амны давстай ёроолоор ул хөрсний ус ойртой нам дор газраар татмын төв ба гульдралын хэсэг дэнжийн хормой, ёроол дагаж марцлаг дэрстэй хотгордуу газраар томхон талбай эзлэн ургадаг.



117-р зураг. Цагаалин Цахилдаг.

118-р зураг. Цагаалин Цахилдагийн тархац

**Тархац-байршил:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх (баруун хэсэг), Дорнод Монгол (Халх гол), Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий (Богд сум), Дорноговь, Говь-Алтай, Алашааны говийн тойргуудад тохиолдоно.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (118-р зураг, 46-р хүснэгт).

46-р хүснэгт

#### Цагаалин Цахилдагийн тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга.	Сумын төвөөс зүүн урагш 16 км-т. Ганга нуурын дэргэд Оргихын булаг. 45° 16' 000", 113° 59' 507"	Улалж- үетэн-алагөвст нуга.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга.	Сумын төвөөс баруун тийш 14 км-т, Баянголын эх, Салаагийн элс. 45° 15' 442", 113° 44' 560"	Үетэн- алагөвст элс.	Дорнод Монгол (Дарьганга)
Мөнххаан.	Өндөрхаанаас зүүн урагш 73 км-т, Өндөрхаанаас Чойбалсан орох төв замын дэргэд. Заан ширээ уулын орчим.	Үетэн- алагөвст хээр	Дундад Халх (дорнод)
Сүхбаатар.	Талбулагийн уурхайгаас зүүн тийш 67 км-т. 47° 07' 20.9", 113°32' 24.6"	Хялгана-зүр өвс-алагөвст хээр	Дундад Халх (дорнод)

**Гарц-нөөц:** Энэ зүйл цахилдаг Монгол оронд харьцангуй их тархацтай боловч гарц-нөөцийн нарийвчилсан судалгаа хийгдээгүй. Харин энэ онд Баян-

Уул сумын төвөөс баруун тийш Улз голын хөндийд болон Баяндун сумын төвөөс зүүн урагш 18 км-т Дашбалбар явах замын нугархаг хөндийд ойролцоогоор 100 га-д 1.0-1.5 тн түүхий эдийн нөөцтэй болохыг тогтоов.

**Хэрэглээ, ач холбогдол:** Монгол уламжлалт эмнэлэгт ходоод өвдөх, ходоод гэдэсний цанх, гэдэсний аливаа цагаан хорхой, шарын халууныг анагаахаар хэрэглэдэг жорны найрлагад үр нь ордог. Мөн Монгол болон дорно дахины эмнэлэгт үндэслэг иш, үр, цэцгийг уушигны хатгалгаа, уушигны цагаан мөгөөрсөн гуурсны үрэвсэл, ходоодны архаг үрэвсэл, шарлахуй хийгээд элэгний бусад өвчнийг анагаахад хэрэглэнэ.

Латин нэр: *Iris tenuifolia* Pall.

Монгол нэр: **Нарийннавчит Цахилдаг**

Адилцаа нэр: Нарийн цахилдаг, цулбуур өвс, тахь өвс, оонын сахал, манин цахилдага

Орос нэр: Ирис тонколиственный, касатик


Англи нэр: Slenderleaf Iris

**Ангилалзүйн шинж:** Цахилдагийн (Iridaceae Juss.) овогт хамаарах нягт дэгнүүл бүхий 5-7 см өндөр ургадаг, ишгүй олон наст өвслөг ургамал. Үетэн адил шугаман-утсархуу маш урт нарийн, дагуудаа хуйларч-атиралдсан буюу тахиралдсан 40 см хүртэл урт, 1-1.5 мм өргөн навчтай. Цайвар-хөх юмуу нил цэцэг нь нягт дэгнүүлээсээ цухуйх төдий хосоор байрладаг. Хонхорцог нь 2.5-4 см урт, зууван, богино шонтонтой. 5-6 -р сард цэцэглэнэ. (119-р зураг)

**Ургах орчин:** Элсэрхэг хөрс, элс-хайргатай хөрсөнд заримдаг цөл, цөлөрхөг хээр, хуурай хээрийн урд захаар ургана.



119-р зураг. Нарийн навчит Цахилдаг



120-р зураг. Нарийн навчит Цахилдагны тархац, нөөц

● -2 тн-оос их      ● -2-тн-ррс бага

**Монгол дахь тархац:** Монгол Алтай (Хасагт Хайрхан), Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор (Бориг дэл элс, Хүнгүй гол), Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Зүүнгарын говь (хойт хэсэг) тойргуудад ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (120-р зураг, 47-р хүснэгт)

47-р хүснэгт

**Нарийннавчит Цахилдагийн тархац, ургах эвшил**

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Дарьганга	Цагаан нуур, Холбоо нуурын орчмын Холбоогийн элсэнд	Алагөвст элсний ургамал бүхий бүлгэмдэлд	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Баянголын эх, Салаагийн элсэнд	Суль- алагөвст элсний ургамал бүхий бүлгэмдэлд	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Молцогийн элсэнд	Суль- алагөвст бүлгэмдэлд	Дундад Халх (дорнод)
Дарьганга	Алтан-Овоо	Галт уулын хүрмэн чулууны завсрын элсэрхэг хөрсөнд	Дорнод Монгол (умарт)
Наран	Молцог элсэнд	Суль- алагөвст бүлгэмдэлд	Дундад Халх (дорнод)
Баяндэлгэр	Онгон элсэнд	Харгана-элдэвөвст бүлгэмдэлд	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47°41'35.1", 112°29'24.3", 929 м-т	Алаг өвс-ерхөг-том хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Талын шандын хөндийд	Алаг өвс-том хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47°31'19.4", 112°19'58.7", 992 м-т	Алаг өвс-түнгэ-хялганат	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Тэгш тал Бүрэнцогт орох зам дагуу	Харгана бүхий-түнгэ-улалж хазаар өвст бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)
Онгон	Шар бүрдийн зүүн урд дэрстэй хээрт. 45° 39'12,1", 113° 05' 30,9". д.т.д. 1092 м	Алаг өвс-том хялганат	Дундад Халх (дорнод)

**Гарц-нөөц:** Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Холбоогийн элс орчимд элс толгодын хооронд 10500 га талбайд хайлаас бүхий элсний элдэв өвстэй ургамалтай (*Artemisia xantochroa*, *Oxytropis gracillima*, *Vincetoxicum sibiricum*, *Thalictrum squarrosus*, *Psammochloa villosa*, *Allium polorrhizum*, *A. mongolicum*, *Hedysarum fruticosum*, *Amygdalus pedunculata*, *Padus asiatica*, *Ulmus pumila*) эвшилд sol арвитай ургана.

- 5x5 м<sup>2</sup>-д 0.25 ш ургамал, 23.7 гр (агаарын хуурайгаар) үүнээс га-д 2 кг; нийт талбайд биологийн нөөц 21 тн-оос үйлдвэрлэлийн нөөц нь 2.7 тн болно.

Дарьганга, Наран, Онгон сумдыг дамнан үргэлжлэх Молцог элсэнд 14000 га талбайд элдэв өвстэй элсний ургамалтай (*Artemisia xantochroa*, *Oxytropis gracillima*, *Vincetoxicum sibiricum*, *Thalictrum squarrosus*, *Allium polorrhizum*, *A. mongolicum*, *Hedysarum fruticosum*, *Haplophyllum dauricum*, *Amygdalus pedunculata*) эвшилд sol арвитай ургана.



- 5x5 м<sup>2</sup>-д 0.5 ш ургамал, 8.3 гр (агаарын хуурайгаар) үүнээс га-д 1.6 кг; нийт талбайд биологийн нөөц 22.4 тн-оос үйлдвэрлэлийн нөөц нь 2.8 тн. болно.

Онгон, Баяндэлгэр сумдыг дамнан орших Онгон элсэнд 29400 га талбайд үетэн үетэн-элдэвөвстэй элсний ургамалтай (*Artemisia xanthochroa*, *Thalictrum squarrosum*, *Psammochloa villosa*, *Agriophyllum pungens*, *Amygdalus pedunculata*, *Salix microstachya*) эвшилд sol арвитай ургадаг болохыг тогтоов. Энд Нарийннавчит Цахилдаг харьцангуй бага нөөцтэй болно.

- 5x5 м<sup>2</sup>-д 0.07 ш ургамал, 14.6 гр (агаарын хуурайгаар) үүнээс га-д 0.4 кг; нийт талбайд биологийн нөөц 12 тн-оос үйлдвэрлэлийн нөөц нь 1.5 тн. болно.

**Биологийн идэвхит бодис:** Үндсэнд 6 флавонон байгааг илрүүлсэн. Үүнд: 5.2.3 – тригидрокси - 6.7 - метиленедиоксифлавоны, 5.2 – дигидрокси - 6.7 - метиленедиоксифлавоны, 5.2.3 – тригидрокси – 7 - метоксифлавоны, 5.3 – дигидрокси - 7.2 - диметоксифлавоны, 3.5.2.3' – тетрагидрокси – 7 - метоксифлавоны, 3.5.3 – тригидрокси - 7.2 - диметоксифлавоны зэргийг агуулдгийг монгол, японы эрдэмтэд илрүүлжээ. Үрэнд линолын хүчил (63.9%) зонхилсон, олеины хүчил нилээд оролцсон 16:0 хүчил бүхий 16 өөхөн хүчлээс тогтсон 9.5% өөхөн тостой.

**Хэрэглээ үйлчилгээ:** Энэ ургамлын бэлдмэл өөхний хэт исэлдэлтийн процесс, өөртөө харших урвалыг дарангуйлж бөөрийг хамгаалах үйлдэл үзүүлдэгийг эрдэмтэн Б.Саранцэцэг тогтоожээ. Монгол эмнэлэгт хорхойн өвчнийг туулгах, шарх анагаах, бөөр давсагны өвчнийг анагаах, савны хавдарт тустай. Гэдэсний цагаан хорхой, түлэнхийг анагаана. “Моносфарм” ХХК Нефроном(MNS 5099:2001) хэмээх шингэн эм үйлдвэрлэж зах зээлд нийлүүлж байна.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Үндэсийг бэлтгэхдээ цэцгийг хатаж унасны дараа намар 8-р сарын дундаас хойш ухаж аваад угааж цэвэрлээд сүүдэр газар хатааж хэрэглэнэ.

## ЦУЛЬХАР

Латин нэр: *Agriophyllum pungens (Vahl.) Link. ex A.Dietr*


Монгол нэр: **Шивүүрт Цульхир**

Адилцаа нэр: Хатгуурт цульхир, дэрвээн цульхир, элсний цульхир, цульхар, цулихир, сульхар, сульхир

Орос нэр: Кумарчик колючий

Англи нэр: Thorny Agriophyllum, Squarrose Agriophyllum

**Ангилалзүйн шинж:** Угнаасаа оройдоо хүртэл салаалсан 30-40 см өндөр иштэй нэг наст өвслөг ургамал. Навчис юлдэрхүү, 3 юмуу хэд хэдэн тод ялгарах тууш судалтай, цайвар ногоон өнгөтэй, хурц өргөслөг үзүүртэй. Баг цэцэг навчны өвөрт орших бөгөөд толгойрхог, цэцгийн дагавар нь шөвгөрхүү-өргөслөг. Жимс дугариг юмуу тонгоруу-өндгөрхүү, хавтгай-гүдгэр талуудтай үзүүртээ сэртгэр 2 шонтонтой тэдгээр нь гадагш нурамтгай үзүүртээ шүдлэгтэй.(121-р зураг).



**Ургах орчин:** Цөлийн хээр, цөлийн бүсэд хамаарах муухан ширэгжсэн болон нүүдэг элсэн манхан, элсэн довцог, элсэн сондог, хуурай элсэн харгиа, сайрын элсэрхэг ёроолоор ургана.

**Монгол дахь тархац:** Ховд, Дундад Халх (Борогчин), Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Говь-Алтай, Дорноговь, Алтайн өвөр говь, Алашаагийн говь, Зүүнгарын говийн тойргуудад ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Онгон, Баяндэлгэр сумдыг дамнан орших Онгон элсэнд харгана-элдэвөвст бүлгэмдэлд ургадаг болохыг тогтоов. (122-р зураг)

**Биологийн идэвхит бодис:** Үрэнд уураг (протеин) 21.25%, сахар 55%, тослог 5.6-8.6%, эслэг 3.4% тус тус агуулагдана. Мөн 20 амин хүчил агуулдгийн дотор лизин, метионин, треонин зэрэг амин хүчлүүд бий.

**Хэрэглээ үйлчилгээ:** Цульхирын гурилаар боов боорцог хийхэд амтлагчаар хэрэглэх ба хийтэй цай хийж хэрэглэдэг. Ардын эмнэлэгт хижигийг анагаах халууныг арилгах, хорыг тайлах, шээлгэх чадалтай.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Цульхирын моджоогүй бүхэл өвсийг түүж иш ба шарласан навчийг түүж хаяад бусад холимогоос сайтар цэвэрлэн ялгаж сүүдэр газар хатаана.

## ЧИХЭРӨВС

Латин нэр: *Glycyrrhiza uralensis* Fisch.

Монгол нэр: **Урал Чихэрөвс**

Адилцаа нэр: Чихэрөвс

Орос нэр: Солодка уралская

Англи нэр: Ural Licorice

**Ангилалзүйн шинж:** Эгц босоо, мөчирлөг бус 40-100 см өндөр иштэй, олон наст өвслөг ургамал. Иш, навчны гол хялгасархаг ширүүн. Навчис 4-6 (8) хос, өндгөрхүү зуувгар, шөвгөрдүү, цавуулаг булчирхай бүхий навчинцартай. Цэцэглэх иш навчнаасаа богино өтгөн цацаг үүсгэнэ. Буурцаг том, хавчгар, зуувгар, ихэд тахир, хөндлөөшөө мушгирч тахийсан бөгөөд гадаргуу нь булчирхайлаг, үсэрхэг, өргөслөг. Үр бөөр хэлбэртэй. Үндэс, үндэслэг ишний тогтолцоо маш сайн хөгжсөн(123-р зураг).

**Ургах орчин:** Хээр тал, чийглэг марцлаг нуга, марц хужиртай элс, элсэрхэг хээр, сондог, хээрийн гол горхины хөндийд ургана.



123-р зураг. Урал Чихэрөвс

124-р зураг. Урал Чихэрөвсний тархац

**Монгол дахь тархац:** Хангай, Монгол Дагуур, Хяangan, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Зүүнгарын говь, Алашаа говийн тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Сүхбаатар аймгийн ихэнх сумдын нутагт харьцангуй сийрэг тархацтай боловч Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Баяндэлгэр зэрэг говийн хэсэг буюу цөлөрхөг хээрт өргөн тархан ургана. (124-р зураг, 48-р хүснэгт)

## Чихэр өвсний тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Асгат.	Асгат сумаас Эрдэнэ цагаан сум орох замын 40 км-т.	Хялгана- алагөвст хээр	Дорнод Монгол
Эрдэнэцагаан.	5-р заставаас 6-р застав орох замын 7 км-т.	Хялгана- алагөвст хээр	Дорнод Монгол
Эрдэнэцагаан.	Баян-Өлзий толгой.	Хялгана- алагөвст хээр	Дорнод Монгол
Эрдэнэцагаан.	Сумын төвөөс урагш 63 км-т, Баруун Могнон уулын орчим.	Хялгана- алагөвст хээр	Дорнод Монгол
Эрдэнэцагаан.	Лаг нуураас баруун урагш, 12 км-т. Улаан хонхорын хөндий. 46° 31' 44", 116° 08' 37"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан.	Лаг нуураас баруун урагш, 27 км-т. Хашаат хоолой.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан.	Лаг нуураас баруун урагш, 35 км-т.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан.	Эрдэнэцагаанаас зүүн хойш 39 км-т, Лаг нуур орох замд.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан.	Эрдэнэцагаанаас баруун тийш 18 км-т, Зотол хаан уул орох замд.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан.	Эрдэнэцагаанаас баруун тийш 52 км-т, Зотол хаан уулын зүүн талд.	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Эрдэнэцагаан.	Зотол хаан уул. 45° 48' 396", 114° 43' 231"	Таана- үетэнт уулын нуга.	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр.	Сумын төвөөс зүүн урагш 50 км-т, Онгон элсний баруун хойт үзүүрт. 45° 35' 596", 112° 49' 039"	Харгана- үетэн- алагөвст цөлөрхөг хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Баяндэлгэр.	Сумын төвөөс баруун урагш 33 км-т, Сайншанд явах төв замын дагуу. 45° 38' 579", 111° 58' 044"	Харгана- үетэн- алагөвст цөлөрхөг хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	Тээг уулын хойд уулын бэл	Алаг өвс-үетэнт хээр	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47°31'19.4", 112°19'587", 992 м-т	Алаг өвс-түнгэ-хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Сумын төвийн хойд тэгш хөндий	Алаг өвс-хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Талын шандын хөндийд	Алаг өвс-том хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47°42'30,0", 112°17'37,7", 987 м-т	Алаг өвс-үетэнт эвшил	Дундад Халх (дорнод)

**Гарц-нөөц:** Лаг нуур 20 x 10 км<sup>2</sup> талбайд ургана.

**Биологийн идэвхит бодис:** Үндсэнд триперпений сапонин-глицирризин (калийн ба кальцийн давстай глицирризины хүчилүүд 23%), глюкоз 1.02%, 5.5%, сахароз 5.5% олдсон. Чихэр-өвсний үндсэнд хэдэн арван флавоноидот нэгдлүүд 4.3% хүртэл агуулагдана. Үндсэнд сахар, стероид, кумарин, эфирийн тос, аспарагин, аскорбины хүчил агуулагдана. Урал чихэр-өвсөнд уралены хүчил бий. Газрын дээрх хэсэгт витексин, сапонаретин зэргээс тогтсон флавноид 3.3% хүртэл буй.

**Хэрэглээ үйлчилгээ:** Урал чихэр өвсний үндсээр бэлтгэсэн эм нь амтлаг амттай, сэрүүн шингэн, эелдэг, хөнгөн зөөлөн чанартай, ханиахыг зогсоох, шимжүүлэх, ундаасахыг зогсоох, халууныг арилгах хорыг тайлах чадалтай. Уушгинд халуун бүрхэж шар цэрээр ханиалгах, цээж тэлэх, амьсгал давхцах, уушигны халуун хатгалгааг анагаахад тустай.

## **ШАРИЛЖ**

Латин нэр: *Artemisia frigida Willd.*

Монгол нэр: **Өлчир Шарилж**

Адилцаа нэр: Агь

Орос нэр: Полынь холодная

Англи нэр: Fringed Sagebrush

**Ангилалзүйн шинж:** Сагс 2-4(5) мм урт бөгөөд 1-5 мм урт унждаг шилбэн дээр байрладаг. Бүх навчис-цуулбар, бариулын угт гурав, дөрвөн хос сайн хөгжсөн чихэнцэртэй, дээд хэсгийн навчис гурвалсан юмуу өдлөг цуулбар. Олон наст найлзуур 10-40 см өндөр, нилээд нягт дэгнүүл үүсгэдэг сааралдуу торгомсог юмуу цагаавтар торгомсог үсэрхэгтэй, цайвар ногоон өнгөтэй олон наст өвслөг, сөөгөнцөр ургамал.

Үрэнцэр тонгоруу өндгөрхүү, өөхий тал руугаа хотгор, яльгүй матигар, дугуй оройтой, сууриадаа шовгор. (125-р зураг)

**Ургах орчин:** Уулын хээр, хээр, цөлөрхөг хээрт уул, толгодын хайргархаг, чулуурхаг хажуу, хад чулуу, голын хайрга, сайр дагуу, хааяа хужирлаг дэрстэй хотгорт ургана. Апофит, тариалан ба бэлчээрийн хөл газрын үндсэн ургамал.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтайн тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Сүхбаатар аймгийн бүх сумдын нутгаар хээр, цөлөрхөг хээрт өргөн тархсан ургамал юм(126-р зураг).

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт флавоноид, кумарин, 20 гаруй бодисоос бүрдсэн эфирийн тос 0.24-0.57%, сахар, органик хүчил, идээлгийн бодис, стерин, алкалоид, С аминдэм, каротин зэрэг бодис агуулагддаг болохыг тогтоожээ.



125-р зураг. Өлчир Шарилж



126-р зураг. Өлчир Шарилжны тархац

**Хэрэглээ үйлчилгээ:** Ардын эмнэлэгт энэ ургамлаар хийсэн эм гашуун амттай, хуурай нөмцөггүй, ширүүн мохдог, сэрүүн чанартай, цус тогтоох, цусан халууныг арилгах, хадар хариулах, чиххааг номхотгох, уушигний болон элэгний халууныг арилгах чадалтай. Цусаар бөөлжих, шарх хийгээд хамраас цус гарах, сарын тэмдэг элбэгших, дотор цус алдах зэрэгт сибирь тошлог, баавгайн цөстэй хавсарч хэрэглэнэ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Намар цэцэглэж байх үед нь газар дээрх хэсгийг хадаж аваад хатааж өгөршсөн хэсэг болон холимогоос цэвэрлэж сүүдэр газар хатаана.

Латин нэр: *Artemisia macrocephala* Jacquem.

Монгол нэр: **Ээрэм Шарилж**

Адилцаа нэр: Царвант шарилж, Царван

Орос нэр: Полынь крупнокорзиночная


Англи нэр: Largehead Wormwood

**Ангилалзүйн шинж:** Иш 6-20 (50) см өндөр, Навчис өргөн зуувгар юмуу сунгуу-зуувгар, 1.5-4 см урт, 1-2 см өргөн, бариулын угт дэлбэн чихэвчгүй, анхдагч сегмент гурвалсан, үзүүрийн салбанцар хүрээрхүү юмуу гонзгойвтор, 1-4 мм урт, 0.5 мм өргөн, мөлгөр. Сагс 5-10 мм өргөн, сийрэг сагс үүсгэдэг, нэг ба хоёр наст ургамал (127-р зураг).

**Ургах орчин:** Уулын хээржүү хайргархаг хажуу, бэл, марц, хужиртай, хотгор, хужирлаг ба эргийн нуга, хайрга, элс, сайр, элсэрхэг хээр, дэрстэй хотгор, тарианы талбай, зам харгуй, буурь, бууц, суурин газар ургана. Апофит, тариалан ба бэлчээрийн хөл газрын үндсэн ургамал.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон

нуурын хөндий, Говь-Алтай, Алтайн өвөр говь, Алашаа говийн тойрогт тохиолдоно



127-р зураг.Царван

128-р зураг.Царвангийн тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (128-р зураг, 49-р хүснэгт)

49-р хүснэгт

### Царвангийн тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Түмэнцогт	Усны хуримтлал ихтэй хоёр гүвээний хоорондахь хөндий жалга	Алаг өвс-түнгэт бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	46°44'545", 112°12'552", 1071 м-т	Үетэн-таанат	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	46°45'203", 112°12'762", 1122 м-т	Алаг өвс-хялгана-хазаар өвст талхлагдсан бүлгэмдэл	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	46°52'266", 112°07'109", 1279 м-т	Amygdalus бүхий чулуусаг алаг өвс-сонгино-крыловийн хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	47°18'283", 112°12'065", 1110 м-т	Алаг өвс-хазаар өвс-хялганат	Дундад Халх (дорнод)
Түмэнцогт	Түмэнцогтын ууланд	Баялаг алаг өвс-үетэнт	Дундад Халх (дорнод)

**Биологийн идэвхит бодис:** Хэд хэдэн газраас цэцэглэлтийн ба үрлэлтийн эхэнд цуглуулсан дээжид (газрын дээд хэсэгт) хар хөх, хар ногоон, хүрэн өнгийн эфирийн тос 0.1-0.4% болон флавоноид агуулагдаж байна. Өмнөд Хангай(Хүрээмарал сум)-д линалоол, гераниол, 1.8-цинеол, кариофиллен, β-пинен, лимонен, h-цимол, селинен бүхий эфирийн тос 0.4%, Зүүнгарын говь (Үенч голын орчим)-оос түүсэн дээжид эфирийн тос харьцангуй их байлаа.

Оросод хийсэн судалгаагаар газрын дээд хэсэгт эфирийн тос 1.8-цинеол(22% хүртэл) ба камфора(31% хүртэл) бий. Мөн α-пинен, камфен, β-

пинен,  $\Delta$ -карен, лимонен, п-цимол,  $\alpha$ -туйон, борнеол. Тосонд азулена (13.8% хүртэл) их агуулагдана.

**Хэрэглээ үйлчилгээ:** Навч баг цэцгийн идээшмэлийг монгол уламжлалт эмнэлэгт уушгины үрэвсэл, мөгөөрсөн гуурстас, томуунд дотуур, мөн ангина, хамар болон амны хөндийн салст бүрхүүлийн үрэвсэл, буйлны үрэвслийн үед үрэвсэл намдаахад зайллаг болгон хэрэглэнэ.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Навч баг цэцгийн идээшмэлийг монгол уламжлалт эмнэлэгт уушгины үрэвсэл, мөгөөрсөн гуурстас, томуунд дотуур, мөн ангина, хамар болон амны хөндийн салст бүрхүүлийн үрэвсэл, буйлны үрэвслийн үед үрэвсэл намдаахад зайллаг болгон хэрэглэнэ.

## ШИМЭЛДЭГ

Латин нэр: *Dracoscephalum foetidum Bunge.*

Монгол нэр: **Үмхий Шимэлдэг**

Адилцаа нэр: Шимэлдэг

Орос нэр: Змееголовник вонючий

Англи нэр: Fetid Dragonhead

**Ангилалзүйн шинж:** Уруул цэцэгтний овог-Labiatae Juss. (Lamiaceae Lindl.)-ийн эвгүй үнэртэй, 5-15 см өндөр иштэй, нэг наст ургамал. Навч доод гадаргуудаа суумал армаг тармаг булчирхайтай. 7-р сард цэцэглэж, 8-р сард үрлэнэ. (129-р зураг)


**Ургах орчин:** Ойт хээр, хээр, говийн бүсэд голын эрэг, хайрга, ам хавцал, сайр садрага, байц хадны ёроол, нуранга, элсэрхэг хээр, чулуурхаг ба хайргат хажууд ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хангай, Хэнтий, Монгол Дагуур, Ховд, Монгол Алтай, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Олон нуурын хөндий, Дорноговь, Говь-Алтай, Алашаа говийн тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Эрдэнэцагаан сумын Чоноголын хөндийд, Зотол хан уул, Дарьганга сумын Шилийн Богд ууланд ургана. (130-р зураг)

**Биологийн идэвхит бодис:** Цэцэглэлтийн үед цуглуулсан газрыг дээд хэсэгт цайвар шар болон хөхөвтөр цэнхэр ногоон өнгөтэй, эвгүй үнэртэй, эфирийн тос (0.09-0.77%) ба флавоноидууд агуулагдана. Орхон голын зүүн эргээс (Булган ба Сэлэнгэ аймаг) цуглуулсан дээжинд 0.74% эфирийн тос агуулагддагийг судалж тогтоосон.





129-р зураг. Үмхий Шимэлдэг

130-р зураг. Үмхий Шимэлдэгийн тархац

**Хэрэглээ үйлчилгээ:** Монгол ардын эмнэлэгт газрын дээд хэсгийг амны хөндийн салстын үрэвсэл, уруул, хэлний шархыг зайлах, угаах зэргээр хэрэглэхийн зэргээ цэцэг нь олон төрлийн эмийн найрлагад (С аминдэмийн дутагдал, үений үрэвсэл, халуун бууруулах) орно. Цэцэг навчийг ходоод гэдэсний хямрал(бөөлжих, гүйлгэх), шарх цэвэрлэхэд хэрэглэнэ.

### ШЭЭРЭНГЭ

Латин нэр: ***Silene repens Patr.***

Монгол нэр: **Мөлхөө Шээрэнгэ**

Адилцаа нэр: Шээрэнгэ, Согоон чих


Орос нэр: Смолёвка ползучая

Англи нэр: Creeping Silene

**Ангилалзүйн шинж:** Баширын (Caryophyllaceae Juss.) овгийн өвслөг ургамал. Цоморлиг үсэрхэг, дэлбийн хэлтэс дайвар дэлбэнцэртэй, үндэслэг иштэй, дэгнүүл үүсгэдэггүй. Ишний навчис өвөртөө богиносон найлзууртай. 6-7-р сард цэцэглэж үрлэнэ.(131-р зураг)

**Ургах орчин:** Сийрэг ой, түүний зах, нугат хээр, хээржүү хажуу, голын эрэг, сөөгөн ширэнгэнд ургана.

**Монгол дахь тархац:** Хөвсгөл, Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Монгол Алтай, Дундад Халх (хойт хэсэг), Дорнод Монгол (хойт хэсэг), Говь-Алтайн (Гурван Богд, Гурван сайхан) тойрогт ургана.



131-р зураг. Мөлхөө Шээрэнгэ

132-р зураг. Мөлхөө Шээрэнгийн тархац

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** (132-р зураг, 50-р хүснэгт)

50-р хүснэгт

### Мөлхөө Шээрэнгийн тархац, ургах эвшил

Сум	Газрын нэр	Ургах эвшил	Ургамал-газарзүйн тойрог
Эрдэнэцагаан	Зотол хан уул	Таана- үетэнт уулын нуга.	Дорнод Монгол (Дарьганга)
Дарьганга	Шилийн Богд уул. 45° 28' 307" 114° 34'506"	Үетэн- алагөвст хээр.	Дорнод Монгол (Дарьганга)
Түмэнцогт	Түмэнцогтын уулын орчимд	Баялаг алаг өвст бүлгэмдэлд	Дундад Халх (дорнод)
Мөнххаан	Баян ууланд	Сөөг бүхий алаг өвс-ерхөг-хялганат	Дундад Халх (дорнод)

**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт сапонаретин, витексин түүний изомерууд, түүнчлэн О-моно- ба О-дигликозидууд бүхий флавоноидууд агуулна. Бүх эрхтэндээ тритерпенийн сапонинууд, алкалоидууд; ишэнд эдээлгийн бодис болон кумаринууд; навч, цэцгэнд С витамин; цэцгэнд карденолидууд; жимсэнд сапонинууд бий.

**Хэрэглээ үйлчилгээ:** Монгол ардын эмнэлэгт цэцгийн хандыг нүд улайж өвдөх, нулимасны хүүдийн үрэвсэл, хамраас нус гоожих, дунд чихний идээт үрэвсэлийг эмчлэхэд хэрэглэнэ. Түвд эмнэлэгт чих дүлийрэхэд хэрэглэдэг байна.

### ОЛС

Латин нэр: ***Cannabis ruderalis Janisch.***

Монгол нэр: **Хогийн Олс**

Адилцаа нэр: Зэрлэг олс

Орос нэр: Конопля сорная


Англи нэр: Ruderal Hemp

**Ангилалзүйн шинж:** Цөөн салаалсан 40-80(120) см өндөр иштэй, налчгар үсэрхэг, нэг наст ургамал. Навчис урт бариултай, 5-7 салбантай, тэдгээр тус бүр шүдэрхэг, гонзгой юлдэрхүү, үзүүрээдээ шөвгөр. Эр цэцгүүд залаанд, эм цэцэг мөчирлөг түрүүнд нэгдэнэ. Жимс угтаа үетэй тул хялбар унамтгай, хатуу, түүний гадна талд шадар эрхтний харласан үлдэгдэл оршино. 5-7-р сард цэцэглэнэ. (133-р зураг)

**Ургах орчин:** Хуурай хажуу, ам хавцал, гол горхины эрэг, сайр, орон байр, нутаг бууц, тариалангийн талбайд ургана. Эдэлбэрт орсон газар зонхилогчоор, шарилж, луультай эвшил үүсгэж ургана.

**Монгол дахь тархац:** Хэнтий, Хангай, Монгол Дагуур, Хянган, Ховд, Дундад Халх, Дорнод Монгол, Их нууруудын хотгор, Дорноговийн тойрогт ургана.

**Сүхбаатар аймагт тархсан байдал:** Эрдэнэцагаан, Дарьганга, Халзан, Баяндэлгэр сумдын нутагт ургадаг байна. (134-р зураг)



**Биологийн идэвхит бодис:** Газрын дээд хэсэгт алкалоид, стероиднын сапонин, тос (30-35%), уургийн бодис(15-20%), аминдэм К, каннабин, никотин зэрэг агуулагдана. Үрэнд 38.2% тостой, аминдэм К; газар дээрхи хэсэг каннабин, түүний уламжлалт бодис, каннабиндиолын хүчил, каннабиндиол, каннабиол, 5-усмаг каннабинол; цэцэг канноби диварин, каннабинойд тэдгээрийн хүчил агуулдаг.

**Хэрэглээ үйлчилгээ:** Тулай, хэрх зэрэг шар өвчин, арьсны өвчин, булчирхайн өвчин, цагаан судлын өвчинд хэрэглэх бөгөөд ядарсан үед сэргээш болгох маягаар хэрэглэнэ. Мөн эм (шар усны, арьсны, булчирхайн өвчин, булингартсан халуун, цагаан судлын өвчин, мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй), хүнс (тос), техникт (татлага, уяа, оосор, олс, даруулга зэрэгт) өргөн хэрэглэдэг.

**Зохистой ашиглах, хамгаалах арга:** Хогийн Олс ихээхэн газар нутгийг хамарч “Нарколандшафт”, “Наркоэкоцистем” зэрэг ландшафтад хамаарах ургамлан нөмрөгийг үүсгэх эхлэл болж байна. Өөрөөр хэлбэл энэ ургамлын өргөн тархалт нь түүний биологийн онцлог (ургал болон үржил эрхтний ургах чадавх, жил бүр маш олон тоотой үр боловсордог, тэдгээр нь олон жил амьдрах чадвараа хадгалдаг зэрэг), экологийн агууриг уян хатан байдал, талхагдалд тэсвэртэй, өрсөлдөх чадвар өндөр зэрэгтэй холбоотой бөгөөд сүүлийн жилүүдэд өтгөн, өндөр өвсөн бүрхэвч үүсгэх болсон нь ажиглагдаж байгаа.

Уг ургамлыг эм (шар усны, арьсны, булчирхайн өвчин, булингартсан халуун, цагаан судлын өвчин, мансууруулах, тайвшруулах үйлчилгээтэй), хүнс (тос), техникт (татлага, уяа, оосор, олс, даруулга зэрэгт) өргөн хэрэглэдэг. Тусгай хяналтын дор зохистой ашиглах, устгах арга технологи боловсруулах шаардлагатай ургамал.

## ДҮГНЭЛТ

Монголчууд бэлчээрийн мал аж ахуй эрхэлж ирсэн уламжлал, малын тоо толгойн өсөлт, улмаар газар тариалан эрчимтэй хөгжиж байгаа зэргээс улбаалан байгалийн ургамлын ашиглалт үлэмж ихсэв. Өнөө үед уламжлалт анагаах ухаанд эмийн ургамлын ашиглалт ихээр нэмэгдэхийн зэрэгцээ гадаад улс орнууд монголын экологийн цэвэр орчинд ургасан эмийн ургамлын түүхий эдийг ихээр авах сонирхолтой болсноос шалтгаалан ургамлыг үндэсээр нь ухаж устгах, иш навч мөчирийг их хэмжээгээр түүж бэлтгэх, худалдаалах, цэцэг үр жимсийг хэт их ашигласнаар тухайн зүйл ургамлын тархалт, нөөц хомсдож, зарим зүйлийн хувьд бүрмөсөн устгах аюул нүүрлээд байна.

Сүхбаатар аймагт .... овогт хамаарах ... төрлийн ... зүйлийн ургамал бүртгэгдсэнээс .... овгийн ... төрлийн ... зүйл ургамлын тархац, ... зүйл ургамлын нөөцийн судлагаа явууллаа.

Одоо ашиглалтанд өртөмтгий ургамлуудын тархалт, нөөцийн судалгааг Сүхбаатар аймагт хийж байгаа явдал бол байгалийн баялаг болох ургамлын аймгийн тогтвортой ашиглалт, бодлого боловсруулах түвшинд мэдээлэлийн сан бүрдүүлэхэд үр дүнгээ өгөх сайн зүйл болж байна. Энэ судалгааг цаашид аймгийн сум бүрээр гаргах боломжийг бүрдүүлэх нь чухал юм. Ингэж ажиллах боломж бүрэн бий. Сум бүрт Байгаль орчны улсын байцаагч, Байгаль

хамгаалагч гэсэн ажлын байранд ажиллаж байгаа хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлэх, давтан сургах, мэргэжсэн ажилтан болгоход анхаарах шаардлагатай.

Цаашид БОНХЯ, Сүхбаатар аймгийн БОГ-ын бодлогын түвшинд дараах зүйлийг санал болгож байна. Үүнд:

- Сүхбаатар аймагт ургаж буй нэн ховор, ховор ургамал нь байгаль экологийн хүчин зүйлээс хамаарч ховордож буй ургамал (Кузнецовын Хорс, .... г.м.), хүн амьтан нөлөөллөөс ховордож буй ургамал (дэрэвгэр Жиргэрүү, урал Чихэрэвс, г.м.) буй бөгөөд энэ бүс нутагт нэн ховор ... зүйл, ховор ... зүйл ургамал тохиолдоно.
- Ашигт (дотоодод хэрэглэгдэж байгаа эмийн болон экспортоор гаргаж байгаа) ургамлын нөөц ашигласны төлбөр, зөвшөөрөлгүй түүж бэлтгэсэн тохиолдолд экологи-эдийн засгийн үнэлгээний төлбөрийг яаралтай мөрдөж хэрэгжүүлэх.
- Хилээр гарч байгаа ургамлын түүхий эдэд ноогдуулах татварын хураамж, олгох лицензийг хэмжээг мэргэжлийн байгууллагын тогтоосон нөөцийн үнэлгээнд тулгуурлан авч үздэг байх.
- Нэн ховор болон ховор ургамлын генофондыг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг даруй эхлүүлэх (ойт хээр, хээрийн бүсэд плантаци байгуулж нөхөн сэргээх, тарималжуулах, генофондын сан байгуулах).
- Сүхбаатар аймгийн өвөрмөц ургамалжилт бүхий Хар Ямаат болон Лхачинвандадын байгалийн нөөц газарт “байгалийн цэцэгт ургамлын хүрээлэн” байгуулж тэнд байгалийн аясаар болон зориудаар зарим ургамлыг шилжүүлэн байршуулах, тарималжуулах, нутагшуулах улмаар нөхөн сэргээх (энд тус аймгийн Шилийн Богд ууланд Шинэс, Нарс, Гацуур болоод хус мод тарьж буй жишээ байдаг).
- Мэргэжлийн Хяналтын газартай хамтарч ургамлын түүхий эд ашиглан үйлдвэрлэл явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд онцгой хяналт тогтоох, байгалийн ургамал ашиглах газар районыг тусгайлан зааж өөрсдийнх нь оролцоотойгоор хамгаалуулах, нөхөн сэргээх ажлыг даруй эхлүүлэх.
- Монгол орны зарим зүйлийн ургамлын түүхий эдээс гадаадын улс орон эмийн онцгой бүтээгдэхүүн үйлдвэрлэн дэлхийн зах зээлд нийлүүлж байна (Япон улс чихэр өвсийг манайхаас экспортлож хорт хавдрын эсрэг үйлчилгээтэй эм гаргаж авсан, Солонгос улс чага, туруу мөөгнөөс бас хорт

хавдрын эсрэг үйлчилгээтэй цай гаргаж аваад худалдаалж байна. Хятад улс дэрэвгэр жиргэрүү, яргуй, газрын үс өвснөөс эмийн бодис ялган авчээ). Эдгээр ургамлын түүхий эдэд онцгой татвар ноогдуулах асуудлыг судлаж үзэх.

- Яамнаас жил бүр гардаг тайланд байгалийн ургамлын ашиглалтын талаар аймаг, сум бүрээс мэдээ авч тусгадаг болох, яагаад гэвэл төвд мэдээ байхгүй мөртлөө сум, багаар явахад ургамал түүж ашигласан өдий төдий баримт байгаа нь илрэв.
- Сүхбаатар аймагт явуулсан судалгаагаар мансууруулах, донтуулах төрлийн ургамлын жагсаалтанд орсон Олсны төрлийн Хогийн олс хэмээх ургамал хэд хэдэн цэгт нилээд аривтай ургаж байгааг тус аймгийн Хууль, Цагдаагийн байгууллагууд анхаарч устгах арга хэмжээ авах нь зүйтэй.

Дулааны улиралд унах тунадасны хэмжээ, температур болон бусад хүчин зүйл, хүний үйл ажиллагааны хам нөлөөгөөр вегетацийн үе ургамлын зүйл тус бүр дээр харилцан адилгүй байлаа. Бидний хээрийн судалгааны хугацаа ургамлын вегетацийн нэлээд хожуу үед хийгдсэн тул хээрийн нөхцөлд хийсэн бичиглэлийг эхний байдлаар товч боловсруулж, ашигт ургамалтай холбоотой мэдээллийг орууллаа.

Тархац нөөц багатай ашиглалтанд өртөмхий ашигт ургамлыг улсын болон орон нутгийн хамгаалалтанд авах, нэн ховор болон ховор ургамлыг үр болон тарималжуулах байдлаар үржүүлэн, хамгаалах, нөхөн сэргээх шаардлагатай байна.

Энэ ажил төгс хийгдсэн гэж үзэж болохгүй бөгөөд цаашид нарийвчилсан хайгуул судалгааг урт хугацаатай аймгийн бүх нутгийг хамарч явуулах шаардлагатай хэмээн үзэж байна.

## **АШИГЛАСАН БҮТЭЭЛ**

1. Байгаль орчны тухай Монгол улсын хуулиуд. УБ. 1999. 107-116.
2. Д.Банзрагч, Чой.Лувсанжав. Улсын нэр томъёоны комиссын мэдээ. № 59-60. УБ. 1965. 107.
3. БНМАУ-ын Ус цаг уурын атлас
4. В.И.Грубов. Конспект флоры Монгольской Народной Республики. М.; Л., 1955. 127.
5. В.И.Грубов. Определитель сосудистых растений Монголии. "Наука" Л. 1982. 93.
6. А.Губанов. Конспект флоры Внешней Монголии (Сосудистые растения). М. 1996.
7. Дикорастущие полезные растения флоры Монгольской Народной Республики. // Биологические ресурсы и природные условия Монгольской Народной Республики. Том XXIII. Изд. "Наука". Л. 1985. 235.
8. У.Лигаа. Монголын уламжлалт эмнэлэгт эмийн ургамлыг хэрэглэх арга ба жор. Тэргүүн дэвтэр. УБ. 1996. 461.
9. У.Лигаа. Монголын уламжлалт эмнэлэгт эмийн ургамлыг хэрэглэх арга ба жор. Дэд дэвтэр. "АРЦОТ" УБ. 1997. 395.

10. 14. Н.Өлзийхутаг. БНМАУ-ын бэлчээр хадлан дахь тэжээлийн ургамал таних бичиг. УБ. 1985. 555.
11. 15. Н.Өлзийхутаг. БНМАУ-ын гуурст ургамлын латин-монгол-орос нэрийн толь. УНТК-ын мэдээ, № 129-133. УБ. 1990.
12. 16. Н.Өлзийхутаг. Монгол орны ургамлын аймгийн тойм. УБ. 1989.
13. 17. Ш.Цэгмид. БНМАУ-ын физик газарзүй. УБ. 1969. 67-133.

**“СҮХБААТАР АЙМГИЙН АШИГТ УРГАМЛЫН ТАРХАЦ-НӨӨЦ”**  
**(Сүхбаатар аймгийн засаг даргын тамгын газрын Байгаль орчны хэлтсийн**  
**захиалгаар гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлын тайлан)**

## гэрээт ажлыг гүйцэтгэсэн тухай товч танилцуулга

### Нэг. Үндэслэл

“Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т “... **Байгалийн нөөцийг тогтвортой, зохистой ашиглаж, нөхөн сэргээж, хүрээлэн буй орчныг хамгаалах...**” гэж заасныг хэрэгжүүлэхийн тулд Сүхбаатар аймгийн Байгаль Орчин Газрын захиалгаар “**СҮХБААТАР АЙМГИЙН АШИГТ УРГАМЛЫН ТАРХАЦ-НӨӨЦ**” ажлыг Шинжлэх Ухааны Академийн Ботаникийн хүрээлэнгээс боловсруулсан судалгааны ажлын аргачлалын дагуу судалгааны баг гүйцэтгэж тайлан, мэдээлэл бүрдүүлэх явдал юм.

### Хоёр. Ажлын хамрах хүрээ, багтаамж

Ажил гүйцэтгэгч Ботаникийн хүрээлэнгийн судлаачдын баг Сүхбаатар аймгийн хэмжээнд нэн ховор, ховор болон ашигт ургамлын тархац нөөцийн судалгааны ажлыг 2014 оны 8-р сараас 11-р сарын 25-ныг хүртэл хийж гүйцэтгэлээ.

Дээрхи судалгааны ажлын хүрээнд дараахь ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Сүхбаатар аймгийн нутагт ойт хээр, хээр, цөлөрхөг хээрийн бүслүүрийн ашиглалтанд өртөмтгий ашигт ургамлын тархац нөөцийг тогтоох судалгаа явуулж, 2600 орчим км замналаар түлхүүр цэгүүдийг сонгож ажиллав. Монгол оронд аймгийн нийт 3127 зүйл (*Urgamal et al.* 2014) гуурст дээд ургамал ургадгаас Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэрт 650 орчим зүйл тархдаг нь нийт зүйлийн 23 орчим хувийг эзэлдэг байна.

Бидний судалгаанд одоогоор ашиглалтанд өртөмхий ашигт 31 овгийн 56 төрлийн 64 зүйл (нэн ховор 1, ховор 11, элбэг 56 зүйл) судалгаанд хамрагдаж 64 ургамлын тархац, 20 гаруй зүйл ургамлын гарц-нөөцийн мэдээ баримтыг цуглуулав. Судалгааны энэхүү мэдээлэл нь дээрх бүс нутагт хийгдэж байгаа нарийвчилсан анхны мэдээ баримт боллоо.

2. Сүхбаатар аймгийн хэмжээнд нэн ховор, ховор болон ашигт ургамлын бүрдэл, ургамалжлын онцлог байдлыг илэрхийлсэн бичиглэл 30 гаруйг хийж гүйцэтгэв.

3. Тус аймгийн хэмжээнд нэн ховор, ховор болон ашигт ургамлын тархацыг илрүүлж, гарц, нөөцийн зураглалыг хийлээ.



4. Сүхбаатар аймгийн хэмжээнд нэн ховор, ховор болон ашигт ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах бодлого боловсруулах түвшинд хэрэглэх зөвлөмжийг боловсруулав.

5. Судалгааны явцад ургамлын 130 гаруй өнгөт фото зураг авч, түүнчлэн тархалтын 134 өнгөт зураг тайланд оруулсан нь ашигт ургамлыг зөв таньж тодорхойлох, мэдээлэлийн эталон сан бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой үнэ цэнэтэй мэдээлэл болов.

#### **Гурав. Гарсан үр дүн**

1. Сүхбаатар аймгийн хэмжээнд нэн ховор, ховор болон ашигт 64 зүйл ургамлын тархац, 20 зүйл ургамлын нөөцийн мэдээллийн сан бий боллоо.

2. Сүхбаатар аймгийн хэмжээнд ашигт ургамлын тархац, нөөцийн судалгааны тайлан, зөвлөмж нь дээрхи бүсийн ургамлыг хамгаалах, нөхөн сэргээх, тогтвортой ашиглах талаар бодлого боловсруулах түвшинд ашиглах боломжтой юм.